

**GOBI**

MONGOLIAN CASHMERE



**ЖИЛИЙН ТАЙЛАН**

**2023**


ГОВЬ  
ХУВЬЦААТ  
КОМПАНИ

## АГУУЛГА

<b>1</b>	<b>МАНАЙ КОМПАНИ</b>	
	Компанийн ерөнхий танилцуулга	07
	Алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, уриа үг	09
	Түүхэн замнал	10
	ТУЗ-ийн даргын мэндчилгээ	12
	Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	14
<b>2</b>	<b>2023 ОНД БИД</b>	
	Бидний амжилт, онцлох үйл явдлууд	18
	2023 оны санхүүгийн үр дүн	25
	Санхүүжилтийн мэдээлэл	28
	Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл	31
<b>3</b>	<b>БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	
	Дотоод зах зээл	37
	Экспортын зах зээл	40
	Гадаад зах зээл	42
	Программ хөгжүүлэлт, цахим шилжилт	46
	Үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн шинэ технологи, бүтээгдэхүүн хөгжүүлэлт	47
	Коллекцууд	49
	Брэндүүд	52
<b>4</b>	<b>ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ</b>	
	Тогтвортой хөгжлийн удирдлага	60
	Байгаль орчин	63
	Нийгэм	75
	Засаглал	87
	Засаглалын бүтэц, үйл ажиллагаа	88
	Засаглалын бодлого	89
	Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө	91
	Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр	94
	Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүн	95
	Хувьцаа эзэмшигчид	96
	Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл	97
	Хувьцаа эзэмшигчдийн хурал	98
	Төлөөлөн удирдах зөвлөл	99
	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан	105
	Дотоод хяналтын тогтолцоо	113
	Компанийн бүтэц	126
	Менежмент багийн удирдлагууд	130
	Хувьцааны арилжааны мэдээлэл	134
	Ногдол ашиг	135
<b>5</b>	<b>ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b>	
	Хараат бус аудиторын тухай мэдээлэл	140
	Говь ХК болон түүний охин компаниудын нэгтгэсэн санхүүгийн тайлан болон хараат бус аудиторын тайлан	141



МАНАЙ КОМПАНИ



## КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

### Компанийн оноосон нэр

“Говь” хувьцаат компани

### Үйл ажиллагааны чиглэл

Ямааны ноолуурт цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах

### Компанийн албан ёсны хаяг

Монгол улс, Улаанбаатар хот-17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК

Шуудангийн хаяг: Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг 36/434, Говь ХК

Утас: (976)-70139977  
Факс: (976)-70143081  
И-мэйл: info@gobi.mn  
Веб сайт: info.gobi.mn  
Фэйсбүүк: GobiCashmere  
Онлайн дэлгүүр:  
Дотоод: gobi.mn  
Гадаад: gobicashmere.com

### Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр

Монголын Хөрөнгийн Бирж

### Компанийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг

780,112,500

### Компанийн удирдлага

ТУЗ-ийн дарга: Дамбын ГЭРЭЛМАА  
Гүйцэтгэх захирал: Цагаачийн БААТАРСАЙХАН

### Үүсгэн байгуулагдсан огноо

1981 оны 9-р сарын 5-ны өдөр

### Ажилтнуудын тоо

1,765

### Үйлдвэрийн хүчин чадал

1,150 тонн түүхий ноолуур боловсруулах  
1,050 тонн ээрмэл утас, 30 тонн нарийн ээрмэл утас хийх  
1,500,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх  
640,000 ширхэг нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх  
162,000 ширхэг оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэх

### Дэлгүүрийн тоо

<b>Дотоод</b>	<b>Гадаад</b>
Улаанбаатар хот 2	Охин компани 5
Дархан хот 1	Салбар дэлгүүр 2
Онлайн дэлгүүр 1	Франчайз дэлгүүр 21
	Онлайн дэлгүүр 13



## АЛСЫН ХАРАА

Амьдралын алхам бүрийг ноолууртай хамт

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Загварлаг, чанартай, нийцэмжит үнэтэй ноолууран хувцсаа дэлхийд таниулж, хүн бүрийг гоёно

## УРИА ҮГ

Ноолууран хувцсыг хүн бүрт

### ҮНЭТ ЗҮЙЛС



#### ХҮНДЭТГЭЛ



Бид олон талт ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, нээлттэй бөгөөд харилцан хүндэтгэлтэйгээр санал бодлоо солилцдог.



#### ГАЛ ЭРМЭЛЗЭЛ & ЧИН СЭТГЭЛ



Бид хийж бүтээх чин сэтгэл, зорилгодоо хүрэх тууштай хүсэл эрмэлзэл дүүрэн хамт олон.



#### ШУДАРГА & ИЛ ТОД БАЙДАЛ



Бид бүх талуудын оролцоог ижил түвшинд чухалчлан, үйл ажиллагааны ил тод байдлыг эрхэмлэдэг.



#### ТӨГӨЛДӨРШИЛ & ХАРИУЦЛАГА



Бид нийгэм, хүрээлэн буй орчин, оролцогч талуудад болон хийсэн үйлдэл, үр дүндээ хариуцлагатай хандаж, тогтвортой хөгжлийн зорилгод тэмүүлж ажилладаг.




#### БҮТЭЭЛЧ БАЙДАЛ



Бид шинэ санаа, бүтээлч өөрчлөлтийг эрэлхийлж, хүлээлтээс давсан үр дүн рүү тасралтгүй тэмүүлдэг.

## ТҮҮХЭН ЗАМНАЛ



1 МАНГАЙ КОМПАНИ

2 2023 ОНД БИД

3 БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГА

4 ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

5 САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Манай компани Монгол Улсын анхны нээлттэй хувьцаат компаниудын нэг бөгөөд Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 жагсаалтад багтдаг компанийн хувьд олон улсын засаглалын сайн туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, тэнцвэртэй, хүчирхэг засаглалын тогтолцоог бий болгож, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж, мэдээллийн ил тод байдлыг хангахыг зорин ажилласаар ирсэн билээ.

Үүний үр дүнд Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтээр 2023 онд Монгол Улсын нээлттэй хувьцаат компаниудыг манлайлан тэргүүн байранд үнэлэгдсэнийг дуулгахад таатай байна.

Өнгөрөгч онд ТУЗ-өөс "Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр" болон "Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө"-г тус тус баталж, компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх, эрх ашгийг нь хангах тал дээр анхаарч ажилласны дүнд манай компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо 3.5%-аар нэмэгдэж 24 мянга болжээ. Бидэнд итгэл хүлээлгэн хөрөнгө оруулж буй хувьцаа эзэмшигчдийн тоо улам өссөөр байгаад баяртай байна.

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд ESG буюу байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын хариуцлага өсөн нэмэгдэж, компаниуд оролцогч талуудын урт хугацааны үнэ цэнэ, тогтвортой өсөлтийг бий болгоход ихээхэн анхаарал хандуулах болсон. Олон улсын зах зээлд танигдаж эхэлсэн манай компанийн хувьд үйл ажиллагааныхаа бүхий л шатанд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг шингээн, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулж, засаглалын тогтолцоогоо улам бэхжүүлэн ажиллахыг зорьж байна.

ТУЗ-өөс 2022 онд баталсан "Тогтвортой хөгжлийн үүрэг амлалт"-ын хүрээнд өнгөрөгч онд компанийн тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудын хэрэгжилтийг хангахад ТУЗ-ийн зүгээс идэвхтэй анхаарч, дэмжин ажилласан бөгөөд ТУЗ-ийн хурлуудаар дамжуулан хэрэгжилтэд тогтмол хяналт тавин, Гүйцэтгэх удирдлагын багийг чиглүүлэн чамгүй ололт амжилттай ажиллалаа.

Үүнээс дурдвал, "Тогтвортой ноолуурын өдөр – 2023" арга хэмжээний үеэр "Усны зохистой хэрэглээг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн шилдэг байгууллага"-аар шалгарсан ба "CSR Awards 2023" арга хэмжээний үеэр бидний 2020 оноос хойш хэрэгжүүлж буй "Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл" нийгмийн хариуцлагын чиглэлийн төслүүдээс шалгарч "Тогтвортой хөгжлийн шилдэг төсөл" шагналыг хүртсэн нь бидний тогтвортой хөгжлийн хүрээнд шат дараатайгаар хэрэгжүүлж буй санаачилгуудын үр нөлөөг онцлон харуулж байгаа гэж бид үзэж байна.

Мөн тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг дэмжих, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор Азийн Хөгжлийн Банктай 30 сая ам.долларын санхүүжилтийн гэрээг амжилттай үзэглэж, эхний санхүүжилтээ хүлээн авсан бөгөөд цаашид тогтвортой хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалтыг тасралтгүй нэмэгдүүлэхээр зорьж байна.

Түүнчлэн өнгөрөгч оны онцлох үйл явдлуудын нэг нь Говь ХК орон нутаг дахь анхны салбар үйлдвэрээ Хэнтий аймагт байгуулан 100 гаруй ажлын байрыг шинээр бий болгосноор үйлдвэрийн хүчин чадлаа нэмэгдүүлээд зогсохгүй хөдөө орон нутгийн хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах эхлэлийг тавилаа.

Говь ХК нь Тогтвортой хөгжлийн бодлогынхоо "Аз жаргалтай ажилтан" зорилтын хүрээнд ажилтнуудын ажил амьдралыг тэнцвэртэй байдлыг хангахаар 2023 онд ажлын уян хатан цагийн системийг оффисын ажилтнуудад, богиносгосон цагийн системийг нярай болон цэцэрлэгийн насны хүүхэдтэй үйлдвэрийн ажилтнуудад хэрэгжүүлж эхэлсэн ба байгууллагын дэргэдэх цэцэрлэгийг зуны улирлын туршид тасралтгүй ажиллуулсан. Мөн бид цаашид ажлын байрны таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, ажилтнуудын сурч хөгжих боломжийг нээж, цалин урамшуулал ба сэтгэл ханамжийг нэмэгдүүлэн байгууллагын соёлыг тасралтгүй сайжруулах болно.

Бидний баялаг бүтээгч ажилтнууд, үнэнч хэрэглэгчид, эрхэм түншүүд, хувьцаа эзэмшигчид болон бүхий л хамтрагч оролцогч талуудынхаа дэмжлэгт гүнээ талархаж байна. Та бүхний оруулж буй хувь нэмэр бидний амжилтын үндэс суурь болдог билээ.

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс та бүхэнд ажлын өндөр амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

Хүндэтгэсэн:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
Удирдахуйн ухааны доктор (Ph.D), профессор Д.ГЭРЭЛМАА

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, бизнесийн түнш, хамтран ажиллагсад та бүхэндээ чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.

“Ноолууран хувцсыг хүн бүрт” уриатай Говь ХК нь үүсгэн байгуулагдаад 43 дахь жилдээ үйл ажиллагаагаа амжилттай явуулж байгаа бөгөөд энэхүү түүхэн хугацаанд байгууллагын маань үе үеийн удирдлага, хамт олны хүчин зүтгэл, хөдөлмөрийн үр дүнд бизнесийн цар хүрээгээ улам бүр өргөжүүлэн тэлж, тасралтгүй хөгжин дэвшсээр байна. Миний бие өдгөө 16 дах жилдээ Говь ХК-ийн хамт олноо удирдан Гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байгаа ба Говь брэндээр дамжуулан Монгол ноолуурыг дэлхийд таниулж олон улсын хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ хүргэхэд чамгүй олон санаачилгуудыг хэрэгжүүлсээр ирсэн билээ.

Говь ХК-ийн хувьд 2023 он ололт амжилтаар дүүрэн жил байлаа. Манай компани өнгөрөгч онд түүхэндээ хамгийн өндөр буюу 255.7 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өмнөх оноос 32%-ийн өсөлттэй байв. Борлуулалтын орлогыг сегментээр нь задлаад үзвэл, дотоод борлуулалт 57.5%, экспортын борлуулалт 23.3%, гадаад борлуулалт 19.2%-ийг тус тус эзэлж байна.

Дотоод зэх зээлийн хувьд Монгол Улсын Засгийн Газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Монгол орныг зорин ирэх жуулчдын тоо эрс нэмэгдсэн ба бид жуулчдын борлуулалтыг дэмжих зорилгоор үйлдвэртэй танилцах аяллыг гадаад хэл дээр зохион байгуулах, аялал жуулчлалын компаниуд ба хөтөч жолооч нартай хамтран ажиллах, салбар дэлгүүрүүдийг уртасгасан цагаар ажиллуулах, гадаад хэлтэй худалдааны зөвлөхүүдийн тоог нэмэгдүүлэх зэрэг санаачилгуудыг гарган ажилласны үр дүнд борлуулалтыг өмнөх оноос 57%-аар нэмэгдүүлж 147 тэрбум төгрөгт хүргэсэн.

Бид экспортын зах зээлд 2021 оноос хойш цөөн бөгөөд чанартай стратегийн харилцагчидтай хамтран ажиллах бодлогыг баримталж ажиллаж байгаа бөгөөд тус бодлогын хүрээнд ашигт ажиллагаа болон үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлж экспортын борлуулалтыг 59.5 тэрбум төгрөгт хүргэж өмнөх оноос 30%-аар өсгөж чадлаа.

Харин гадаад зах зээлийн хувьд дэлхийн геополитикийн хурцадмал байдал болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө байсан хэдий ч бид борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Казахстан Улсад охин компани байгуулж, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Дюссельдорф хотноо шинэ салбар дэлгүүрээ нээсэн. Түүнчлэн Говь брэндийн органик хайлтыг сайжруулахаар SEO компаниудтай хамтран ажилласны дүнд [www.gobicashmere.com](http://www.gobicashmere.com) вебсайтын органик хандалт 38%-аар өссөн. Энэ нь 2019 оноос хойш гадаад зах зээлд хэрэгжүүлж буй бидний маркетинг, брэндингийн үйл ажиллагааны үр дүн эхнээсээ гарч, брэндийн танигдалт нэмэгдэж буйг илтгэж байна.

Бид 2020 оноос хойш компанийн программ хангамж болон удирдлагын системийг хөгжүүлэх цахим шилжилтийг үе шаттайгаар хийж байгаа билээ. Өнгөрөгч онд бизнесийн үйл ажиллагааг автоматжуулж, үйл явцыг хурдлуулах төдийгүй бүтээмжийг нэмэгдүүлэхэд томоохон дэвшил авчрах Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн менежмент буюу Product Lifecycle Management (PLM) систем болон Бэлэн бүтээгдэхүүний бүртгэл тооллогын систем зэрэг үйлдвэрлэлийн шат дамжлага, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн системүүдийг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн. Түүгээр зогсохгүй SAP ERP системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг амжилттай хийж гүйцэтгэлээ.

Мөн тайлант хугацаанд ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцооны стандартын баталгаажуулалтыг авч, 2022 онд баталгаажуулалтаа авсан ISO 14001, ISO 45001 стандартуудын магадлан аудитыг амжилттай хамгаалж, гэрчилгээний хугацааг сунгаснаар Говь ХК нь Нэгдсэн удирдлагын тогтолцоог цогцоор нь хэрэгжүүлэгч компани болж байна.

Дизайн хөгжүүлэлтийн хувьд өнгөрөгч онд бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэгдүүлэн Монгол Улсад анхлан ноолууран гутал үйлдвэрлэж, хэрэглэгчдийн гарт хүргэлээ. Түүнчлэн Ерөнхий дизайнераар Итали Улсын алдарт дизайнер Giorgio Spina ажиллан дэлхийн хэмжээний загварын шоуг Монголдоо амжилттай зохион байгуулж, ноолууран бүтээгдэхүүний загварыг шинэ түвшинд хүргэсэн “The Face” болон Organic “Materia” коллекцуудыг танилцуулсан нь дотоод болон гадаадын хэрэглэгчдэд Говь брэндийг шинэлэг өнгө төрхтэйгөөр таниулж чадсан гэж үзэж байна.

Мөн бид “Аз жаргалтай ажилтан” зорилтынхоо хүрээнд цалин урамшууллаар ноос, ноолуур үйлдвэрлэлийн салбартаа тэргүүлэх бодлогыг баримтлан цалинг үе шаттайгаар нэмэгдүүлсний үр дүнд 2023 онд ажилтнуудын цалинг дунджаар 24% нэмэгдүүлж чадсан бөгөөд ирэх жилүүдэд бид ажилтнуудынхаа ажиллах орчныг сайжруулж, ажил амьдралын тэнцвэртэй байдлыг хангаж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэн байгууллагын соёлоо улам сайжруулахад чиглэсэн ажлуудыг санаачлан хэрэгжүүлэх болно.

Цаашид манай компани зах зээлд тэргүүлэгчийн байр сууриа хадгалж, дэлхийн хэмжээнд үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлж, улс орныхоо эдийн засгийн сэргэлтэд хувь нэмрээ тууштай оруулахад бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажиллахын сацуу нийгэм болоод байгаль орчиндоо ээлтэй тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэгч хариуцлагатай компани байхын төлөө ажиллах болно.

Та бүхэнд эрүүл энхийг хүсэж, цаашдын ажил үйлсэд тань өндрөөс өндөр амжилт хүсэн ерөөе!

Хүндэтгэсэн:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Ц.БААТАРСАЙХАН



CASHMERE  
**BOOTS**



2023 ОНД БИД

2

## БИДНИЙ АМЖИЛТ, ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



### “ТОП-100”-аар шалгарлаа.

Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг таван үзүүлэлтээр үнэлэн шалгаруулдаг “ТОП-100” аж ахуйн нэгжийн шалгаруулалтад Говь ХК нь 21-р байранд орж батламжаа гардан авлаа.



### Төв дэлгүүрийг өргөтгөн, шинэ өнгө төрхтэйгөөр нээлээ.

Үйлдвэрийн дэргэдэх Төв дэлгүүрийн өргөтгөл 679 м2 талбайг шинэчлэн засвар хийж дэлгүүрийн талбайгаа өргөтгөн, уламжлалт монгол гэрийн хэв маягийг орчин цагийн өнгө аястай хослуулан 5-р сарын 25-ны өдөр бүрэн ашиглалтад орууллаа.



### Дэлхийн хэмжээний загварын шоуг Монголдоо зохион байгууллаа.

Говь ХК-ийн Ерөнхий дизайнер Giorgio Spina-гийн анхны коллекц болох THE FACE Pre-Fall 23 болон MATERIA Organic PreFall 23 коллекцийн загварын шоуг дэлхийн хэмжээний өндөр зохион байгуулалттайгаар 6-р сарын 8-ны өдөр амжилттай зохион байгуулав.



### Ноолууран гутал үйлдвэрлэж эхэллээ.

Говь ХК нь 2023 онд загварын нэр төрлийг нэмэгдүүлэн тусгай аргаар боловсруулсан нягт өндөртэй шинэ төрлийн 100% ноолууран Felton материалыг гарган ноолууран бүтээгдэхүүний хөгжлийг нэг шатаар ахиулсан Монголдоо анхдагч ноолууран гутлыг дотоод болон гадаадын зах зээлд хэрэглэгчдэд хүргэсэн. Инноваци шингэсэн тус бүтээгдэхүүнээр Монголын Ноос Ноолуурын Холбооноос “Онцлох Бүтээгдэхүүн-2023” шагнал хүртсэн.



### ISO 9001:2015 олон улсын стандартыг хангаж, гэрчилгээгээ гардан авлаа.

ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцооны стандартын шалгуурыг бүрэн хангаж олон улсын SGS баталгаажуулалтын байгууллагаас 6-р сард гэрчилгээгээ гардан авлаа.



### Герман улсын Дюссельдорф хотноо шинэ салбар дэлгүүрээ нээлээ.

Гадаад зах зээлийн борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх болон олон улсын хэрэглэгчдэдээ илүү ойртох зорилгоор 10-р сард ХБНГУ-ын Дюссельдорф хотод хоёр дахь салбар дэлгүүрээ нээсэн бөгөөд дэлгүүрийн дотоод заслын шийдэлд монгол уламжлалт ахуйн элементүүдийг шингээж өгснөөрөө онцлог боллоо.



### Орон нутаг дахь анхны салбар үйлдвэрээ Хэнтий аймагт нээлээ.

Бид хөдөө орон нутаг дахь анхны салбар үйлдвэрээ 11-р сард Хэнтий аймагт нээж, үйл ажиллагаагаа эхлүүлснээр хөдөө орон нутагт ажлын байрыг бий болгохын зэрэгцээ тогтвор суурьшилтай амьдралын нөхцөл боломжийг бүрдүүлж нийслэл хотыг зорих иргэдийн урсгал багасан, орон нутгийн хөгжил тэлэхийн зэрэгцээ өрхийн орлого нэмэгдэх гээд онцлоод баршгүй олон давуу талууд цогцолсон үйл явдал болж байна.



### “Усны зохистой хэрэглээг нэвтрүүлсэн шилдэг байгууллага”-аар шалгарав.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэргэдэх Монголын Тогтвортой Ноолуурын Платформ болон БОАЖЯ, ХХААХҮЯ-ийн хэрэгжүүлж буй АДАПТ төсөл хамтран Монгол Улсад анх удаа “Тогтвортой ноолуурын өдөр – 2023” арга хэмжээг 11-р сард зохион байгуулсан. Говь ХК нь тус арга хэмжээний үеэр “Усны зохистой хэрэглээг нэвтрүүлсэн шилдэг байгууллага”-аар шалгарав.



### Азийн Хөгжлийн Банкнаас санхүүжилт авлаа.

Манай компани 2019 оноос эхлэн олон улсын зах зээлд үйл ажиллагаагаа эрчимтэй тэлэх зорилтыг тавин ажиллаж байгаа ба бидний зорилт болон тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Азийн Хөгжлийн Банктай 30 сая ам.долларын урт хугацаат эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийн гэрээг амжилттай үзэглэж, эхний санхүүжилтээ хүлээн авсан.



### Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл “CSR Sustainability” буюу “Тогтвортой хөгжлийн шилдэг төсөл”-өөр шалгарлаа.

Монгол дахь Америкийн Худалдааны Танхим “Амчам Монгол ТББ”-ийн “CSR Awards 2023” арга хэмжээгээр манай компанийн 2020 оноос хойш хэрэгжүүлж буй “Тогтвортой ноолуур, гурван талт төсөл” тогтвортой хөгжлийн шилдэг төслөөр шалгарч Говь ХК “CSR Sustainability” шагналыг хүртлээ.




### Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтээр тэргүүлээ.


“Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2023 оны хагас жил болон жилийн эцсээр 2 удаа үнэлсэн бөгөөд Говь ХК нь Монгол Улсын нээлттэй хувьцаат компаниудыг манлайлан тэргүүн байранд дараалан үнэлэгдлээ.

## БОРЛУУЛАЛТ

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, СЕГМЕНТЭЭР /тэрбум төгрөг, %/




БОРЛУУЛАЛТ, ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/




## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2007 ОНООС ХОЙШ НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 156.1 тэрбум төгрөг



2007 оны хувьчлалаас хойш өссөн дүнгээрээ нийт 156.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Үүнээс 2019 онд 60.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 23.2 тэрбум нь Говь ХК-ийн барилга байгууламж, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгө оруулалтад зарцуулагдсан бол үлдсэн 37.3 тэрбум төгрөг нь Гоёо ХХК-ийг нэгтгэсний дүнд үүссэн өсөлт байв.

2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ




2023 онд нийт 4.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 30% буюу 1.4 тэрбум төгрөг нь барилга байгууламж, 8% буюу 408 сая төгрөг нь тоног төхөөрөмж, 36% буюу 1.7 тэрбум төгрөг нь тавилга эд хогшил болон бусад биет хөрөнгө оруулалт, 26% буюу 1.2 тэрбум төгрөг нь биет бус хөрөнгө оруулалтад зарцуулсан байна.

## ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ, ШИМТГЭЛ

Говь ХК нь 2007 оноос хойш зөвхөн Монголын татварын албанд нийт 233.3 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна. Үүнээс 2023 онд 33.4 тэрбум төгрөгийн татвар хураамж, шимтгэлийг улсын төсөвт төлсөн.

### ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР ХУРААМЖ, ШИМТГЭЛ



## ГОВЬ ХК 2023 ОНД

/2022 оны гүйцэтгэлтэй харьцуулав/

↑ 32%

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО  
255.7 тэрбум төгрөг

↑ 3%

ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)  
(6.8) тэрбум төгрөг

↑ 57%

ДОТООД БОРЛУУЛАЛТ  
147.0 тэрбум төгрөг

↑ 30%

ЭКСПОРТЫН БОРЛУУЛАЛТ  
59.5 тэрбум төгрөг

↓ 10%

ГАДААД БОРЛУУЛАЛТ  
49.2 тэрбум төгрөг

↓ 4%

МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ  
27.8 тэрбум төгрөг

↑ 23%

ҮЙЛДВЭРЛЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН  
1.0 сая ширхэг

↑ 14%

БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН  
1.2 сая ширхэг

↑ 10%

КОМПАНИЙН ҮНЭЛГЭЭ  
213.4 тэрбум төгрөг

↑ 51%

ТӨСӨВТ ТӨЛСӨН ТАТВАР, ШИМТГЭЛ  
33.4 тэрбум төгрөг

↑ 60%



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ  
4.8 тэрбум төгрөг

↑ 6%



ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ  
237.3 тэрбум төгрөг

## 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮН


ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2022 он	2023 он	Өөрчлөлт	
		Гүйцэтгэл 2022	Гүйцэтгэл 2023	тоо	хувь
<b>БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО</b>	сая.төг	193,428	<b>255,651</b>	62,223	32%
Дотоод борлуулалт	сая.төг	93,500	<b>146,997</b>	53,496	57%
Экспортын борлуулалт	сая.төг	45,586	<b>59,485</b>	13,899	30%
Гадаад борлуулалт	сая.төг	54,342	<b>49,169</b>	(5,173)	-10%
Борлуулсан бүтээгдэхүүний тоо/ш	мян.ш	1,012	<b>1,153</b>	140	14%
<b>БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ</b>	сая.төг	97,767	<b>131,011</b>	33,245	34%
<b>НИЙТ АШИГ</b>	сая.төг	95,661	<b>124,639</b>	28,978	30%
Бохир ашгийн хувь	хувь	49%	<b>49%</b>	-1%	-1%
Үйл ажиллагааны зардал	сая.төг	100,815	<b>124,142</b>	23,327	23%
Маркетингийн зардал	сая.төг	28,876	<b>27,803</b>	(1,074)	-4%
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ</b>	сая.төг	(5,155)	<b>497</b>	5,652	110%
Үйл ажиллагааны ашгийн хувь	хувь	-3%	<b>0%</b>	3%	107%
Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	4,842	<b>474</b>	(4,368)	-90%
Татварын өмнөх ашиг	сая.төг	(9,997)	<b>23</b>	10,020	100%
<b>ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ</b>	сая.төг	(6,998)	<b>(6,768)</b>	230	3%
Цэвэр ашгийн хувь	хувь	-4%	<b>-3%</b>	1%	27%
Нийт үйл ажиллагааны зардал	сая.төг	198,582	<b>255,154</b>	56,571	28%
<b>ҮЙЛДВЭРЛЭЛ</b>	мян.ш	848	<b>1,040</b>	192	23%
Сүлжмэл бүтээгдэхүүн	мян.ш	674	<b>742</b>	68	10%
Нэхмэл бүтээгдэхүүн	мян.ш	136	<b>264</b>	128	94%
Оёмол бүтээгдэхүүн	мян.ш	38	<b>34</b>	(3)	-8%
Пальто	мян.ш	16	<b>18</b>	1	8%
Пиджак	мян.ш	6	<b>5</b>	(1)	-17%
Ээрмэл утас	тонн	168	<b>273</b>	105	62%
<b>АЖИЛТНУУДЫН ТОО</b>	хүн	1,548	<b>1,765</b>	217	14%
Нэг ажилтанд ногдох орлого	мян.төг	124,953	<b>144,844</b>	19,891	16%
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	сая.төг	3,009	<b>4,809</b>	1,800	60%
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	сая.төг	292,284	<b>311,950</b>	19,666	7%
Банкны зээл	сая.төг	223,448	<b>237,319</b>	13,871	6%
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	сая.төг	298,112	<b>311,784</b>	13,671	5%
Бараа материал	сая.төг	128,809	<b>142,521</b>	13,713	11%




2023 оны ашигт ажиллагааны гүйцэтгэлийг 2022 онтой харьцуулахад борлуулалтын орлого 255.7 тэрбум төгрөгт хүрч 32% өссөн. Хүү төлөх чадварын харьцаа 0.2 пунктээр сайжирсан.



2023 онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо 23%, борлуулсан бүтээгдэхүүний тоо 14%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүнийг нэр төрлөөр нь задалбал сүлжмэл бүтээгдэхүүн 70%, оёмол бүтээгдэхүүн 3%-ийг тус тус эзэлж байна. Нэхмэл бүтээгдэхүүний хувьд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 26%, борлуулсан бүтээгдэхүүний 27%-ийг эзэлж байгаа нь өмнөх оноос 5 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.




2023 онд маркетингийн зардал 27.8 тэрбум төгрөг болж өмнөх оноос 4% буурсан үзүүлэлттэй байна. Энэ оны хувьд нийт маркетингийн зардлын 93% буюу 25.9 тэрбум төгрөгийг гадаад зах зээлийг идэвхжүүлэх маркетингийн зардалд зарцуулж, гадаад зах зээлийн маркетингийн зардлыг өмнөх оноос 10% бууруулсан. Компанийн 2023 оны цэвэр алдагдал 6.8 тэрбум төгрөг ба тайлант үеийн алдагдал нь тайлант үеийн эцэс дэх өөрийн хөрөнгийн дүнгийн 30 хувиас хэтэрсэн байна.



2023 онд түүхий эдийн татан авалтыг хамгийн бага түвшинд хийж, нөөцөө бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр бараа материалын эргэц хоног 2022 оноос 24%-р буурч 378 хоног болж сайжирсан.

## МӨНГӨН УРСГАЛ



2023 онд үйл ажиллагаанаас нийт 265.9 тэрбум төгрөг орсон ба 2022 онтой харьцуулахад 26% өссөн. Харин гарах мөнгөн урсгалын хувьд нийт 284.9 тэрбум төгрөг зарцуулсан ба үүнээс 223.8 тэрбум төгрөгийг үйл ажиллагааны зардалд, 33.4 тэрбум төгрөгийг татварын зардалд, санхүүжилтийн зардалд 27.7 тэрбум төгрөг тус тус төлсөн. 2023 онд 4.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бол хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ 3.9 тэрбум төгрөг байна. Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ 23.3 тэрбум төгрөг байна.

## САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

/ мянган төгрөг/

САНХҮҮЖҮҮЛЭГЧИЙН НЭР	Валют	2023 Нэрлэсэн хүү (2022)	Дуусах хугацаа /он/	2022.12.31			2023.12.31				
				Гадаад валют /мянган/	Дансны үнэ	Хүүгийн өглөг	Гадаад валют /мянган/	Нэрлэсэн үнэ	Бодит үнэ цэнийн хэмжилтийн нөлөө	Дансны үнэ	Хүүгийн өглөг
1. Голомт банк (Хөнгөлөлттэй зээл) (i)	MNT	11.00%	2025	-	20,000,000	54,247	-	13,333,333	209,569	13,123,764	36,164
2. Голомт банк (Зээлийн шугам) (I)	MNT	15.65%	2024	-	-	12,012	-	48,950,000	-	48,950,000	83,760
3. Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 1А) (ii)	USD	6.79%	2024	1,818	6,262,910	204,356	-	-	-	-	-
4. Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 1Б) (ii)	USD	7.49%	2024	2,727	9,394,364	338,137	-	-	-	-	-
5. Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (Транч 2) (ii)	USD	6.93%	2024	3,273	11,273,235	375,428	-	-	-	-	-
6. Хаан банк (Зээлийн шугам) (iii)	MNT	12.60%	2025	-	-	-	-	6,500,000	-	6,500,000	8,334
7. Хаан банк (Хөнгөлөлттэй зээл) (iii)	MNT	3.00%	2024	-	10,000,000	21,370	-	4,202,775	33,280	4,169,495	8,982
8. Хаан банк (Хөнгөлөлттэй зээл) (iii)	MNT	5.00%	2024	-	-	-	-	10,000,000	247,199	9,752,801	35,616
9. Монгол Улсын Хөгжлийн Банк (iv)	MNT	16.34%	2023	-	42,900,000	255,754	-	-	-	-	-
10. Монгол Улсын Хөгжлийн Банк (iv)	MNT	16.34%	2023	-	33,333,333	113,424	-	-	-	-	-
11. Хас банк (v)	MNT	13.20% -14.40%	2024	-	9,566,000	201,904	-	-	-	-	-
12. Хас банк (v)	MNT	5.00%	2023	-	-	-	-	16,666,667	238,441	16,428,226	68,493
13. Ариг банк (vi)	MNT	5.00%	2024	-	-	-	-	14,500,000	450,200	14,049,800	59,589
14. Азийн хөгжлийн банк (АХБ) (vii)	USD	3.89%+ SOFR	2026	-	-	-	12,000	40,928,280	-	40,928,280	104,954
15. Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (viii)	EUR	4.25%	2027	8,000	29,352,160	162,864	8,000	30,333,280	-	30,333,280	1,475,377
16. Олон Улсын Хөрөнгө Оруулалтын банк (viii)	EUR	5.25%	2027	14,000	51,366,280	352,073	14,000	53,083,240	-	53,083,240	3,189,418
<b>Нийт зээлийн дүн</b>					<b>223,448,282</b>	<b>2,091,569</b>		<b>238,497,575</b>	<b>1,178,689</b>	<b>237,318,886</b>	<b>5,070,687</b>

Монголбанкны ханш /төгрөг/

	2022.12.31	2023.12.31
USD	3,444.60	3,410.69
EUR	3,669.02	3,791.6

## ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

/мянган төгрөг/

Огноо	Гэрээ хэлцлийн утга	Үнийн дүн	Гэрээний нөгөө тал	Гэрээний нөхцөл болзол	Эхлэх огноо	Дуусах огноо	Хэлцэл баталсан
2023.04.14	Хас банкнаас зээл авах	25,000,000	Хас банк	Ноолуур бэлтгэлийн хүүгийн хөнгөлөлттэй зээл	2023.04.14	2024.04.01	ТУЗ-ийн тогтоол №13
2023.05.26	Ариг банкнаас зээл авах	14,500,000	Ариг банк	Ноолуур бэлтгэлийн хүүгийн хөнгөлөлттэй зээл	2023.05.29	2024.05.30	ТУЗ-ийн тогтоол №18

## СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Огноо	Гэрээ хэлцлийн утга	Үнийн дүн	Гэрээний нөгөө тал	Гэрээний нөхцөл болзол	Эхлэх огноо	Дуусах огноо	Хэлцэл баталсан
2023.06.16	Хаан банкны зээлийн эрх нээх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах	10.0 тэрбум төгрөг	Хаан банк	Ноолуур бэлтгэлийн хүүгийн хөнгөлөлттэй зээл	2023.06.28	2024.06.05	ТУЗ-ийн тогтоол №20
2023.09.22	Гэрээ байгуулах зөвшөөрөл олгох	400.0 мянган ам.доллар	Говь Кашмер Казахстан (охин компани)	Худалдах, худалдан авах гэрээ байгуулах	2023.09.26	2023.12.31	ТУЗ-ийн тогтоол №33
2023.11.20	Үл хөдлөх хөрөнгө борлуулах эрх олгох тухай	1.4 тэрбум төгрөг	Улаанбаатар Принт ХХК	Үл хөдлөх хөрөнгө борлуулах	2023.11.20	2023.11.20	ТУЗ-ийн тогтоол №37
2023.12.22	Харилцах дансны нөхцөл өөрчлөх тухай	-	Хаан банк	Харилцах дансны нөхцөлийг "Байгууллагын шаталсан хүүт харилцах данс"-ны нөхцөл болгон өөрчлөх	2023.05.17	-	ТУЗ-ийн тогтоол №40

## Сонирхлын зөрчилтэй болон холбоотой талуудтай хийх хэлцэлд зөвшөөрөл олгох, хяналт тавих процесс

Говь ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Таван Богд Группийн толгой компани болох Таван Богд Трейд ХХК\* болон түүний хамаарал бүхий компаниудтай хийсэн ажил гүйлгээг сонирхлын зөрчилтэй буюу холбоотой талуудтай хийсэн хэлцэлд тооцсон болно.

Жил бүрийн эхэнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд нь тухайн жилд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсөн этгээдүүдийн жагсаалтыг баталдаг бөгөөд жилийн эцэст компанийн Гүйцэтгэх удирдлагын зүгээс Төлөөлөн удирдах зөвлөлд сонирхлын зөрчилтэй этгээдүүдтэй хийгдсэн хэлцлийн тайлангаа тавьж, ТУЗ-ийн Эрсдэл, аудитын хороо болон хараат бус гишүүд тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг.

2023 оны хувьд 2023.02.03-ны ТУЗ-ийн №03 тоот тогтоолоор холбоотой талуудын жагсаалтыг баталж, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах зөвшөөрлийг олгосон бөгөөд 2024.01.26-ны ТУЗ-ийн хурлаар тус тогтоолын хэрэгжилттэй танилцан, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний гүйцэтгэлд хяналт тавьсан.

Говь ХК-ийн нэгдмэл сонирхолтой хуулийн этгээдүүд болон эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг энэхүү тайлангийн 97-р хуудаснаас харж танилцах боломжтой.

\*Таван Богд Трейд ХХК нь 2024 оны 1-р сараас Таван Богд Холдингс ХХК болгон нэрээ өөрчилсөн болно.



**1. 2023 оны холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл /мянган төгрөг/**

**1.1 Холбоотой талуудын үлдэгдэл**

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудын үлдэгдэл дараах байдалтай байна:

	2022	2023
<b>Холбоотой талаас авах авлага</b>		
Бусад холбоотой талууд	17,222	<b>129,632</b>
<b>Холбоотой талд өгөх өглөг /Богино хугацаат/</b>		
Дээд шатны хянагч этгээд	-	<b>13,642,760</b>
Зэргэлдээ охин компаниуд	42,268	<b>10,630,000</b>
Бусад холбоотой талууд	5,315	<b>703</b>
<b>Холбоотой талд өгөх өглөг /Урт хугацаат/</b>		
Дээд шатны хянагч этгээд	30,980,732	<b>17,032,986</b>
<b>Холбоотой талаас авсан зээл</b>		
Бусад холбоотой талууд	10,025,578	<b>20,475,228</b>

Холбоотой талуудын дансны үлдэгдэлд барьцаа, найдваргүй өрийн сан байхгүй.

Холбоотой талд өгөх урт хугацаат өглөг нь Таван Богд Трейд ХХК-аас Гоёо ХХК-ийн хувьцааг зээлээр худалдан авсантай холбоотой. Тус гэрээнд аливаа хөрөнгийг барьцаалаагүй.

Холбоотой талуудын дансны үлдэгдэл нь барьцаагүй ба найдваргүй авлагын сан байгуулаагүй.

**1.2 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ**

Дараах ажил гүйлгээг Группийн дээд шатны хянагч компани болох Таван Богд Трейд ХХК-тай хийсэн байна:

	2022	2023
Дээд шатны хянагч компаниас авсан урьдчилгаа	-	<b>200,750,000</b>
Дээд шатны хянагч компаниас авсан урьдчилгааны төлбөр	-	<b>200,750,000</b>
Дээд шатны хянагч компанид өгсөн урьдчилгаа		<b>18,950,000</b>
Дээд шатны хянагч компанид өгсөн урьдчилгааны төлбөр		<b>18,950,000</b>
Дээд шатны хянагч компаниас авсан худалдан авалт	1,356,559	<b>1,375,508</b>
Дээд шатны хянагч компанид хийсэн борлуулалт	7,789	<b>33,051</b>
Дээд шатны хянагч компаниас авсан түрээсийн орлого	22,090	-
Дээд шатны хянагч компаниас авсан хүүгийн орлого		<b>195,185</b>
Дээд шатны хянагч компанид төлөх хүүгийн зардал	2,219,369	<b>5,816,451</b>
Дээд шатны хянагч компанид төлсөн хүүгийн зардал	2,219,369	<b>5,816,451</b>

Дараах ажил гүйлгээг Группийн нэгдсэн хяналтад байдаг бусад холбоотой талуудтай хийсэн байна:

	2022	2023
Бусад холбогдох этгээдээс авсан санхүүжилт	105,506,586	<b>252,920,000</b>
Бусад холбогдох этгээдээс авсан санхүүжилтийн эргэн төлөлт	105,506,586	<b>242,290,000</b>
Бусад холбоотой талуудаас авсан худалдан авалт	1,202,395	<b>1,776,029</b>
Бусад холбоотой талаас авсан худалдан авалт	28,918	<b>25,932</b>
Бусад холбоотой талд хийсэн борлуулалт	134,599	<b>251,554</b>
Бусад холбоотой талаас авсан түрээсийн орлого	347,349	<b>292,062</b>
Бусад холбоотой талд төлөх хүүгийн зардал	853,494	<b>2,226,785</b>
Бусад холбоотой талд төлсөн хүүгийн зардал	853,494	<b>2,226,785</b>

Дараах ажил гүйлгээг дээд шатны хянагч компанийн хараат компани болох Хаан Банктай хийсэн байна.


	2022	2023
Хаан банкнаас авсан санхүүжилт	19,310,000	<b>81,700,000</b>
Хаан банкнаас авсан санхүүжилтийн эргэн төлөлт	9,310,000	<b>70,997,225</b>
Хаан банканд хийсэн борлуулалт	22,002	<b>138,672</b>
Хаан банкнаас худалдан авалт хийсэн	1,302,303	-
Хаан банкинд төлөх хүүгийн зардал	194,904	<b>555,651</b>
Хаан банкинд хүүгийн төлбөр төлөх	524,089	<b>1,027,028</b>

Бүх холбоотой талын гүйлгээ нь харилцан тохиролцсон нөхцөлөөр хийгдсэн.

**1.3 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний харьцуулалт**

САНХҮҮЖИЛТИЙН ЗАРДАЛ	2022	2023
Нийт санхүүжилтийн зардал	26,000,427	<b>31,150,837</b>
Холбоотой талаас авсан санхүүжилтийн зардал	3,267,767	<b>8,598,888</b>
Эзлэх хувь /холбоотой тал/	13%	<b>28%</b>

Нийт санхүүжилтийн зардал




Говь ХК нь 2023 онд холбоотой талын санхүүжилтийн зардалд 8,598,888 мянган төгрөг төлсөн нь нийт санхүүжилтийн зардлын 13%-ийг эзэлж байна. Холбоотой талаас авсан санхүүжилтийн зардлын дундаж төгрөгийн хүү нь 16.1%, ам.долларын 7.8% байна.


Жич: Холбоотой тал нь олгосон санхүүжилтэд санхүүгийн харьцаа болон барьцаа хөрөнгө шаарддаггүй.

ХУДАЛДАН АВАЛТ	2022	2023
Нийт худалдан авалт	60,911,143	<b>102,285,245</b>
Гадаадын худалдан авалт	10,241,714	<b>22,143,070</b>
Дотоодын худалдан авалт	50,669,429	<b>80,142,175</b>
Холбоотой талаас авсан худалдан авалт	2,811,030	<b>3,040,428</b>
Эзлэх хувь /нийт худалдан авалтад холбоотой талын эзлэх хувь/	4.6%	<b>3.0%</b>
Эзлэх хувь /дотоодын худалдан авалтад холбоотой талын эзлэх хувь/	5.5%	<b>3.8%</b>

Нийт худалдан авалт



Дотоодын худалдан авалт



Говь ХК нь 2023 онд холбоотой талаас авсан худалдан авалтын дүн 3,040,428 мянган төгрөг буюу нийт худалдан авалтад эзлэх хувь 3.0% байна. /2022 онд 4.6% байсан./

Жич: Бүх холбоотой талын гүйлгээ нь Говь ХК-ийн "Худалдан авалтын бодлого", "Захиалга хүлээн авах, худалдан авах, хүлээлгэн өгөх журам", "Ажил үйлчилгээ худалдан авах журам", "Сонгон шалгаруулах хорооны журам"-ын дагуу үнийн харьцуулалт судалгааг хийн, сонгон шалгаруулалтын хороогоор орсны үндсэн дээр зах зээлийн үнээр хийгдсэн бөгөөд харилцан давуу байдлыг олгоогүй болно.




БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3


## ДОТООД ЗАХ ЗЭЭЛ

2023 онд дотоод зах зээл 147 тэрбум төгрөгийн борлуулалттай ажиллаж өмнөх оноос 57%-ийн өсөлт үзүүлэв.

Мөн дотоод зах зээлд нийт 640 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх онтой харьцуулахад 36%-ийн өсөлттэй байв.




ДОТООД ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ



Говь ХК нь 2023 оны байдлаар дотоодын зах зээлийн 66%-ийг эзэлж байна.

БОРЛУУЛАЛТЫН БҮТЭЦ



Борлуулалтын бүтцийн хувьд дотоодын нийт борлуулалтын 52%-ийг жуулчдын борлуулалт эзэлж байна. Харин худалдан авагчдын сагсны дундаж худалдан авалт энэ онд 536 мянган төгрөг болж өмнөх огноос 26% нэмэгдсэн байна.

↑114%

МОНГОЛ УЛСАД ИРСЭН  
НИЙТ ЖУУЛЧИД  
651 мянган хүн

↑117%

ГОВЬ БРЭНДИЙН ДЭЛГҮҮРЭЭС  
ХУДАЛДАН АВАЛТ ХИЙСЭН ЖУУЛЧИД  
153 мянган хүн

↑155%

ЖУУЛЧДЫН ХУДАЛДАН  
АВАЛТЫН ДҮН  
76.9 тэрбум төгрөг

2023 онд Монгол улсад зочилсон нийт жуулчдын тоо өмнөх оноос 114% өсч 651 мянгад хүрсэн нь Монгол улсын хувьд түүхэн дээд үзүүлэлт байлаа. Үүнийг дагаад Говь ХК-иас бүтээгдэхүүн худалдан авсан гадаад жуулчдын тоо 117% өсч 153 мянгад хүрсэн ба Монгол улсад зочилсон жуулчдын 4 хүн тутмын нэг нь Говь брэндийн дэлгүүрээр үйлчлүүлсэн.

Улмаар жуулчдын худалдан авалтын дүн өмнөх оноос 155% өсч 76.9 тэрбум төгрөгт хүрсэн нь дотоодын нийт борлуулалтын өсөлт 57%-д хүрэхэд нөлөөлсөн бөгөөд гадаадаас Монгол улсад ирж буй жуулчдын тоо компанийн борлуулалтад шууд нөлөөлдөг гэдгийг харуулж байна.

Манай улс 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарлаж, 2024 онд 1 сая жуулчин хүлээн авах зорилт дэвшүүлээд байгаа тул аялал жуулчлалын салбарын хөгжил, өсөлт нь Говь ХК төдийгүй дотоодын ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд борлуулалтаа өсгөхөд маш том түлхэц болно. Говь ХК-ийн хувьд ч гэсэн энэхүү боломжийг ашиглан жуулчдыг татах, тав тухтай үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, бүтээгдэхүүний сонголтыг нийцэмжтэй байлгах, үйлчилгээний чанар стандартаа улам сайжруулахад анхаарч ажиллахаар төлөвлөж байна.

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



### Төв дэлгүүрийн шинэчлэлт

Үйлдвэрийн дэргэдэх Төв дэлгүүрийн өргөтгөл талбайг дахин шинэчилж уламжлалт өнгө төрхийг орчин үеийн хэв маягтай хослуулж ашиглалтад оруулсан. Шинэчлэн засварласан хэсэгт Брэндийн түүхийг өгүүлсэн ханыг бий болгосон нь хэрэглэгчдэд хүрсэн ба илүү тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор кофе шоп нээн ажиллуулж байна.



### Giorgio Spina загварын шоу

Ерөнхий дизайнер Giorgio Spina анхны "THE FACE" Pre-Fall 23 болон MATERIA Organic Pre-Fall 23 коллекцийн загварын шоуг Чойжин ламын сүм музейд шинэлэг хэлбэрээр зохион байгуулж Монголд загварын шоуны шинэ стандартыг тогтоосон.



### "Тэргүүлэгч цэцэг яргуй" коллекц

Төрийн соёрхолт С.Саранцацралт зураачтай хамтран "Тэргүүлэгч цэцэг яргуй" цагаан сарын коллекцийг амжилттай гаргасан нь хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн өндөр үнэлгээг авсан.



### Gobi Experience төсөл

Gobi experience төслийг эхлүүлж жүжигчин П.Эрдэнэзаантай хамтран контент хийсэн нь хэрэглэгчдэд бүтээгдэхүүн бүтэх түүх, үнэ цэнийг эергээр хүргэсэн. Мөн хөдөлмөрийн зах зээлд компанийг сурталчлан таниулж чадсан. Мөн энэхүү төслийн хүрээнд хэвлэл мэдээллийн 9 компанийн 20 гаруй ажилтнуудыг урьж компанийн үйл ажиллагаа болон үйлдвэртэй танилцуулав.




### Мэргэжлийн стилистийн зөвлөх үйлчилгээ

Галлериа салбар болон Төв дэлгүүр дээр мэргэжлийн стилистийн зөвлөх үйлчилгээг шинээр нэвтрүүлэн хэрэглэгчдэд стилистийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн. Энэ нь өөрийн загварын хэв маяг, хувцаслалтын шинэлэг шийдлийг эрэлхийлж байгаа хэрэглэгчдийг сонголт хийхэд туслахаас гадна борлуулалтыг дэмжих нэгэн хөшүүрэг болж байна.



## ЭКСПОРТЫН ЗАХ ЗЭЭЛ



Экспортын зах зээлийн хувьд манай компани цөөн, чанартай стратегийн харилцагчидтай хамтран ажиллах бодлогыг баримталж байгаа бөгөөд 2023 онд нийт 18 улсын 51 харилцагчид 59.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн буюу өмнөх оноос 30%-аар өссөн үзүүлэлттэй байна. Мөн нийт 352 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх онтой харьцуулахад 13%-ийн өсөлттэй байв.



2023 оны сүүлийн байдлаар 7 улсын 20 хотод 21 франчайз дэлгүүртэй үйл ажиллагаа явуулж байна.

### ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



1-р сард Франц улсын Парис хотод харилцагч нартай бизнес уулзалтууд хийж, шинэ коллекцийн танилцуулгаа хийсэн. Ийнхүү харилцагчидтай биечлэн уулзаж харилцагчийн үйл ажиллагаатай нь дэлгэрэнгүй танилцсанаар итгэлцэл, хамтын ажиллагаа сайжирч борлуулалтын өсөлтөд эергээр нөлөөлсөн.



БНСУ-ын Lotte Home Shopping сувгаар Goyo брэндээр бүтээгдэхүүнээ борлуулж эхэлсэн. Ингэснээр Солонгос улс дахь хэрэглэгчдэд илүү ойртохоос гадна брэнд танигдалт нэмэгдэж байна.



## ГАДААД ЗАХ ЗЭЭЛ

Говь ХК нь 2019 оноос хойш гадаад борлуулалтын сувгаа хөгжүүлэн Говь брэндийн бүтээгдэхүүнийг онлайн сувгаар болон нэрийн дэлгүүрээрээ дамжуулан олон улсын зах зээлд борлуулан Монгол ноолуурыг дэлхийд таниулахаар зорин ажиллаж байна.

2023 онд гадаад борлуулалтын зорилтот зах зээлүүд болох Европын Холбоо, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс гэсэн 3 бүсэд төвлөрөн дэлхийн өнцөг булан бүр дэх эцсийн хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ борлуулж, дэлхийн томоохон компаниудтай хамтран ажиллалаа.

Мөн Говь брэндийн онлайн дэлгүүрийн тоо 2022 онд 5 байсныг 2023 онд 13 болгон тухайн улсын хэл болгон дээр вэбсайтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж, вэбсайтын дизайн, идэвхжүүлэлт болон бүтээгдэхүүний зураг авалтаа сайжруулсан бөгөөд Zalando, Tmall, JD, Taobao зэрэг платформуудаар дамжуулан борлуулалт хийж байна.

Мөн нэрийн дэлгүүрийн тоогоо шат дараатайгаар нэмэгдүүлэх зорилгоор Герман улсын Берлин хотоос гадна 2023 оны 10-р сард Дюссельдорф хотод салбар дэлгүүрээ шинээр нээн үйл ажиллагаагаа амжилттай өргөжүүлэн тэлсээр байна.



### ВЕБСАЙТ

- | Европ                       | Олон улс   |
|-----------------------------|------------|
| 1. www.gobicashmere.com     | Олон улс   |
| 2. www.gobicashmere.com/de  | Герман     |
| 3. www.gobicashmere.com/fr  | Франц      |
| 4. www.gobicashmere.com/dk  | Дани       |
| 5. www.gobicashmere.com/se  | Швед       |
| 6. www.gobicashmere.com/it  | Итали      |
| 7. www.gobicashmere.com/pl  | Польш      |
| 8. www.gobicashmere.com/es  | Испани     |
| 9. www.gobicashmere.com/cz  | Чех        |
| 10. www.gobicashmere.com/fi | Финлянд    |
| 11. www.gobicashmere.com/nl | Нидерланд  |
| Хойд Америк                 |            |
| 12. www.gobicashmere.com/us | АНУ        |
| Их Британи                  |            |
| 13. www.gobicashmere.com/uk | Их Британи |

### ПЛАТФОРМ

- | Европ                                     |  |
|---|--|
| 1. Zalando                                |  |
| /Герман, Австри, Франц, Шведийн зах зээл/ |  |
| Хятад                                     |  |
| 1. Tmall                                  |  |
| 2. JD                                     |  |
| 3. Taobao                                 |  |

### САЛБАР ДЭЛГҮҮР

- |                                |
|--------------------------------|
| 1. Берлин хот, Герман Улс      |
| 2. Дюссельдорф хот, Герман Улс |

## ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ЗАХ ЗЭЭЛ	CTR			CR			CPA		
	2022	2023	Өөрчлөлт %	2022	2023	Өөрчлөлт %	2022	2023	Өөрчлөлт %
Европ, Хойд Америк, Их Британи	1.36%	<b>1.23%</b>	-10%	1.64%	<b>2.24%</b>	267%	\$65.45	<b>\$65.15</b>	0%
Бүгд Найрамдах Хятад Ард Улс	3.30%	<b>2.68%</b>	-19%	0.69%	<b>0.70%</b>	2%	¥190	<b>¥185.1</b>	-3%

Үзүүлэлтүүдийн тайлбар

### CTR /Click through rate/

- Нийт сурталчилгаа харсан тооноос хэдэн хувь нь click буюу үйлдэл хийснийг илэрхийлэх хувь

### CR /Conversion rate/

- Нийт веб рүү зочилсон зочлолтын хэдэн хувь нь худалдан авалт хийж буйг илэрхийлэх хувь

### CPA /Cost per acquisition/

- Нэг захиалга хийлгэхэд гаргаж буй маркетингийн зардал

ЗАХ ЗЭЭЛ	Захиалгын тоо /мянган ширхэг/			Борлуулсан бүтээгдэхүүн /мянган ширхэг/			Борлуулалтын орлого /тэрбум төгрөг/		
	2022	2023	Өөрчлөлт %	2022	2023	Өөрчлөлт %	2022	2023	Өөрчлөлт %
Европ	69.0	<b>48.1</b>	-30%	127.3	<b>79.4</b>	-38%	32.6	<b>26.8</b>	-18%
Их Британи	0.1	<b>6.5</b>	4977%	7.5	<b>8.6</b>	15%	1.9	<b>2.9</b>	52%
Хойд Америк	26.2	<b>25.0</b>	-5%	51.4	<b>42.3</b>	-18%	13.7	<b>13.5</b>	-2%
Хятад	20.3	<b>20.8</b>	3%	25.8	<b>23.7</b>	-8%	6.1	<b>6.0</b>	-3%
<b>Нийт</b>	<b>115.6</b>	<b>100.4</b>	<b>-13%</b>	<b>212.0</b>	<b>154.0</b>	<b>-27%</b>	<b>54.3</b>	<b>49.2</b>	<b>-10%</b>

2023 онд гадаад зах зээл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад захиалгын тоо 13%-иар, борлуулалтын тоо ширхэг 27%-иар, мөнгөн дүн 10%-иар буурсан байна.

БОРЛУУЛАЛТЫН СУВАГ	Борлуулалт/сая төгрөг/		Өөрчлөлт %	Борлуулалтад эзлэх %
	2022	2023		
Вебсайт	27,400	<b>21,208</b>	-23%	79%
Zalando	1,089	<b>1,654</b>	52%	6%
Салбар дэлгүүр	4,065	<b>3,894</b>	-4%	15%
<b>НИЙТ</b>	<b>32,554</b>	<b>26,756</b>	<b>-18%</b>	<b>100%</b>

Гадаад борлуулалтын гол зах зээл болох Европын зах зээлийн борлуулалтыг сувгаар нь задлаад үзвэл вебсайтаар хийсэн онлайн борлуулалт 21.2 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 23% бууралттай, Европын томоохон Marketplace болох Zalando-ийн онлайн борлуулалт 1.6 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 52% өсөлттэй байсан бол Герман улс дахь хоёр салбар дэлгүүрийн борлуулалт 3.9 тэрбум төгрөг буюу 4% бууралттай байв.

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



### Казахстан улс дахь охин компани

Гадаад борлуулалтын сувгаа нэмэгдүүлэх зорилгоор 9-р сард Бүгд Найрамдах Казахстан Улсад охин компаниа байгуулсан.



INSTAGRAM VERIFIED BADGE

### Instagram-ийн албан ёсны таних тэмдэг

Gobi Cashmere-ийн бүх зах зээлийн 11 Instagram хаягууд албан ёсны таних тэмдгийн баталгаажуулалтаа авсан. Энэхүү албан ёсны таних тэмдгийг олон төрлийн шалгууруудыг давсан, олонд танигдсан брэндүүдэд олгодог бөгөөд Говь брэндийг илүү итгэл даахуйц, албан ёсны гэдгийг олон улсын хэрэглэгчдэд баталгаажуулах нэг алхам болно.



### CNN TV-ийн нэвтрүүлэг

CNN TV-ийн зочид төлөөлөгчид Монгол улсад хүрэлцэн ирж бэлтгэсэн Made in нэвтрүүлэгтээ Говь ХК-ийн үйлдвэр, дэлгүүр болон компанийн үйл ажиллагааны талаар ярилцлага мэдээллийг бэлтгэн оруулсан. Уг контент нь Америкийн сувгаар 6-7-р сард цацагдсан бөгөөд энэ нь дэлхий дахинд Говь брэндээ сурталчлах нэг алхам болсон.



### PR агентлагуудтай хамтын ажиллагаа

Бид 2023 онд Америкийн зах зээлд L.E.R, Английн зах зээлд B.agency, Германы зах зээлд R+, Бельгийн зах зээлд Charaly PR гэсэн PR агентлагуудтай хамтран ажиллалаа. Ийнхүү хамтран ажилласны үр дүнд Maya Musk, James Gunn, Kit Conner, Roman Pope Francis, Nas Daily зэрэг 429 нэр нөлөө бүхий дэлхийн дуучид, инфлүэнсэртэй хамтран ажилсан бөгөөд L'Officiel, The Magazine, GQ, Vogue, Elle, Cosmopolitan, The Guardian гэх мэт 219 сэтгүүлд гарч, АНУ, Герман, Англи улсуудад нийт 11 арга хэмжээнд оролцсон. Зорилтот зах зээлийн PR агентлагуудтай хамтарснаар зах зээлийн танигдалт тасралтгүй нэмэгдэж цаг алдалгүй, өндөр чанарын ажилбар гүйцэтгэх боломжтой болдог.



### Герман улс дахь шинэ салбар дэлгүүр

Гадаад зах зээлд нэрийн дэлгүүрийн тоогоо шат дараатайгаар нэмэгдүүлэх зорилгоор Герман улсын Дюссельдорф хотод 10-р сард салбар дэлгүүрээ нээн үйл ажиллагаагаа амжилттай өргөжүүлэн тэлсээр байна.



### Google x GOBI

Google компаниас Говь брэндийг хариуцаж буй ажилтнууд 9-р сард Монголд Говь ХК-ийн үйлдвэрээр зочлон түүхий эд бэлтгэлээс эцсийн бүтээгдэхүүн хүртэлх бүх шат дамжлагатай биечлэн танилцсан. Энэхүү уулзалтын үр дүнд гадаад зах зээлд Говь брэндийг таниулахтай холбоотой цаашдын төлөвлөгөөг тодорхойлсон бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



### Data Science

Говь ХК хэрэглэгчдийн нэгдсэн датаг бүрэн хэмжээнд боловсруулан ашиглахын тулд 2023 оноос эхлэн Data Science ашиглаж эхэллээ. Ийнхүү худалдан авалтын замналыг тодорхойлон мэдээллийн нэгдсэн дата платформтой болж, дата боловсруулалтыг хийн, борлуулалтын таамаглалыг илүү бодитой гаргах ажлуудыг амжилттай хийж байна.

## ГОВЬ БРЭНДИЙН ОРГАНИК ХАЙЛТ



2023 онд Гадаад борлуулалтын зах зээлд хийсэн нэг чухал ажил нь SEO буюу Search Engine Optimization компаниудтай хамтран ажиллаж брэндийн органик хайлтыг сайжруулах дээр анхаарч ажилласан.


### Органик түлхүүр үг

ХУГАЦАА	Түлхүүр үгийн байр				Түлхүүр үгийн тоо		Өөрчлөлт %
	1-3	4-10	11-50	51-100	2022	2023	
1-р улирал	485	1,448	7,182	3,820	3,529	<b>12,935</b>	267%
2-р улирал	379	1,120	5,692	3,258	3,412	<b>10,525</b>	209%
3-р улирал	296	817	4,700	3,989	6,566	<b>9,916</b>	51%
4-р улирал	652	1,883	7,773	5,991	13,144	<b>16,420</b>	25%

2022 онд нийт органик түлхүүр үгийн тоо 13,144 байсан бол 2023 онд 16,420 болж 25% өссөн. Үүнээс задлаад харвал 1-3 байранд байрлах үгс оны эхэнд 485 байсан бол оны эцэст 652, 4-10 байранд байрлах үгс 1,448-аас 1,883, 11-50-д байрлах үгс 7,182-оос 7,773, 51-100-д байранд байрлах үгс 3,820-оос 5,991 болж тус тус өссөн.


### Органик хандалт

ВЕБСАЙТЫН ХАНДАЛТ	2022	2023	Өөрчлөлт %
COM (www.gobicashmere.com)	124,506	<b>170,520</b>	37%
DE (www.gobicashmere.de)	74,459	<b>81,091</b>	9%
US (www.gobicashmere.us)	76,388	<b>127,291</b>	67%
<b>Нийт</b>	<b>275,353</b>	<b>378,902</b>	<b>38%</b>



2023 онд Говь брэндийн органик хайлтыг сайжруулах дээр анхаарч ажилласны үр дүнд вебсайт руу хандсан нийт хандалтаас органик хандалт нийт дүнгээрээ 38%-ийн өсөлтийг үзүүлсэн үр үндтэй байна. Үүнээс COM 37% өсөлттэй, DE 9% өсөлттэй, US 67% өсөлттэй байна.

## ПРОГРАММ ХӨГЖҮҮЛЭЛТ, ЦАХИМ ШИЛЖИЛТ



Говь ХК нь 2020 оноос хойш компанийн үйл ажиллагааны процессууд болон дотоодын программ хөгжүүлэлт зэрэг ажлуудыг шат дараатай хийн цахим шилжилтийг хэрэгжүүлэн ажиллаж байсан нь шинээр хэрэгжүүлж байгаа төслүүдийн суурь болсон.

2023 онд Мэдээллийн технологийн газрын зүгээс үйлдвэрлэлийн шат дамжлага, бүтээгдэхүүн хөгжүүлэлт талын системийн нэвтрүүлэлтүүдийг шат дараалан хийж, SAP ERP систем, Product Lifecycle Management систем, бэлэн бүтээгдэхүүн бүртгэл тооллогын системүүдийг амжилттай хийн ажиллаж байна.

### PRODUCT LIFECYCLE MANAGEMENT (PLM) СИСТЕМ



### ENTERPRISE RESOURCE MANAGEMENT (ERP) СИСТЕМ



Эдгээр системүүдийг үйл ажиллагаанд нэвтрүүлснээр Говь ХК-ийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, нэгж бүтээгдэхүүний үр ашиг, дамжлага дундын мэдээлэл, бэлэн бүтээгдэхүүний чанар, мөшгөлт, үйлдвэрлэлтийн тогтвортой, хэвийн үйл ажиллагаа зэрэг олон үйл ажиллагааны ашигт ажиллагааг улам сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэхэд томоохон дэвшил авчрах юм.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ ТЕХНОЛОГИ, БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

Говь ХК нь 2023 онд загварын нэр төрлийг нэмэгдүүлэн тусгай аргаар боловсруулсан нягт өндөртэй шинэ төрлийн 100% ноолууран Felton материалыг гарган ноолууран бүтээгдэхүүний хөгжлийг нэг шатаар ахиулсан Монголдоо анхдагч ноолууран гутлыг дотоод болон гадаадын зах зээлд хэрэглэгчдэд хүргэсэн. Инноваци шингэсэн тус бүтээгдэхүүнээр Монголын Ноос Ноолуурын Холбооноос "Онцлох Бүтээгдэхүүн - 2023" шагнал хүртсэн.

Манай компанийн Дизайн хөгжүүлэлтийн газар нь олон улсын томоохон брэндийн гутал хөгжүүлэлт дээр ажиллаж байсан туршлагатай мэргэжилтнээр удирдуулан гутлын технологи хөгжүүлэлтээ хийж байгаа бөгөөд цаашид нэр төрлөө нэмэгдүүлэн олон төрлийн гутлыг хэрэглэгчдэд хүргэхээр төлөвлөж байна.



Дизайн хөгжүүлэлтийн газар нь 2023 онд Gobi Pre-FW23 болон Organic Pre-FW23 коллекц дээр Ерөнхий дизайнер Giorgio Spina-тай хамтран ажилласан. Уг коллекциор бид үйлдвэрлэлийн хүчин чадлыг бүрэн ашиглан оёмол сүлжмэлийг хослуулж, сүлжээсний шинэ төрлүүдийг загвар дизайндаа тусган хэрэглэгчдэдээ хүргэсэн. Мөн 45 моделд 137 төрлийн стиль бүрдүүлэлт хийн Олон улсын жишигт нийцсэн Монголын анхны томоохон загварын шоуг толилуулсан. Хамтын ажиллагааныхаа дараагийн түвшинд бид, Gobi SS24 болон Organic SS24 коллекциуд дээр олон улсын зах зээлд зориулан, цаг уурын онцлогт тааруулсан шинэ төрлийн ноолуурын холиотой утаснуудаар урласан бүтээлүүдийг хэрэглэгчдэд хүргэхээр бэлтгэн ажиллаж байна.





## ДЭЛХИЙН АЛДАРТ ДИЗАЙНЕРТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА



GIORGIO SPINA

Дэлхийн загварын ертөнцийн том дөрвөлийн нэг болох Итали улсын алдарт дизайнер Giorgio Spina нь 2022 оны 12-р сараас Говь ХК-ийн ерөнхий дизайнераар томилогдон брэндийн өнгө төрх, загвар дизайн, өмсгөл суултыг илүү сайжруулан дэлхийн тавцанд өрсөлдөхүйц хэмжээнд хүргэхээр ажиллаж байна. Giorgio Spina нь загварын салбарт 20 гаруй жил ажиллахдаа Brunello Cucinelli, Alexander Wang, Moncler, Zegna гэх мэт маш олон алдартай брэндүүд мэргэжлийн ур чадвар, авьяас чадварыг нь үнэлэн бүтээсэн сүлжмэл утсыг өөрсдийн коллекцидоо тусган хамтран ажилладаг билээ.



## КОЛЛЕКЦУУД

Говь ХК-ийн Дизайн хөгжүүлэлтийн газрын мэргэшсэн чадварлаг хамт олон 2023 онд борлуулалт, ашигт ажиллагаагаа дэмжих, хэрэглэгчдэдээ тогтмол шинэлэг бүтээгдэхүүнээр бэлэг барих зорилгоор сар бүр шинэ коллекц танилцуулахаар төлөвлөж ажилласны дагуу нийт 29 шинэ коллекцийг дотоод болон гадаадын зах зээлд хэрэглэгч, үйлчлүүлэгчдэдээ хүргэсэн.



БАРЛАСАН ШААЛЬ КОЛЛЕКЦ



SWEATER КОЛЛЕКЦ



VALENTINE КОЛЛЕКЦ



ТЭРГҮҮЛЭГЧ ЦЭЦЭГ ЯРГУЙ



3D WHOLEGARMENT КОЛЛЕКЦ



ТУУЛАЙ ЖИЛИЙН  
ТУУЛАЙТАЙ ОЙМС



MEXICANA SS23 КОЛЛЕКЦ



PEONY КОЛЛЕКЦ



ХҮҮХДИЙН КОЛЛЕКЦ



ДЭЛХИЙН НЭГ ӨДӨР



SUPERTHIN КОЛЛЕКЦ



THE FACE PRE-FW23 КОЛЛЕКЦ



GOBI ORGANIC VANILLA FW23



CASHMERE REBORN



CASHMERE BOOTS



MATERIA PRE-FW23 КОЛЛЕКЦ



CASHMERE SHOES



НААДАМ КОЛЛЕКЦ



GOYO КОЛЛЕКЦ



WINTER FANTASY КОЛЛЕКЦ



CASHMERE SNEAKER /KNITTED/



MOUNTAIN FLOWER КОЛЛЕКЦ



BLAZER КОЛЛЕКЦ



TOWN & COUNTRY FW23 КОЛЛЕКЦ



АКЦЕССУАР КОЛЛЕКЦ



LEGGINGS КОЛЛЕКЦ



CASUAL SPORTIVE КОЛЛЕКЦ

**GOBI**  
MONGOLIAN CASHMERE

Бүх насныханд зориулсан сонгодог загварын хувцас, аксессуар болон гэр ахуйн бүтээгдэхүүнээр дэлхийд танигдсан GOBI MONGOLIAN CASHMERE брэнд

БРЭНДУУД



1  
МАНГАЙ КОМПАНИ

2  
2023 ОНД БИД

3  
БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4  
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

5  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

# GOBI ORGANIC

MONGOLIAN CASHMERE

Байгалийн үндсэн дөрвөн өнгийн ноолуурыг химийн будаг болон цайруулагч ашиглалгүйгээр урласан GOBI ORGANIC брэнд



Дэлхийн шилдэг дизайнерууд ур ухаанаа шингээн урласан дээд зэргийн чанартай, тансаг зэрэглэлийн YAMA брэнд





Орчин үеийн загварын чиг хандлагад нийцүүлэн бүтээлээ урладаг, тод өнгө, загваруудаар эрх чөлөөт байдлыг илэрхийлсэн шинэ залуу үеийн GOYO брэнд



Хүүхдийн хөдөлгөөнд саад учруулахгүйгээр дулаахан, таатай, хөнгөн мэдрэмжийг бэлэглэх загварлаг үрсийн KID GOYO брэнд






# ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Байгаль орчин

Нийгэм

Засаглал



## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА

Орчин үед бизнесийн байгууллагууд шийдвэр гаргах үйл явцдаа байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөлөөллийг буюу тогтвортой хөгжлийн үзүүлэлтийг чухалчлах нь дэлхий даяарх бизнесийн шинэ чиг хандлага болоод байна. Энэ нь зөвхөн нийгмийн хариуцлагын шаардлага гэхээс илүүтэй хэрэглэгч, хөрөнгө оруулагчид тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийг чухалчилдаг болсноос гадна, хууль эрх зүйн орчин шинэчлэгдэж байгаа өнөө үед өрсөлдөх чадвараа хадгалах зорилгоор үүсэн бий болж байна.

Тэр дундаа, хувцас үйлдвэрлэлийн салбарын хувьд дэлхийн эдийн засгийн томоохон хэсгийг буюу 2.5 их наяд долларыг бүрдүүлдэг бөгөөд манай дэлхий дээр амьдарч буй 75 сая хүнийг ажлын байраар хангадаг. Энэ салбар сүүлийн хэдэн арван жилд хурдтайгаар тэлсээр байгаагийн жишээ нь 2000-с 2014 онд 60%-н өсөлт үзүүлснийг дурдаж болно. Бид хувцас үйлдвэрлэлийн салбарын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгахад тодорхой хувь нэмэр оруулах зорилго тавьж, үндэсний томоохон аж ахуйн нэгжийн хувьд тогтвортой хөгжлийн манлайллыг үзүүлж 2022 оны 7 сард Тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичигтэй болсон.

Уг баримт бичигт 2025 он хүртэлх тогтвортой хөгжлийн удирдлага, байгаль орчин, нийгэм, засаглал, салбарын үйл ажиллагааны зорилтуудыг тодорхойлон, төлөвлөгөө гаргаж, шат дараатайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Бид тогтвортой хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалтыг тасралтгүй нэмэгдүүлж, ирэх 2024 онд компанийн нийт борлуулалтын орлогын 1% орчмыг тогтвортой хөгжлийн үзүүлэлтийг сайжруулахад зарцуулахаар төлөвлөж байна.


### ГОВЬ ХК – ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО /2022 – 2025/



**Нийлүүлэлтийн гинжин хэлхээн дэх сонирхогч талуудын хамтын ажиллагаанд ил тод, нээлттэй байдлыг ханган, компанийн тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийг тасралтгүй сайжруулах замаар Монгол ноолууран хувцсаа дэлхийд таниулна.**

Говь ХК-ийн Тогтвортой хөгжлийн бодлого нь нийгэм болон байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай засаглалтайгаар компанийн үйл ажиллагааг урт хугацаанд тогтвортой явуулах, бүтээмж болон үнэ цэнийг нэмэгдүүлэх, эрсдэл ба боломжийн хяналтыг сайжруулахад оршино.

#### БАРИМТЛАХ ЗАРЧМУУД



### Тогтвортой хөгжлийн соёлыг ажилтнаар дамжуулан өрх бүрд түгээв.

Тогтвортой хөгжлийн тухай ойлголт, соёл, Нэгдсэн Үндэсний байгууллагаас улс орнуудад, улс орнуудын төр засгийн байгууллагаас томоохон компаниудад, компаниас ажилтанд, ажилтнаас өрх бүрд хүрч, түгдэг.

Говь ХК-ийн хувьд тогтвортой хөгжлийн бодлогодоо “Сонирхогч талуудад тогтвортой хөгжлийн талаарх мэдлэг ойлголтыг түгээн өдөр тутмын амьдралд нь хэвшүүлнэ.” гэсэн зарчмыг тусгагдсан байдаг.

Компанийн Тогтвортой хөгжлийн баг 2023 онд нийт 2,981 хүн/цагийн сургалт зохион байгуулж, ажилтнуудын БОНЗ-ын хүрээний мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, дадал зуршлыг бий болгох ажлыг хийн, хэрхэн байгаль орчин, нийгэм, засаглалд ээлтэй иргэн байх талаарх соёлыг ажилтан бүрд, цаашлаад ажилтнаар дамжуулан өрх бүрд түгээлээ.

### Компанийн тогтвортой хөгжлийн соёлын түвшин өсөв.

Тогтвортой хөгжлийн бат бөх соёлыг дэлгэрүүлэх зорилгоор бид жил бүр тогтвортой хөгжлийн соёлын түвшнийг тодорхойлон, сайжруулах төлөвлөлтийг гаргадаг.

2023 оны 12 сард нийт 855 ажилтнаас Тогтвортой хөгжлийн удирдлагын соёлын судалгаа авав. Энэхүү судалгаагаар ажилтнуудын тогтвортой хөгжлийн талаарх мэдлэг ойлголт болон тогтвортой хөгжлийн үзүүлэлтийг сайжруулахад ажилтны оролцооны түвшин 2022 оны үзүүлэлтээс 36%-аар өссөн байна.



### Тогтвортой хамтын ажиллагаа

Говь ХК дотоодын болон олон улсын нэр хүнд бүхий байгууллага, нэгжүүдтэй хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, харилцан туршлага солилцон, тасралтгүй суралцаар байна.

Говь ХК дотоодын болон олон улсын нэр хүнд бүхий байгууллага, нэгжүүдтэй хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, харилцан туршлага солилцон, тасралтгүй суралцаар байна.



2023 онд хамтын ажиллагаагаа тэлсэн онцлох үйл явдлын нэг нь бид Азийн Хөгжлийн Банктай хамтран, тус байгууллагын санхүүжилтээр “Уур амьсгалын өөрчлөлтөд малчдыг бүлгэмээр дасан зохицуулах, бэлчээрийн тогтвортой менежментийг бий болгох туршилтын төсөл” хэрэгжүүлэхээр болсон билээ. Уг төсөл нь 2029 он хүртэл хэрэгжих бөгөөд дараах үндсэн зорилготой:

- Малчдын амьжиргааны түвшнийг дээшлүүлэх,
- Эрэгтэй эмэгтэй малчдад тэгш боломжийг олгох,
- Бэлчээрийн тогтвортой менежментийг бий болгох,
- Малчдыг уур амьсгалын өөрчлөлтөд бүлгэмээр дасан зохицуулах.



Энэхүү төсөл амжилттай хэрэгжиж дууссаны дараа төслийн явцад бий болгосон сайн туршлага, үр дүн, арга барилыг Монгол улсын төрийн холбогдох байгууллагуудтай хуваалцах юм. Ийнхүү бид тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход нэг шатаар ойртож буй хэрэг билээ.



БАЙГАЛЬ ОРЧИН





Уур амьсгалын өөрчлөлт бол температур, цаг агаарын хэв маягийн урт хугацааны өөрчлөлт юм. 1800-аад оноос хойш хүний үйл ажиллагаа, тэр дундаа нүүрс, газрын тос, хий гэх мэт чулуужсан түлшний шатаах үйл явц нь энэхүү өөрчлөлтийн гол шалтгаан болж байгаа тухай НҮБ тодорхойлсон байдаг.

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал манай улсад нэн хамаатай. 2090 он гэхэд дэлхийн дундаж температур 3.7% өсөх бол Монгол улсын дундаж температур 5.3% өсөх тухай Дэлхийн Банк, Азийн Хөгжлийн Банкны хамтын судалгаа байдаг. Энэхүү цаг агаарын өөрчлөлт нь манай улсын ажил эрхлэлтийн хувьд хамгийн том салбар болох мал аж ахуйн салбарт хамгийн хүндээр нөлөөлөх ажээ. Уур амьсгалын өөрчлөлт нь зудын хүнд байдал, давтамжийг ихэсгэх бөгөөд, үер усны аюул, хэт халалт, усны хомсдолыг үүсгэх тухай эх сурвалжууд дурдсан байдаг.

Иймд дэлхийн улс орнууд, цаашлаад компаниуд НҮБ-ын тогтвортой хөгжлийн 17 зорилгын хүрээнд Байгальд орчинд үзүүлэх нөлөөллөө хамгийн бага байлгах үүрэг амлалтаа өгч, тодорхой зоримог алхмуудыг хийж эхэлсэн.




Говь ХК-ийн хувьд үйлдвэрлэлийн бүх шат дамжлагадаа байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, байгалийн нөөц баялгийг хариуцлагатайгаар ашиглах зорилгоор Байгаль Орчны Удирдлагын "НОГООН ТОГТОНЦОО"-г бий болгон тасралтгүй сайжруулан ажилладаг ба Байгаль орчны удирдлагын тогтолцооны стандарт ISO 14001:2015-г үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.



Бид тогтвортой хөгжлийн бодлогодоо байгаль орчны дараах зорилтуудад хүрэх 3 жилийн төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.




## БАЙГАЛЬ ОРЧНЫ 2025 ОНЫ ЗОРИЛТ БА 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТ




Цэвэр бохир усны тоолуурыг сайжруулан, байгууллагын үйл ажиллагаанаас гарч буй ахуйн болон үйлдвэрийн бохир усны 10 хүртэлх хувийг дахин цэвэршүүлэх



Байгууллагын талбайд эзлэх ногоон байгууламжийн талбайн эзлэх хувийг нэмэгдүүлэх




Нийт хог хаягдлыг ангилан бүртгэлжүүлж, хог хаягдлын дахин боловсруулалтын хувийг нэмэгдүүлэх



Үйл ажиллагаандаа сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх


**Зорилт:** Нэгж бүтээгдэхүүнд ногдох эрчим хүчний хэрэглээг 15% буюу 31.82кВт.ц хүртэл бууруулах.

НЭГЖ БҮТЭЭГДЭХҮҮНД НОГДОХ ЭРЧИМ ХҮЧ /кВт.ц/



2023 он нэгж бүтээгдэхүүнд ногдох эрчим хүчний хэрэглээ нь 2022 онтой харьцуулбал 15.2%-аар буурсан.

НИЙТ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ /сая кВт.ц/



2023 оны нийт эрчим хүчний хэрэглээ нь 2022 онтой харьцуулбал 4%-аар өссөн.

## 2023 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫ ХҮРЭЭНД ХИЙСЭН ОНЦЛОХ АЖЛУУД



### ISO 14001:2015

Байгаль орчны удирдлагын тогтолцоо ISO 14001:2015 стандартыг 2022 онд баталгаажуулалт хийгдсэнээс хойш тасралтгүй сайжруулан 2023 онд Олон улсын баталгаажуулалтын байгууллагаар амжилттай магадлан аудитлагдав.



### БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ

Монгол улсад мөрдөгдөж буй Байгаль орчны хууль, тогтоомж, стандартын шаардлагуудын хэрэгжилтийг үнэлэх байгаль орчны аудитаар 8 бүлэг 117 шалгуур үзүүлэлтийн хүрээнд 99.2% гүйцэтгэлтэйгээр багц хуулийн нийцлийн аудитаар дүгнүүлэв.

### СУРГАЛТ - 258 ХҮН/ЦАГ



- Химийн бодистой харьцаж ажилладаг ажилтнуудад “Химийн бодисын зохистой хэрэглээ” сэдвийн хүрээнд 160 хүн/цагийн сургалт,
- “Эрчим хүчний хэмнэлт, үр ашиг” сургалтын хүрээнд Техник удирдлагын хэлтсийн инженерүүд болон үйлдвэрийн удирдлагуудад 98 хүн/цагийн сургалт зохион байгуулав.

### НОГООН БАЙГУУЛАМЖ



- 3,200 ширхэг**  
Дүйцүүлэн хамгаалах болон Гадаа талбайн ногоон байгууламжийн ажлын хүрээнд 3,000 ширхэг хайлс, 200 ширхэг улиас мод тарив.




- 966 м.кв**  
Байгууллагын хэмжээнд ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэхээр зүлэгжүүлэлт хийв. /Говь, Говь-2, Гоёо/



- 800 ширхэг**  
Оффисын гадаа талбайн тохижилтын ажлын хүрээнд 3 төрлийн 800 ширхэг хун цэцэг тарив.


### ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ



Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг шинэчлэн батлуулсан бөгөөд хөтөлбөрийн хүрээнд дээж шинжилгээ мониторинг хийж, хэвийн үзүүлэлт хангагдсан.


**Зорилт:** Байгууллагын шууд болон шууд бус үйл ажиллагаанаас хамаарах хүлэмжийн хийн ялгарлыг 10% бууруулах.

НЭГЖ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛЭЭС ЯЛГАРАХ ХҮЛЭМЖИЙН ХИЙ /кг/



2022 оны суурь үзүүлэлтээс 14.6%-аар буурав.

НИЙТ ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРУУЛАЛТ /мянган тонн/



Байгууллагын шууд болон шууд бус үйл ажиллагаанаас ялгарах хүлэмжийн хийн хэмжээ 2022 оноос 5%-аар өссөн.

### ХОГ ХАЯГДАЛ

Хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд “Хог хаягдлын хөтөлбөр”, “Хог хаягдлын тухай журам”-ыг шинэчлэн боловсруулж, “Өнгө нэм” ТББ-тай хамтран дараах ажлуудыг хийж хэрэгжүүлэв. Үүнд:



- Хог хаягдлын бүтцийн болон суурь судалгаа хийв.



- Хог ангилан ялгалтын төрлийг 4 болгож нэмэгдүүлэв.



- Хогийн цэгийг шинэчлэх төлөвлөлт гарган, хогийн цэгийг нүүлгэн шилжүүлэв.

### ХИМИЙН БОДИС

Химийн бодис хэрэглэдэг 4 үйлдвэр, 2 албанд нийт 76 ширхэг асгаралтыг тосох подон байршуулж, химийн бодисын асгаралтын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулав. Мөн химийн хортой болон аюултай бодис захиалах, худалдан авах, тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах журам"-г шинэчлэн боловсруулж батлуулав.



### ЭРЧИМ ХҮЧ

Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх зорилгоор нарны эрчим хүчний системүүдийн судалгаа, тооцоолуудыг CRD болон Huawei байгууллагуудтай хамтран хийв. Мөн ISO 50001 стандартын агуулгын хүрээнд “Эрчим хүч хэмнэлтийн журам”-ыг шинээр боловсруулан, батлуулав. 2024 онд нарны эрчим хүч ашиглаж эхлэхээр төлөвлөж байна.



### УСНЫ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ



Агааржуулалтын хөргөлтөд ашигласан цэвэр усыг анхан шатны үйлдвэрийн ноолуур угаах дамжлагад дахин ашиглаж байна.



Ноолуур будахдаа цайруулалт хэрэглэхээс татгалзаж, натурал өнгө дээр шууд будалт хийснээр ус, химийн бодисын зарцуулалт буурсан.



Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг сайжруулан лаг усгүйжүүлэх төхөөрөмж суурилуулав.

## УСНЫ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ ҮЙЛДВЭРЛЭЛД НЭВТРҮҮЛСЭН ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА

Манай компани жил бүр усны хэрэглээг бууруулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилладаг. Тухайлбал агааржуулалтын хөргөлтөд ашигласан цэвэр усыг анхан шатны үйлдвэрийн ноолуур угаах дамжлагад дахин ашиглах, ариун цэврийн өрөөнд усны хэмнэлттэй цорго суурилуулах болон ноолуур будахдаа цайруулалтаас татгалзах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр цэвэр усыг илүү үр ашигтай, хэмнэлттэйгээр зарцуулж байна.

Мөн 2020 онд бохир ус цэвэршүүлэх байгууламж байгуулан ашиглаж эхэлсэн. Цаашид цэвэршүүлэх байгууламжийнхаа хүчин чадлыг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийг нь шинэчлэх ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

2023 онд бидний хэрэгжүүлж буй дээрх ажлууд үнэлэгдсэн жил байлаа.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэргэдэх Монголын Тогтвортой Ноолуурын Платформ болон Уур амьсгалын Ногоон Сангийн санхүүжилтээр БОАЖЯ, ХХААХҮЯ-ны хэрэгжүүлж буй “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” (АДАПТ) төсөл хамтран Монгол Улсад анх удаа “Тогтвортой ноолуурын өдөр – 2023” арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээний үеэр “Говь” ХК нь Усны зохистой хэрэглээг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн шилдэг байгууллагаар шалгарлаа.



## ХАРИУЦЛАГАТАЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бид түүхэн хөгжлийнхөө явцад олон зуун жилийн түүхтэй ард иргэдийнхээ уламжлалт нүүдэлчин ахуйг, орчин үеийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, инновацтай хослуулан бүтээгдэхүүн үйлчилгээгээ хөгжүүлж ирсэн төдийгүй, хэрэглэгчдэдээ чанар, нийцэмжит үнэ, загвар, тогтвортой байдлыг амладаг.



ЧАНАР



НИЙЦЭМЖИТ ҮНЭ



ЗАГВАР




ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Энэ амлалтынхаа хүрээнд байгаль орчин, нийгэмд ээлтэй, хариуцлагатай коллекчуудынхаа үйлдвэрлэлийн тоо хэмжээг жил бүр нэмэгдүүлсээр байгаа бөгөөд ингэснээр тогтвортой үйлдвэрлэл эрхлэх зорилгодоо хүрэхэд улам ойртож байгаа гэдэгтээ эргэлзэхгүй байна.

Бид байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах шинэ технологи, арга барилыг байнга нэвтрүүлэн ашигладаг бөгөөд хуучин технологио эрчим хүч, зардал бага зарцуулдаг орчин үеийн тоног төхөөрөмжөөр шинэчлэх хөрөнгө оруулалтыг тасралтгүй хийсээр байна.

### Нийт хариуцлагатай коллекчуудын үйлдвэрлэл



2023 оны хариуцлагатай коллекцийн үйлдвэрлэлийн тоо хэмжээ 2022 онтой харьцуулахад 36%-аар өсөв.

2023 оны хариуцлагатай коллекцийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувь нь 2022 онтой харьцуулахад 15%-аар өссөн байна.

### Нийт хариуцлагатай коллекц үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлсэн эерэг нөлөөг дараах байдлаар илэрхийлж болно:

/Энгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэнтэй харьцуулахад/

8,499,000  
литр ус хэмнэсэн.

44.7  
хүний жилийн усны хэрэгцээтэй тэнцэнэ.

3,061,463.26  
кВт/ц эрчим хүчийг хэмнэсэн.

790  
айл өрхийн жилийн эрчим хүчний хэрэглээтэй тэнцэнэ.


4,000 тонн CO<sub>2</sub> буюу  
хүлэмжийн хийг агаар мандалд  
ялгарахаас сэргийлсэн.

200  
ширхэг бензин хөдөлгүүртэй  
машины жилийн нүүрс  
хүчлийн хийн ялгаруулалттай  
тэнцэнэ.


### ОРГАНИК КОЛЛЕКЦ

Монгол ноолуур нь байгалийн 4 төрлийн өнгөтэйгөөрөө бусад улсын ноолуураас давуу талтай. Бид энэхүү давуу талаа ашиглан ямар ч будагч бодис болон цайруулах бодис ашиглахгүйгээр байгальд болон хүний биед хамгийн ээлтэй бүтээгдэхүүнийг энэхүү "Органик" коллекцоороо хүргэдэг. Органик коллекцийн онцлог нь:

- Ноолууран утсыг будахад химийн бодис хэрэглэдэггүй ба усны өндөр хэрэглээнээс зайлсхийдэг.
- Эрчим хүч хэмнэж, CO<sub>2</sub>-н ялгаруулалтыг бууруулдаг.
- Ноолууран утасны байгалийн бүтцийг алдагдуулахгүйгээр, чанарыг нь хэвээр хадгалдаг.
- Байгалийн өнгө нь халуун дулаан мэдрэмжийг төрүүлдэг.




Органик коллекцийн давуу талыг тоогоор илэрхийлбэл:




### WHOLEGARMENT 3D КОЛЛЕКЦ

Оёдолгүй ноолууран бүтээгдэхүүн нь уламжлалт сүлжмэл бүтээгдэхүүнээс залгаа оёдолгүйгээрээ ялгаатай ба Shima Seiki сүлжмэлийн машинаар загварын програмчлалын дагуу бүтээгдэхүүнийг бүтнээр нь сүлжин үйлдвэрлэдэг. 3D коллекцийн онцлог нь:

- Биед тав тухтай. Оёдол, холбоос байхгүй тул эмзэг арьстай хүн өмсөхөд нухаж холгохгүй.
- Байгаль орчинд ээлтэй. Эрчим хүч, ус бага зарцуулдаг, ажлын цагийн бүтээмж өндөр тул эдийн засгийн хувьд хэмнэлттэй.
- Технологийн үлдэгдлийг багасгадаг. Энэхүү коллекцийн үйлдвэрлэлд өнгө, хээний зохицлоос шалтгаалсан технологийн хаягдал гардаггүй.
- Бүтээгдэхүүний насжилт өндөр. Нэхээс жигд, өндөр чанартай, үйлдвэрлэлийн хугацаа богино ба эдэлгээ удаантай байдаг




Cashmere Reborn коллекцийн давуу талыг тоогоор илэрхийлбэл:




### CASHMERE REBORN КОЛЛЕКЦ

Бид хэрэглэгчдэд тогтвортой үйлдвэрлэлийн шинэ санаачилгыг танилцуулж 2023 онд "CashmeReborn" коллекцийг худалдаанд гаргасан юм. Уг коллекцоор бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцад үүссэн технологийн үлдэгдлийг дахин ашиглаж, дахин шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэн хэрэглэгчдэд хүрдэг билээ. CashmeReborn коллекцийн онцлог нь:

- Хаягдалгүй үйлдвэрлэл. Энэ нь байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн өндөр ач холбогдолтой.
- Ус, эрчим хүчний хэрэглээ, CO<sub>2</sub>-н ялгаруулалтыг бууруулдаг.
- Тус коллекцийн бүтээгдэхүүнүүд нь дахин давтагдашгүй өнгө, загвартай




Cashmere Reborn коллекцийн давуу талыг тоогоор илэрхийлбэл:



### RESPONSIBLE CASHMERE КОЛЛЕКЦ

Говь ХК нь өнгөрсөн 3 жилийн хугацаанд нийгмийн хариуцлагын хүрээнд үйлдвэрлэл – малчид – шинжлэх ухааны уялдаа холбоог бэхжүүлэх зорилготой "Тогтвортой ноолуур гурван талт төсөл"-ийг санаачлан хэрэгжүүлсэн.

Төслийн үр дүнд түүхий ноолуурын чанар сайжирснаар малчдын орлого нэмэгдэх бөгөөд цаашлаад цөлжилттэй тэмцэх урт хугацааны амбицтай төсөл билээ. Төсөлд хамрагдсан малчдын гар дээрээс авсан ноолуураар RESPONSIBLE CASHMERE коллекц үйлдвэрлэгдэж эхэллээ. Тус коллекц 2024 оны 1-р улиралд Европын Холбооны зах зээлд худалдаалагдаж эхэлнэ.





НИЙГЭМ



Говь ХК нь тогтвортой хөгжлийн бодлогодоо "Нийгэм" -ийн хүрээнд Хүний нөөцийн хариуцлагатай менежмент буюу дотооддоо чиглэсэн, Нийгмийн хариуцлага буюу гадагшаа чиглэсэн гэж хоёр чиглэлд хуваан, тус бүрд нь тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн.

## НИЙГМИЙН БОДЛОГО, ЗОРИЛТ 2025

<p>Хүний нөөцийн эргэц</p> <p>20%</p> <p>↑ Цалин урамшуулал</p> <p>Салбартаа тэргүүлэх цалин урамшуулал</p> <p>↑ Ажилтнуудын эрүүл, аюулгүй орчин</p>	<p>Аюул ослын давтамж (ХЭМАБ-ын бодлого)</p> <p>0</p> <p>↑ Ажлын байрны таатай орчин, Ажил-Амьдралын тэнцвэрт байдал</p> <p>↑ Ногоон ажлын байр</p> <p>↑ Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт</p>	<p>Хөдөлмөрийн мөлжлөг, албадсан болон насанд хүрээгүй хүний хөдөлмөр эрхлэлт</p> <p>0</p> <p>↑ Ажилтнуудын хувийн өсөлт хөгжилт</p> <p>↑ Ижил тэгш боломж</p>
---	---	--


## ХҮНИЙ НӨӨЦИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

### НИЙТ АЖИЛТНЫ ТОО




1,765


### ЧИГ ҮҮРГЭЭР




### АЖИЛЛАСАН ЖИЛЭЭР




### УДИРДЛАГЫН БАГ




### ДУНДАЖ НАС 35: НАСНЫ ИНТЕРВАЛААР:




### ЗАХИРГАА



### БОРЛУУЛАЛТ



### ҮЙЛДВЭР




### БАЙРШЛААР:

МОНГОЛ - 99% ОЛОН УЛС - 1%



### Хүний нөөцийн эргэц



Ажилтны санаачилгаар - 35%  
Ажил олгогчийн санаачилгаар - 5%

## ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАРИУЦЛАГАТАЙ МЕНЕЖМЕНТ

Бид ажилтан бүрийнхээ ажлын байрыг тогтвортой хадгалах, өсөж дэвжих таатай орчныг бүрдүүлэх, ижил тэгш оролцоогоор ханган хүний эрхийг дээдэлж ажиллахаа амладаг. Бид хүний нөөцийн хариуцлагатай менежментийн дараах хүрээнд төвлөрөн ажиллаж байна. Үүнд:

1. Ажилтны эрүүл аюулгүй орчин
2. Ажилтнуудын хувийн өсөлт хөгжил
3. Ажлын байрны таатай орчин, Ажил - Амьдралын тэнцвэрт байдал
4. Салбартаа тэргүүлэх цалин урамшуулал

### 1. АЖИЛТНЫ ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИН

*Зорилт - Нэгдүгээрт аюулгүй байдал*

ГОВЬ ХК “Нэгдүгээрт аюулгүй байдал” зарчмыг баримтлан ажилтнуудынхаа эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлөөр хангахыг зорилго болгон ажилладаг. Тиймээс, олон улсын Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO45001:2018 стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлсээр байна.

Манай байгууллага нь өөрийн ажлын байрандаа уламжлалт болон орчин үеийн эмчилгээг хослуулсан үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг яаралтай тусламжийн нэгжтэй. Тус нэгж нь ажилтнуудад эрүүл мэндээ анхаарах, урьдчилан сэргийлэх, эмчийн үзлэгт хамрагдах, анхны тусламж шуурхай авах боломжоор хангадаг. Энэ нь ажилтны цаг хугацаа, мөнгө санхүүг хэмнэх, эрүүл мэндийг хамгаалах өндөр ач холбогдолтой.

#### ЭМНЭЛЭГ

Он	Өдөр тутмын үзлэг	Урьдчилан сэргийлэх үзлэг
2022	Давхардсан тоогоор 3,774 ажилтан	300 ажилтан
<b>2023</b>	<b>Давхардсан тоогоор 3,251 ажилтан</b>	<b>1,500 ажилтан</b>

#### ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

Он	Осол гэмтэлгүй ажилласан цаг	Сургалт
2022	2,396,160 хүн/цаг	Давхардсан тоогоор 15,144 ажилтанд сургалт оров. (3.8 хүн/цаг)
<b>2023</b>	<b>2,547,200 хүн/цаг</b>	<b>Давхардсан тоогоор 6,105 ажилтанд 22,433 хүн/цагийн сургалт оров. (12.7 хүн/цаг)</b>



## 2. АЖИЛТНУУДЫН ХУВИЙН ӨСӨЛТ ХӨГЖИЛ

*Зорилт - Компанийн хэрэгцээ шаардлага, ажилтны хувийн болон карьер төлөвлөлтөд үндэслэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ*

ГОВЬ ХК нь “Ажилтнуудыг мэдлэг ур чадвараа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэн ажлын байранд нь мэргэшүүлэх, чадавхжуулах, хөрвөх чадвар бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлын байран дээрх болон танхимын сургалтуудыг зохион байгуулан ажиллана” хэмээн Хүний нөөцийн бодлогодоо тусгасан. Сургалт хөгжлийн үйл ажиллагааг ГОВЬ ХК-ийн Сургалт, хөгжлийн журмаар зохицуулдаг.

Он	Нийт сургалтын тоо	Оролцогчдын тоо	2023 оны нэг ажилтанд ногдох сургалтын цаг	
2022	246 удаагийн сургалт	Давхардсан тоогоор 8,662 ажилтан	Мэргэжлийн ур чадвар	5.2 хүн/цаг
<b>2023</b>	<b>316 удаагийн сургалт</b>	<b>Давхардсан тоогоор 5,618 ажилтан</b>	Ерөнхий ур чадвар	6.4 хүн/цаг

#### Санхүүгийн боловсрол олгох сургалт

Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх “Хувьцааны хуримтлал” сургалт

- 5 удаагийн 8 цагийн танхимын сургалтыг 243 ажилтанд зохион байгуулсан.
- Мөн 250 гаруй ажилтанд онлайнгаар хүргэсэн.
- Санхүүгийн боловсролд зориулж “Хуримтлалтай баялаг бүтээгч” арга хэмжээг нийт ажилтнуудад зориулан 3 удаагийн өдөрлөгийг зохион байгуулж нийт 210 ажилтанд мэдээлэл өгсөн бөгөөд үүнээс 35 ажилтан шууд үйлчилгээ хүлээн авч 18 ажилтанд хадгаламжийн данс нээлгэсэн.

#### Gobi Trainer - 2023

Байгууллага дотоод нөөц боломжоо ашиглан **дотоодын сургагч 27 багшийг** бэлтгэж, 30 удаагийн сургалтыг 927 ажилтанд орсон бөгөөд сургалтанд хамрагдсан ажилтнуудын сэтгэл ханамжийн үнэлгээ 92% байв. Ингэснээр гадны байгууллагаас авах сургалтыг өөрийн багш нараар, мөн Говь ХК-ийн соёлыг дотоодын сургагч багш нараар дамжуулан ажилтнууддаа түгээх боломж бүрдэж байгаа юм.





### 3. АЖЛЫН БАЙРНЫ ТААТАЙ ОРЧИН, АЖИЛ - АМЬДРАЛЫН ТЭНЦВЭРТ БАЙДАЛ

Зорилт - Аз жаргалтай ажилтан

Аливаа байгууллагын амжилт, цаашдын өсөлт хөгжилд нөлөөлөх хамгийн чухал хүчин зүйл нь хамт олны нэгдмэл байдал, аз жаргалтайгаар ажиллах орчин нөхцөл байдаг. Тийм ч учраас Говь ХК нь баялаг бүтээгч нийт ажилтнуудынхаа ажил амьдралыг тэнцвэртэй зохицуулах, ялгаварлан гадуурхалтгүй орчныг бүрдүүлэх, сэтгэл хангалуун байлгахад онцгойлон анхаарч ажиллаж байна.



#### Уян хатан ажлын цаг

Замын хөдөлгөөний түгжрэлээс урьдчилан сэргийлэх, ажилтнуудын ажил амралтын цагийг тэнцвэржүүлэх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 3 дахь жилдээ ажлын уян хатан цагийн системийг оффисын +500 ажилтнуудад хэрэгжүүлж байна.

Ажилтнуудын ажил амралтын цагийг тэнцвэржүүлэх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор сүлжмэлийн үйлдвэрийн нярай болон цэцэрлэгийн насны хүүхдүүдтэй сүлжмэл бүтээгдэхүүний 24 оёдолчныг богиносгосон цагаар ажиллуулж байна.



#### Говь-ийн багачууд цэцэрлэг


Байгууллагын дэргэдэх "Говь-ийн багачууд" цэцэрлэг 2022 онд нээлтээ хийснээс хойш жилийн 4 улирлын турш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна.

Зуны улиралд ч амралгүйгээр үйл ажиллагаагаа явуулснаар ажилтнууд маань хүүхдүүдээ эрүүл, аюулгүй орчинд сургаж хүмүүжүүлэхээс гадна сэтгэл амар ажиллах боломж бүрдсэн.

### 4. САЛБАРТАА ТЭРГҮҮЛЭХ ЦАЛИН УРАМШУУЛАЛ

Зорилт - Мерит зарчмыг баримтлан ажилтны ур чадварыг үнэлж урамшуулан, чадварлаг хүний нөөцийг татах, тогтвортой ажиллах соёлыг бэхжүүлнэ.

Байгууллагын урт хугацааны томоохон хөрөнгө оруулалтын нэг бол ур чадвартай, хариуцлагатай хүний нөөцийг бүрдүүлж, тогтвортой ажиллуулахад оршдог. Манай байгууллагын хувьд ажилтан бүрийг тэгш боломжоор хангах, цалин урамшууллыг үнэн шударгаар олгох, эх орондоо тайван амьдрах боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.




2023 оны эрэгтэй ажилтны дундаж цалин эмэгтэй ажилтны дундаж цалингаас 4%-иар өндөр байна.

2023 онд эрэгтэй ажилтнуудын дундаж цалингийн өсөлт 16%, эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн өсөлт 13% байна.

### НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА /Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт/

Зорилт - Батлагдсан төсөл, хөтөлбөрийн дагуу хамтын ажиллагаагаар дамжуулан тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалтыг жил тутамд нэмэгдүүлж, гүйцэтгэлийг 90%-аас дээш хангана.

Нийгмийн салшгүй нэг хэсэг болох бизнесийн байгууллагуудын хувьд улс орон болоод нийгэмд тулгарч буй асуудлыг шийдэхэд санаачилга гаргах, бусдыг уриалан нэгтгэх, эдийн засгийн өсөлт хөгжилд хувь нэмрээ оруулах зайлшгүй шаардлагатай билээ. Бид ноос ноолуурын салбарын анхдагч ууган үйлдвэрлэл эрхлэгч, хөдөө аж ахуйн салбартай нягт холбогдон ажилладгийг үндэслэн тогтвортой хөгжлийн нийгмийн хариуцлага, тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалтын хүрээнд 2023 онд нийгмийн сайн сайхны төлөөх олон төсөл, хөтөлбөрүүд санаачлан хэрэгжүүлж гүйцэтгэлээ.



2023 онд Говь ХК нийгмийн хариуцлагад зориулан 724 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн нь өмнөх оны үзүүлэлтээс 54% өссөн үзүүлэлт юм.

#### ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, АЖИЛ ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИН САЛБАР ҮЙЛДВЭРЭЭ НЭЭВ.



Говь ХК нь 2023 онд орон нутаг дахь анхны салбар үйлдвэрээ Хэнтий аймагт нээв. Уг үйлдвэр нь ноос ноолуурын салбарт хамгийн нарийн ажиллагаанд тооцогддог "кеттель"-ийн үйлдвэр бөгөөд 100 гаруй ажилтан ажиллах хүчин чадалтай юм. Уг үйлдвэр нь эхний ээлжид 50 гаруй ажилтныг "КЕТТЕЛЬЧИН" ажлын байранд ажиллуулж байгаа бөгөөд Монгол-Солонгосын политехникийн кеттелийн багш нар хамтран мэргэжлийн ур чадвар олгох богино хугацааны сургалтад туршлагагүй хүмүүсийг ч хамруулан чадамжийн гэрчилгээ олгох юм.

"ГОВЬ"-ийн орон нутаг дахь кеттелийн салбар үйлдвэр ноос ноолуурын салбарт цөөн байдаг боловсон хүчнийг нэмэгдүүлж, чадавхжуулсаар байна. Бид орон нутагт салбар үйлдвэрээ нээснээр тогтвортой ажлын байрыг бий болгож нийслэл хотыг зорих иргэдийн урсгал багасан, орон нутгийн хөгжил тэлэхийн зэрэгцээ өрхийн орлого нэмэгдэх гээд онцлоод баршгүй олон давуу талууд цогцолсон үйл явдал болсон билээ.

**Говь ХК 2023 оны 10-12 сард уг салбар үйлдвэрийн бүтээн байгуулалт, ажилтнуудын цалин, урсгал зардалд 400 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд байна. Үүнд:**

- **Хамгийн дулаан бэлэг:** Өргөө амаржих болон ЭХЭМҮТ-ийн төрөх тасгийн нийт 800 нярайд зориулан ноолууран бүтээгдэхүүнээр бэлэг барилаа.
- **Хүүхэд бүхэн аз жаргалтай:** Зорилтот бүлгийн нийт 135 хүүхдүүдэд хүүхдийн баярын бэлэг бэлэглэв.
- **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжигч-эко даавуун тор:** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн "Эко даавуун торны үйлдвэр"-ийг дэмжин даавуун торыг уг үйлдвэрээс захиалан хийлгэж байна.
- **Ахмадуудын сар шинийн мэнд:** Говь ХК-аас гавьяаныхаа амралтанд гарсан 456 ахмадууддаа гарын бэлэг хүргүүлэв.
- **Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн үйл ажиллагаа:** ХУД-ийн Гэр бүл хүүхэд залуучуудын газартай хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажилтнуудаа сургаж хөгжүүлж байна.

## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТӨСӨЛ

### ТОГТВОРТОЙ НООЛУУР, ГУРВАН ТАЛТ ХАМТАРСАН ТӨСӨЛ

Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 70.1%-г бэлчээр эзэлдэг. Бэлчээрийн боломжит даац нь хонин толгойд шилжүүлэхэд 86 сая байх ёстой ч 2022 оны байдлаар малын тоо 120.7 сая хонин толгой болсон байгаа буюу нийт бэлчээрийн талбайн 30 гаруй хувьд даац хэтэрсэн үзүүлэлттэй байна. Хэрвээ ашиглалтын хэлбэрийг бүрэн өөрчилбөл бэлчээрийн талаас илүүг сэргээх боломжтой тухай Монгол банкны 2019 оны судалгаа байдаг.

Монгол улсад 2022 оны байдлаар 300,000 малчин мал аж ахуй эрхлэн, аж төрж байна. Эдгээр малчдын аж амьдрал ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбараас шууд хамааралтай. Өөрөөр хэлбэл, малчдын орлогын дийлэнх буюу 62%-ийг ямааны ноолуур бүрдүүлдэг тухай 2019 оны судалгаа байдаг.

Тиймээс Говь ХК нийгмийн хариуцлагын хүрээнд “Тогтвортой ноолуур, гурван талт төсөл”-ийг 3 дахь жилдээ хэрэгжүүлж байна.

Говь ХК нь уг төслийг 2020 оноос эхлэн санаачлан санхүүжүүлж, ХААИС, малчидтай хамтран Баянхонгор аймгийн Жинст сум, Хөвсгөл аймгийн Их – Уул суманд 2025 он хүртэл хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэхүү төсөл нь Үйлдвэрлэл – Шинжлэх ухаан – Малчид хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх, малын удмын санг сайжруулах, түүхий ноолуурын чанарыг нэмэгдүүлэх замаар малчин өрхийн орлогыг дэмжих зорилготой билээ.



Төслийн үндсэн үйл ажиллагааг дурдвал:

- Шилмэл үүлдрийн ухнаар малын удмын санг сайжруулах
- Ноолуурын дээж авч, чанарын үзүүлэлтийг тодорхойлох, тасралтгүй сайжруулах
- Малчдын гараас худалдан авсан түүхий эдээр мөшгөх боломжтой бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хэрэглэгчдэд хүргэх
- Малын эрүүл мэндийг сайжруулах
- Малчдад зориулсан сургалт, үйлдвэртэй танилцах аялал зохион байгуулах зэргийг дурдаж болно.

2023 онд төслийн санхүүжилтэд 125 сая төгрөгийн зарцуулж, төлөвлөгөөний дагуу амжилттай хэрэгжүүлэн, 91%-ийн гүйцэтгэл хангав. Бид төсөлд хамрагдсан малчдын гар дээрээс ноолуур авч эхэлсэн бөгөөд ижил бүс нутгийн төслийн бус ноолууртай харьцуулахад ноолуурын голч 1%-аар нарийсаж, хаг, хогт хольц 6% буурсан эерэг үр дүн гараад байна.

Бид төслийн ноолуураар бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд 2024 оны 1-р улиралд Европын холбооны зах зээл дээр борлуулахаар ажиллаж байна. Мөн төслийн үйл ажиллагааны хүрээнд тогтвортой хөгжлийн соёлыг түгээн дэлгэрүүлэх зарчмаа баримтлан 2023 оны 11 сард төслийн малчдад зориулан “Тогтвортой хөгжилд малчдын оролцоо” сэдэвт сургалт орж, гарын авлага тараасан билээ.


Цаашид бид малчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, мэдлэг олгох сургалт, хөтөлбөр зохион байгуулах, малчдыг эко гэрчилгээ, баталгаажуулалт авахад хамтран ажиллах, Азийн хөгжлийн банкттай хамтран төслийг өргөжүүлж “Бэлчээрийн доройтлын эсрэг” төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хөтөлбөр гаргах зэргээр төслийн үйл ажиллагааг өргөжүүлэхээр төлөвлөж байна.

#### 2023 онд “Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл” тогтвортой хөгжлийн шилдэг төслөөр шалгарав.

Тодруулбал, Монгол дахь Америкийн Худалдааны Танхим “Амчам Монгол ТББ” нь “CSR Awards 2023” арга хэмжээгээр Нийгмийн Хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн төслүүдээс INNOVATION, LEADERSHIP, SUSTAINABILITY гэсэн төрлөөр шилдэг гурван төслүүдийг шалгаруулсан бөгөөд SUSTAINABILITY төрөлд арван гишүүн байгууллага нэр дэвшсэнээс энэхүү шагналыг Говь ХК-ийн “Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл” хүртлээ.



## НООЛУУРЫН САЛБАР




Монгол Улсад 2023 онд 24.6 сая тоо толгой ямаан сүрэг тоологдсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 сая буюу 11%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Манай улс 2023 онд 10.5 мянга орчим тонн ноолуур бэлтгэсэн нь өмнөх оноос 0.3 мянган тонн буюу 3%-аар өссөн үзүүлэлт бөгөөд дэлхийн түүхий ноолуурын 40%-ийг хангаж байна.

2023 онд ноолуурын дундаж үнэ 135 мянган төгрөг байсан нь өмнөх оноос 8%-аар өссөн байна.


### СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН МОНГОЛ УЛСЫН НООЛУУРЫН САЛБАРЫН ТООН МЭДЭЭЛЭЛ

Монгол улсын ямааны тоо толгой /сая/




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол улсын түүхий ноолуурын бэлтгэл /мянган тонн/




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо /тооцооллын аргаар/

Түүхий эдийн дундаж үнэ /мянган төгрөг/



Эх сурвалж: Монголын ноос ноолуурын холбоо

Ноолуурын зах зээл /тэрбум төгрөг/



/Түүхий ноолуурын дундаж ханшаар тооцоолов/






ЗАСАГЛАЛ



## ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Говь ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм.

Бид олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекс, олон улсын сайн засаглалын туршлагаас суралцан засаглалын тогтолцоогоо тасралтгүй сайжруулан, холбогдох хууль дүрэм журмуудын хэрэгжилтийг ханган, улсдаа компанийн засаглалаар тэргүүлсэн үлгэр жишээ компани болохыг зорин ажилладаг.



Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийг томилдог бөгөөд ТУЗ нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдынхаа эрх ашгийг хангах, хөрөнгийн өгөөж үр ашгийг нэмэгдүүлэх, компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавин, оновчтой чиглүүлгээр ханган ажиллахыг зорьдог.

ТУЗ-ийн дэргэд Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Эрсдэл аудитын хороо гэсэн 3 хороо үйл ажиллагаа явуулан тус бүрийн чиг үүргийнхээ дагуу бодлогыг хэрэгжүүлэн компанийн Менежмент багийнхны үйл ажиллагаанд хяналт тавин дүгнэлт өгч, үр дүнгээ ТУЗ-д тайлагнан ажилладаг.

Эрсдэл аудитын хорооны харьяанд Дотоод аудитын хэлтсийг ажиллуулан компанийн хэмжээнд хараат бусаар дотоод хяналтыг хэрэгжүүлдэг.

ТУЗ-ийн харьяанд ТУЗ-ийн ажлын алба ажилладаг бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон ТУЗ-ийн мэргэжилтэн гэсэн 2 хүний бүрэлдэхүүнтэй. ТУЗ-ийн ажлын алба нь ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлын бэлтгэлийг ханган зохион байгуулах, олон нийтэд хүргэх мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангах, засаглалын бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, хэрэгжилтэд нь хяналт тавих, компанийн засаглалын асуудлыг хариуцах, хувьцаа эзэмшигч нарын санал хүсэлтийг хүлээн аван шийдвэрлэх, мэдээ мэдээллээр хангах гэсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

## ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО



Говь ХК нь урт хугацааны хөрөнгө оруулалт, санхүүгийн тогтвортой байдал, бизнесийн тасралтгүй байдлыг хангахад шаардлагатай итгэлцэл, ил тод байдал, хариуцлагын орчныг бүрдүүлж, бүхий л оролцогч талын эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангасан шударга, ёс зүйтэй засаглалын тогтолцоог бүрдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна.

Энэхүү бодлогодоо үндсэн 9 агуулгын хүрээнд зорилго зорилтуудаа дэвшүүлж, засаглалын хувьд баримтлах зарчмаа тодорхойлсон.

### Засаглалын зорилго, зорилтууд

1. Оролцогч талуудын эрх ашгийг хангах
2. ТУЗ-ийн зохистой бүтэц зохион байгуулалтыг бүрдүүлэх
3. Тайлагнал мэдээллийн ил тод байдлыг хангах
4. Шударга ёс зүйтэй үйл ажиллагааг явуулах
5. Хяналтын тогтолцоог бүрдүүлэх
6. Компанийн соёлыг төлөвшүүлэх
7. Цалин урамшууллын зохистой системийг бүрдүүлэх
8. Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг хөгжүүлэх
9. Компанийн засаглалыг сайжруулах

### Засаглалын зарчмууд

- Ил тод байдлыг хангах
- Бүх оролцогч талын эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангах
- Хууль, дүрэм журмыг мөрдөх
- Шударга, ёс зүйтэй байх
- Хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх
- Байгууллагын соёлыг төлөвшүүлэх
- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх
- Тасралтгүй сайжруулах

Бид 2023 онд компанийн сайн засаглалыг бэхжүүлэн сайжруулах зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийсэн.

**БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН БҮРДЛИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГООР ТУЗ-ӨӨС БАТАЛСАН БОДЛОГО, ЖУРМУУД**

**ШИНЭЧИЛСЭН**

- Эрсдлийн удирдлагын бодлого
- Эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааны бодлого
- ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам
- ТУЗ-ийн дэргэдэх 3 хорооны үйл ажиллагааны журам
- Гүйцэтгэх захиралтай байгуулах Менежментийн гэрээ
- Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам

**ШИНЭЭР БАТАЛСАН**

- Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр
- Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө
- Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам
- Цалин урамшууллын бодлого

**ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛГООР ХИЙГДСЭН АЖЛУУД**

- Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайланг 2 удаа хийн Санхүүгийн зохицуулах хороогоор хянан баталгаажуулалт хийлгэсэн. БОНЗ-ын үнэлгээний тайланг Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ын хавсралтын дагуу 2 дахь жилдээ хийхээс гадна Тогтвортой хөгжлийн тайланг анх удаа гарган Монголын хөрөнгийн бирж болон компанийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн.
- Компанийн засаглалын кодексийн зарчмын дагуу Жилийн тайланд орох мэдээлэл болон компанийн цахим хуудас дахь мэдээллийн агуулгыг сайжруулсан. ТУЗ-ийн гишүүдийн 2023 оны цалингийн төсвийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулсан.
- Шүгэл үлээх тогтолцоог хэрэгжүүлэн, тогтмол сайжруулалтыг хийж ажилласан.
- Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хангах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Хувьцаа эзэмшигчдийн үйлдвэртэй танилцах аяллыг 2 удаа зохион байгуулсан.
- Хувьцаа эзэмшигч нарын эрх, үүрэг оролцоог таниулах, компанийн талаарх мэдээллийг өгөх зорилгоор “Хувьцаа эзэмшигчдийн гарын авлага”-ыг боловсруулан олон нийтэд хүргэсэн.
- Хувьцаа эзэмшигч нарт компанийн цахим хуудсаар дамжуулан өөрийн бүртгэлээ шалгах, ногдол ашгийн үлдэгдлээ авах, санал хүсэлт илгээх, компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл болон тайлантай цаг алдалгүй танилцах боломжийг бүрдүүлсэн.
- Олон улсын хөрөнгө оруулагч нарт зориулан мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор компанийн цахим хуудсыг англи хэл дээр давхар ажиллуулж эхэлсэн.

**ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Говь ХК нь засаглалын бодлогын хүрээнд тодорхойлсон Оролцогч талуудын эрх ашгийг хангах зорилтыг хангах хүрээнд 2023 оны 11-р сард “Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө”-г ТУЗ-өөс баталсан.

**Удирдлагын төлөвлөгөөний үйл ажиллагааны зарчим**

Говь ХК нь бүхий л үйл ажиллагаа, төсөлдөө бүх талуудын оролцоог ижил түвшинд чухалчлан, үйл ажиллагааны ил тод байдлыг эрхэмлэн олон талт ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, нээлттэй бөгөөд харилцан хүндэтгэлтэйгээр санал бодлоо солилцон нийгэм, хүрээлэн буй орчин, оролцогч талуудад болон хийсэн үйлдэл, үр дүндээ хариуцлагатай хандаж, тогтвортой хөгжлийн зорилгод тэмүүлж ажиллана.

**Оролцогч талуудтай хамтран ажиллах удирдлагын зорилго**

- Үйлдвэр, үйл ажиллагааны ойролцоох оршин суугч иргэд, бэлтгэн нийлүүлэгчид болон малчид, хэрэглэгч, төр захиргааны байгууллага, судалгаа шинжилгээний байгууллага, төрийн бус байгууллага, хөрөнгө оруулагчид, банк санхүүгийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтай харилцан итгэлцэл, нээлттэй ил тод байдал, нэгдмэл сонирхолд үндэслэсэн тогтвортой харилцаа бий болгоно.
- Бэлтгэн нийлүүлэгч, малчдын чадавхыг бэхжүүлж, уламжлалд суурилсан байгальд ээлтэй, хүний эрхийг дээдэлсэн ахуй соёлын мэдлэгийг бий болгон, хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлнэ.

**ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ХАРИЛЦААНЫ ҮР ӨГӨӨЖ**

Д/д	Оролцогч талууд	Харилцааны үр өгөөж	Мэдээлэл түгээх аргууд
1.	Хэрэглэгчид (дотоод, гадаад, онлайн)	Бизнес болон түүний үйлчлүүлэгчид эсвэл худалдан авагчдын хооронд утга учиртай, интерактив харилцаа холбоог бий болгоход чиглэсэн стратеги, санаачилгууд дээр төвлөрнө. Энэ нь харилцаа холбоог хөгжүүлэх, онцгой туршлагыг бий болгох, Говь-иор таатай аялах нөхцөлийг бүрдүүлж, үйлчлүүлэгчдийг татан оролцуулж, тэдний сэтгэл ханамжийг хангах технологийг ашиглана.	Сурталчилгаа, шинэ бүтээгдэхүүний шоу, санал авах цахим уулзалт, үйлдвэрийн үйл ажиллагаа танилцуулах нээлттэй хаалганы өдөр, цахим хуудас
2.	Хөрөнгө оруулагчид (хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагч, ТУЗ)	Нээлттэй харилцаа холбоо, ил тод тайлан, идэвхтэй оролцоо нь итгэлцлийг бий болгох, хөрөнгө оруулалт татах, оролцогч талууд болон компанийн аль алинд нь урт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна.	Гүйцэтгэлийн тайлан хүргүүлэх, ганцаарчилсан болон бүлгийн уулзалт, жилийн тайлангийн хурал
3.	Санхүүгийн байгууллагууд (Банк, ББСБ, сан гэх мэт)	Үйл ажиллагааг оновчтой болгох, инновацид хөрөнгө оруулалт хийх, шинэ боломжуудыг ашиглахын тулд хүчтэй түншлэлийг бий болгох, санхүүжилтийг баталгаажуулах, санхүүгийн туршлагаа ашиглах зорилгоор бизнесээ өргөжүүлэх санхүүгийн байгууллагуудтай стратегийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	Ганцаарчилсан уулзалт, цахим хуудас, семинар

**ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ, ХАМТРАН АЖИЛЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2023-2025 ОН/**

4.	Төрийн байгууллагууд (яамд, агентлаг, алба, хэлтэс, ИТХ, ЗД)	Хамтарсан зорилго, бодлого, төслүүд дээр хамтран ажиллахын тулд орон нутгийн, бүс нутгийн, үндэсний зэрэг янз бүрийн түвшний төрийн байгууллагуудтай хамтран ажиллана. Энэ нь эерэг үр дүнд хүрэх, нийгэмд тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэх, патент, хуулбарлах эрх, хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн тулд үр бүтээлтэй харилцаа тогтоох, харилцан ашиг сонирхлыг хамгаалах, засгийн газрын нөөц, туршлагаас ашиглах ач холбогдолтой юм.	Олон нийтийн уулзалт, цахим хуудас, нийгмийн сүлжээний сувгууд
5.	Үйлдвэрийн ойролцоо оршин суугч иргэд	Мэдээллийг ил тод хуваалцах, эерэг өөрчлөлтийг бий болгох, нэгдмэл зорилгын мэдрэмжийг бий болгохын тулд олон нийттэй хамтран ажиллах, уур амьсгалын өөрчлөлт, ногоон хөгжлийн талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Олон нийтийн уулзалт, хэлэлцүүлэг, цахим хуудас, нийгмийн сүлжээний сувгууд, нээлтэй хаалганы өдөр
6.	Бизнесийн түншүүд, зах зээлийн өрсөлдөгчид	Инновацыг бий болгох, шилдэг туршлагыг хуваалцах, эрүүл өрсөлдөөнийг хадгалахын тулд салбараа хамтдаа урагшлуулахын тулд бизнесийн түншүүд болон өрсөлдөгчдийн оролцоог хангана. Энэ нь өсөлт, дэвшлийг дэмжихэд мэдлэг солилцох, стратегийн түншлэл, хамтын ажиллагааны санаачилгыг хөгжүүлнэ.	Бага хурал, хэлэлцүүлэг, туршлага солилцох аялал
7.	Бэлтгэн нийлүүлэгчид (малчин, хоршоо, компани)	Тогтвортой түншлэлийг дэмжих: Түүхий эдийн хариуцлагатай эх үүсвэрийг хангах, шударга худалдааны практикийг дэмжих, хамтын үнэ цэнийг бий болгох зорилгоор түүхий ноолуур бэлтгэн нийлүүлэгч хоршоодтой хамтын ажиллагаагаа бэхжүүлнэ. Энэ сэдвийн хүрээнд ил тод, нээлттэй харилцаа холбоо, чадавхыг бэхжүүлэх санаачилга, урт хугацааны түншлэл нь хоёр талын харилцан өсөлт, тогтвортой байдлыг бүрдүүлнэ.	Сургалт, үйлдвэр үйл ажиллагаа танилцуулах нээлттэй хаалганы өдөр, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, чадавхжуулах хөтөлбөр
8.	Гэрээт гүйцэтгэгчид	Говь компанийн нийлүүлэлтийн сүлжээгээрээ тогтвортой байдлыг хангахад чиглэсэн хамтын хүчин чармайлтыг онцолж, ёс зүйн практикийг бий болгох, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, хариуцлагатай эх үүсвэрийг хангах зорилгоор гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчидтэй идэвхтэй хамтран ажиллах зорилгоор гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчидтэй хамтран ажиллана.	Ганцаарчилсан хэлэлцүүлэг, санал асуулга, зорилтот бүлгийн семинар, ханган нийлүүлэгчдийг хөгжүүлэх хөтөлбөр
9.	Иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжлийн холбоод	Нийгэмд тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэх, бодлого боловсруулах, хамтын туршлага, нөлөөллийн хүчин чармайлт, стратегийн түншлэл ба олон нийтэд утга учиртай нөлөөллийг бий болгоход мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах, дэмжлэг авна.	Үйлдвэрийн үйл ажиллагаа танилцуулах нээлттэй хаалганы өдөр, сэдэвчилсэн семинар, ганцаарчилсан уулзалт, хамтарсан төсөл хөтөлбөр
10.	Хэвлэл мэдээлэл	Брэндийн харагдах байдал, харилцаа холбооны нөлөөллийн хувьд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй үр дүнтэй ажиллах нь бизнес болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн динамик харилцан үйлчлэлд төвлөрдөг. Энэ нь Говь компанийн брэндийн харагдцыг нэмэгдүүлэх, гол мессежүүдийг хүргэх, олон нийтийн ойлголтод нөлөөлөхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хэрхэн стратегийн холбоотой ажиллаж байгааг судлахад нөлөөтэй юм.	Ярилцлага, нэвтрүүлэг, контент боловсруулах, сонин сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх, цахим хуудас, олон нийтийн соён гэгээрлийн төсөл хөтөлбөр
11.	Эмзэг бүлэг	Нийгэмшихэд хувь нэмрээ оруулах, жендэрийн эрх тэгш боломжийг олгох, мэдээллийг сайжруулна.	Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, сургалт, төсөл хөтөлбөр зохион байгуулах, мэдээлэл хүргэх онцлог аргууд

Д/д	Оролцогч талууд	Зорилго	Харилцаа хамтын ажиллагаа	Давтамж
1.	Үйлдвэрийн үйл ажиллагааны ойр орчим оршин суугч иргэд, байгууллагын ажилтнууд	Үйл ажиллагааны тухай мэдээлэл хүргэх, санал гомдол хүлээн авч оролцогч талуудын итгэлцлийг бүрдүүлэх	Харьяалах хорооны удирдлагын ордонд Говь ХК-н Мэдээллийн самбар байршуулж, дараах мэдээллийг түгээх: <ul style="list-style-type: none"> <li>Үйл ажиллагааны ерөнхий мэдээлэл (худалдан авалт, хөдөлмөр эрхлэлт, төсөл хөтөлбөр)</li> <li>Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлын журам танилцуулах</li> <li>Санал, гомдол хүлээж авах, барагдуулах механизмыг танилцуулах</li> </ul>	Улирал, хагас жил
2.	Бэлтгэн нийлүүлэгчид (малчин, хоршоо, компани)	Түүхий эдийн чанарын шаардлагаас гадна, хүний эрх, байгаль орчин хамгаалах тухай мэдлэг олгож бүтээгдэхүүний хүн ба байгаль орчинд ээлтэй, органик нэр хүндийг баталгаажуулах	<ul style="list-style-type: none"> <li>Говь ХК-н үйл ажиллагаатай танилцах аялал зохион байгуулах</li> <li>Хүний эрх, байгаль орчин хамгаалах чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулах</li> <li>Санал, гомдол хүлээж авах, барагдуулах механизмыг танилцуулах</li> </ul>	Хагас жил, жилээр
3.	Гэрээт гүйцэтгэгчид, тэдний ажилтнууд	Зохистой хөдөлмөр эрхлэлтийн ойлголтыг төлөвшүүлж, хүний эрхийг хүндэтгэхэд хамтын чармайлт гаргах	<ul style="list-style-type: none"> <li>Гэрээт, гүйцэтгэгчийн менежментийн төлөвлөгөөг хэлэлцэж, баталгаажуулах, зохистой хөдөлмөр эрхлэлт ба байгаль орчны шаардлагуудыг гэрээнд оруулах, мөрдүүлэх</li> <li>Санал, гомдол хүлээж авах, барагдуулах механизмыг танилцуулах</li> </ul>	Тухай бүр
4.	Үйлчлүүлэгчид, хэрэглэгчид	Зохистой хэрэглээг сурталчлан таниулах, итгэлцлийг бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах</li> <li>Дэлгүүрүүдэд үйлчлүүлэгчийн мэдээллийн самбар ажиллуулах</li> <li>Санал, гомдол хүлээж авах, барагдуулах механизмыг танилцуулах</li> </ul>	Жилээр
6.	Эмзэг бүлэг	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бусад нийгмийн эмзэг бүлэгт нийгэмших зан үйлд дэмжлэг болох	<ul style="list-style-type: none"> <li>Нийгмийн нөлөөллийн ажлууд зохион байгуулах</li> <li>Тусгай зориулалтын сургууль, цэцэрлэгтэй хамтарч ажиллах</li> <li>Брэндингийн мэдээлэлд Браиль үсэг ашиглах боломж эрэлхийлэх</li> </ul>	Тухай бүр

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР

Говь ХК-ийн Засаглалын бодлогын хүрээнд дэвшүүлсэн Оролцогч талуудын эрх ашгийг хангах зорилтыг биелүүлэх, компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангах, хөрөнгө оруулагчдад компанийн талаарх үнэн зөв мэдээ мэдээллийг тогтмол хүргэх, тэдний оролцоог сайжруулах зорилгоор 2023 оны 4-р сард ТУЗ-өөс “Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр”-ийг баталсан. Тус хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна. Үүнд:

- Хөрөнгө оруулагч болон оролцогч талуудад мэдээлэл хүргэх, санал хүсэлт, гомдлыг хүлээн авах суваг, арга хэлбэрийг тодорхойлох, хөгжүүлэх;
- Компанийн санхүү, үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг үнэн зөв хоёрдмол агуулгагүйгээр цаг хугацаанд нь хүргэх;
- Хөрөнгө оруулагч нарын хөрөнгийн зах зээлтэй холбоотой суурь мэдлэг ойлголтыг сайжруулах, түгээмэл тулгардаг асуудлуудыг шийдвэрлэхэд туслах зорилгоор гарын авлагыг боловсруулан хүргэх;
- Хөрөнгө оруулагч нарыг компанийн үйл ажиллагаатай биечлэн танилцах боломжоор хангах зорилгоор үйлдвэртэй танилцах аяллыг зохион байгуулах;
- Гадаад хөрөнгө оруулагч нарт зориулан олон нийтэд хүргэх мэдээ мэдээллийг англи хэл болон нэмэлт шаардлагатай хэл дээр хүргэдэг болох;
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, мэдээлэх.

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НАРЫН ҮЙЛДВЭРТЭЙ ТАНИЛЦАХ АЯЛАЛ

Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн хүрээнд 2023 онд “Хувьцаа эзэмшигч нарын үйлдвэртэй танилцах аялал”-ыг 2023 оны 4-р сар болон 9-р сард 2 удаа зохион байгуулан хувьцаа эзэмшигч нарыг компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн процесстэй биечлэн танилцах боломжийг бүрдүүлсэн. Цаашид тус аяллыг жилд 2-оос доошгүй удаа тогтмол зохион байгуулахаар төлөвлөж байна.



### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НАРЫН ГАРЫН АВЛАГА



Хөрөнгө оруулагч нарын хөрөнгийн зах зээлтэй холбоотой суурь мэдлэг ойлголтыг сайжруулах, түгээмэл тулгардаг асуудлуудыг шийдвэрлэхэд туслах, хувьцаа эзэмшигч нарын эрх, үүрэг оролцоог таниулах, компанийн талаарх мэдээллийг өгөх зорилгоор “Хувьцаа эзэмшигч нарын гарын авлага”-ыг 2023 оны 9-р сард боловсруулан Монголын хөрөнгийн бирж болон компанийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн.

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны 3-р сард “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталсантай холбоотой хэрэгжилтийг нь үнэлэх зорилгоор 2022 оны 6-р сарын 22-ны өдөр “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж”-ийг баталсан.

Тус удирдамжийн үнэлгээний аргачлалын дагуу Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг 2023 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар ТУЗ-ийн ажлын алба үнэлсэн бөгөөд үнэлгээний үр дүнг Санхүүгийн зохицуулах хороо хянан баталгаажуулсан болно.

### ГОВЬ ХК-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН


Д/д	Гарчиг	Авбал зохих оноо	2022.12.31-ний байдлаар		2023.12.31-ний байдлаар		Өөрчлөлт хувь
			Өөрийн үнэлгээний оноо	Хэрэгжилт хувь	СЗХ-ны хяналтын оноо	Хэрэгжилт хувь	
1.	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10	83.3%	11	91.7%	8.4%
2.	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9	90.0%	9	90.0%	-
3.	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100.0%	6	100.0%	-
4.	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100.0%	6	100.0%	-
5.	Эрсдэлийн удирдлага	8	8	100.0%	8	100.0%	-
6.	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4	66.7%	6	100.0%	33.3%
7.	Оролцогч талуудын эрх ашиг	8	6	75.0%	8	100.0%	25.0%
8.	Компанийн соёл	6	6	100.0%	6	100.0%	-
9.	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	90.0%	10	100.0%	10.0%
Нэгдсэн дүн		72	64	88.9%	70	97.2%	8.3%

Нэгдсэн дүнгээс харахад Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ нь 2022 оны эцсээр 88.9% буюу дунд засаглалтай байсан бол 2023 оны эцсийн байдлаар дахин үнэлж, Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс хянан баталгаажуулалт хийсний үр дүнд 97.2% болж 8.3% өссөн буюу засаглал хэвийн, эрсдэлгүй гэж үнэлэгдсэн байна. /Монгол улс дахь нээлттэй хувьцаат компаниуд дотроо эхний байранд үнэлэгдэв./

Засаглалын үнэлгээний дэлгэрэнгүй тайлантай МХБ болон компанийн цахим хуудаснаас танилцах боломжтой.



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



\*Таван Богд Трейд ХХК нь 2024 оны 1-р сараас Таван Богд Холдингс ХХК болгон нэрээ өөрчилсөн болно.

## НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН НЭР	2022.12.31		2023.12.31	
	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь
Таван Богд Трейд ХХК	392,640,072	50.33%	400,140,072	51.29%
Хиде Интер ХХК	265,238,300	34.00%	265,238,300	34.00%

Тайлбар: Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч гэж компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.

**ХИДЕ ИНТЕР ХХК** нь Япон улсын хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани юм.

**ТАВАН БОГД ТРЕЙД ХХК** нь Таван Богд Группийн толгой компани ба 1997 онд Группийн хэмжээнд бодлого стратегийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон салбар компаниуддаа менежментийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан. Таван Богд Групп нь 20 охин компани, 2 хөрөнгө оруулалттай компани, нийт 12 мянга гаруй ажилтантайгаар бизнесийн салбар бүртээ манлайлан ажилладаг Монгол улсын тэргүүлэгч групп компани юм.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ АЖИЛТАН

Говь ХК нь 2021 оны 6-р сард "Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр"-ийг албан ёсоор эхлүүлсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд 2021 оны 7-р сарын 20-ны өдрийн байдлаар ажиллаж байсан ажилтнууддаа компанийнхаа хувьцааг эзэмшүүлсэн. Ингэснээр ажилтнуудын хувьд өөрийн гараар бүтээсэн баялгаасаа хувь хүртэж, сэтгэл хангалуун бөгөөд тогтвор суурьшилтай ажиллах хөшүүрэг болохоос гадна ажилтан бүрийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой юм.

2023 оны 12-р сарын 31-ний байдлаар компанийн 978 ажилтан 532,700 ширхэг буюу 0.07% хувьцааг эзэмшиж байна. Цаашид ТУЗ болон компанийн удирдлагуудын зүгээс энэхүү хөтөлбөрөө үргэлжлүүлэн тогтмол хэрэгжүүлэхээр төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

## НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

Д/д	КОМПАНИЙН НЭРС	Д/д	КОМПАНИЙН НЭРС
1	Таван Богд Трейд ХХК*	20	Таван Богд Резиденс ХХК
2	Таван Богд Интернэйшнл ХХК	21	Мон Бийф ХХК
3	Таван Богд Дистрибьюшн ХХК	22	Таван Богд Финанс ББСБ ХХК
4	Монгол Машин Концерн ХХК	23	Таван Богд Капитал ҮЦК ХХК
5	Таван Богд ХХК	24	Таван Богд Билдинг Саплай ХХК
6	Эйрлинк Монголиа ХХК	25	Таван Богд Мон Мийт ХХК
7	Улаанбаатар Гурил ХХК	26	Таван Богд Тэтгэврийн Хуримтлал ХХК
8	Жуулчин ХХК	27	Таван Богд Моторс ХХК
9	Жуулчин Дюти Фрий ХК	28	Гэрлүг Виста Сервис ХХК
10	Файв Старс Ин Хархорин ХХК	29	Таван Богд Нура ХХК
11	Хаан Палас ХХК	30	Ти Би Эм Өү ХХК
12	Сэргэлэн Резорт ХХК	31	Хаан Банк ХК
13	Таван Богд Фүүдс ХХК	32	Замайн Сервисиз ХХК
14	Таван Богд Фүүдс Пицца ХХК	33	Ар И Ди Эженси ХХК
15	Улаанбаатар Принт ХХК	34	Ток Ток ХХК
16	Таван Богд Фүүд Сервис ХХК	35	Дата Бэйнк ХХК
17	Таван Богд Солюшнс ХХК	36	Тэмүүжин Цогцолбор ХХК
18	Таван Богд Проперти ХХК	37	Жуулчин Туризм Корпорейшн ХХК
19	Таван Богд Хаус ХХК	38	Утаагүй Орчин ХХК

\*Таван Богд Трейд ХХК нь 2024 оны 1-р сараас Таван Богд Холдингс ХХК болгон нэрээ өөрчилсөн болно.

## ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Овог нэр	Иргэний харьяалал	Эзэмшлийн хувь	
			Хувь хүн	Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд
1	Цагаач БААТАРСАЙХАН	Монгол	0.006%	Таван Богд Трейд ХХК 51.29% Таван Богд ХХК 0.40% Таван Богд Капитал ҮЦК ХХК 0.04%
2	Хидэо САВАДА	Япон	-	Хиде Интер ХХК 34.00%

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд удирдлага юм.

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ АЖИЛТАН

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4-р сарын 20-ны өдрийн 10:00 цагт компанийн МҮХАУТ-ын Их Танхимд амжилттай зохион байгуулагдав.

#### Хурлын ирц

Хуралд урьдчилан санал өгөх арга хэлбэрээр нийт 284,381,205 (36.45%) саналын эрхтэй 829 хувьцаа эзэмшигч, хурлын өдөр биечлэн оролцох арга хэлбэрээр 406,030,659 (52.05%) саналын эрхтэй 68 хувьцаа эзэмшигч буюу нийт 690,411,864 саналын эрхтэй 897 хувьцаа эзэмшигч оролцсоноор хурлын ирц 88.50% болж бүрдэн хурал хүчин төгөлдөр явагдав.

#### Хурлаар танилцуулсан асуудал

1. Говь ХК-ийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайлан
2. 2022 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараахгүй тухай ТУЗ-ийн тогтоол
3. ТУЗ-өөс компанийн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлт
4. ТУЗ-ийн 2022 оны ажлын тайлан
5. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэх төсөл
6. ТУЗ-ийн 2023 оны цалингийн төсөв
7. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга

#### Хурлаас гарсан шийдвэр

Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлуудтай холбогдох тайлан илтгэлүүдийг сонсож, асуулт хариулт болон санал шүүмжлэлээ хэлэлцсэний эцэст саналын хуудсаар саналаа өгсөн бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах шийдвэрийг гаргав.

1. ТУЗ-өөс “Говь ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын баг 2022 онд төлөвлөгдсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан” гэсэн дүгнэлт өгснийг 99.99%-ийн саналаар батлав.
2. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох саналыг 99.98%-ийн саналаар батлав.
3. ТУЗ-ийн 2023 оны цалингийн төсвийг 99.99%-ийн саналаар батлав.
4. ТУЗ-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүдээр Д.Гэрэлмаа, Д.Хүрэлбаатар, А.Жаргалмаа, Такэши Камбэ нарыг, ТУЗ-ийн ердийн гишүүдээр Ц.Баатарсайхан, Д.Хулан, Б.Амарсайхан, Ц.Оргилболд, Хидэо Савада нарыг 3 жилийн хугацаатай томилов.



#### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАРДАЛ

/мянган төгрөг/

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2022	2023	Өөрчлөлт %
Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал	21,825	19,448	-11%

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

### ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

#### ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



Дамбын  
ГЭРЭЛМАА

ТУЗ-ийн дарга,  
Эрсдэл, аудитын  
хорооны гишүүн,  
Нэр дэвшүүлэх  
хорооны гишүүн

МЭРГЭЖИЛ  
Эдийн засагч

БОЛОВСРОЛ  
1982-1988 ЗХУ, Москва хотын Цахилгаан Холбооны Дээд Сургууль, Холбооны инженер эдийн засагч, бакалавр  
2000-2003 МУ-ын ЗГ-ийн хэрэгжүүлэгч агентлаг “Удирдлагын академи”, удирдахуйн ухааны доктор

ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
1988-1992 Радио Телевизийн Техникийн Төв, эдийн засагч  
1992-1994 Эдийн Засгийн Хөгжлийн Коллеж, Бизнес удирдлагын тэнхим, багш  
1994-2003 Эдийн Засгийн Хөгжлийн Коллеж, Бизнес удирдлагын тэнхим, тэнхимийн эрхлэгч  
2003-2006 Монгол Улсаас НҮБ-д суух Байнгын төлөөлөгчийн газар, Швейцарийн Холбооны улс дахь ЭСЯ, нягтлан бодогч  
2006-2009 СЭЗИС, Сургалт Эрдэм Шинжилгээ эрхэлсэн дэд захирал  
2009-2015 СЭЗИС, Сургалт эрхэлсэн дэд захирал  
2015 оноос СЭЗИС, Бизнес удирдлагын тэнхимийн профессор  
2022 оноос СЭЗИС, Ахисан Түвшний сургуулийн профессор  
**2013 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ  
Хувьцаа эзэмшдэггүй.



Дамбийжавын  
ХҮРЭЛБААТАР

Нэр дэвшүүлэх  
хорооны дарга,  
Цалин, урамшууллын  
хорооны дарга

МЭРГЭЖИЛ  
Нягтлан бодогч, Эдийн засагч, Санхүүч

БОЛОВСРОЛ  
1979-1981 Худалдааны Техникум, Нягтлан бодогч, бакалавр  
1985-1989 ОХУ-ын Байгалийн Улсын Их сургууль (Иркутск хотын УАААДС), Эдийн засагч, санхүүч магистр

ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
1981-1984 Улсын банк, Улсын байцаагч аудитор  
1990-2005 Худалдаа Хөгжлийн Банк, Харилцагчийн үйлчилгээний газрын захирал  
2005-2007 Монгол шуудан банк, Дэд захирал  
2008-2016 Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн  
2007-2020 Худалдаа Хөгжлийн Банк, Гүйцэтгэх захирлын орлогч  
2020-2022 Худалдаа Хөгжлийн Банк, ТУЗ-ийн ажлын албаны дарга  
**2022 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ  
4,800 ширхэг (0.0006%)



**МЭРГЭЖИЛ**  
Нягтлан бодогч

**БОЛОВСРОЛ**

2008-2012 Оксфорд Брүүксийн Их Сургууль, Нягтлан бодох бүртгэл, бакалавр  
2010-2012 ACCA Мэргэшлийн түвшний шалгалтууд, (Association of Chartered Certified Accountants)  
2012-2015 Санхүү Эдийн Засгийн Их сургууль, Бизнесийн удирдлага, магистр  
2013-2015 Хандонг Глобал Их Сургууль, Глобал менежмент, MBA

Алтангэрэлийн  
**ЖАРГАЛМАА**

Эрсдэл, аудитын  
хорооны дарга,  
Цалин, урамшууллын  
хорооны гишүүн

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

2012-2017 Багш, Санхүү Эдийн Засгийн их сургууль  
2013-2014 Итезмон ХХК, Нягтлан бодогч  
2014-2014 Иаруди Консалтинг ХХК, Зөвлөх  
2016-2018 Бурый мэдвэдь ХХК, Нягтлан бодогч  
2015-оноос Дүнгээ ХХК, Нягтлан бодогч  
2017 оноос GAPE (Global Academy for Professional Education), ACCA ахлах багш, хөтөлбөрийн удирдагч  
**2019 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**  
Хувьцаа эзэмшдэггүй.



**МЭРГЭЖИЛ**  
Эдийн засагч

**БОЛОВСРОЛ**

1978-1981 Япон улс, Кэйогийн Их Сургууль, Эдийн засгийн ухаан, бакалавр  
1981-1985 Япон улс, Кэйогийн Их Сургууль, Эдийн засгийн ухаан, магистр

Такэши  
**КАМБЭ**

Цалин, урамшууллын  
хорооны гишүүн

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

1985-1986 Япон улс, Asahi Mutual Life Insurance компани, хүний нөөцийн менежер  
1986-1989 Нагано салбарын захиргааны менежер, Киото салбарын худалдааны менежер  
1989-1992 Японы хамтын ажиллагааны банкны Гадаадын хамтын ажиллагааны эдийн засгийн фондын зээлийн мэргэжилтэн, Азийн хөгжлийн банк болон Дэлхийн Банкны хамтран Бангладеш, Шриланк, Мянмар улсуудад хэрэгжүүлсэн төслүүд дээр ажилласан  
1992-1995 Азийн даатгалын компанийн Олон улсын хөрөнгө оруулалтын газрын хөрөнгө оруулалтын санхүүжилт зээлийн менежер  
1995-1998 Хонгконг дахь азийн хөрөнгө оруулалтын удирдагч  
1999-2000 Азийн даатгалын хамтарсан компанийн Удирдлагын зөвлөлийн дарга  
2000-2002 Азийн үл хөдлөх хөрөнгө ХХК-ийн зээлийн болон судалгаа шинжилгээний менежер  
2002-2006 Азийн даатгалын хамтарсан компанийн жижиг дунд корпорацуудад арилжааны зээл олгох асуудлыг хариуцсан менежер  
2006 оноос Азийн даатгалын хамтарсан компанийн үл хөдлөх хөрөнгийн арилжааны хяналтын менежер  
**2008 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**  
Хувьцаа эзэмшдэггүй.

**ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮД**



**МЭРГЭЖИЛ**  
Инженер

**БОЛОВСРОЛ**

1984-1988 Монгол улс, Политехникийн Их Сургууль, Холбооны инженер, бакалавр  
1989-1993 Япон улс, Токио хотын Цахилгаан Холбоо, Электроникийн Их Сургууль, Электроникийн инженер, бакалавр

Цагааачийн  
**БААТАРСАЙХАН**

Гүйцэтгэх захирал

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

1993-1997 Япон Монголын хамтарсан Алтай компанид гүйцэтгэх захирал  
1997 оноос Таван Богд Группийн ерөнхийлөгч, Таван Богд Трейд ХХК-ийн ерөнхий захирал,  
2001-2003 МИАТ компанийн дэд ерөнхийлөгч  
2008 оноос Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал  
2009 оноос Хаан Банкны ТУЗ-ийн гишүүн  
**2007 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**

Хувь хүн: 50,000 ширхэг (0.006%)  
Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:  
Таван Богд Трейд ХХК 400,140,072 ширхэг (51.29%)  
Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%) Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)



**МЭРГЭЖИЛ**

Олон улсын банк санхүү

**БОЛОВСРОЛ**

1985-1990 Орос улс, Москвагийн Санхүүгийн Дээд Сургууль, Олон улсын банк санхүү, бакалавр

Дашдаваагийн  
**ХУЛАН**

Эрсдэл, аудитын  
хорооны гишүүн

**ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

1990-1992 Монгол Улсын Сангийн Яам, Эдийн засгийн гадаад харилцааны хэлтэс, Эдийн засагч  
1993-1997 Говь ХК, Токио дахь салбар, Төлөөлөгч, худалдааны менежер  
1997-2000 Таван Богд Трейд ХХК, Дэд захирал  
2000-2002 Худалдаа Хөгжлийн Банк, Дэд захирал  
2003-2021 Таван Богд Групп, Тэргүүн дэд ерөнхийлөгч  
2003-2021 Хаан Банкны ТУЗ-ийн гишүүн  
2009 оноос Люксембург улсын Монгол дахь өргөмжит консул  
2021 оноос Хаан Банкны ТУЗ-ийн Дэд дарга  
2021 оноос Таван Богд Группийн ТУЗ-ийн дарга  
**2007 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

**ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ**

Хувь хүн: 12,973,022 ширхэг (1.66%)  
Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:  
Таван Богд Трейд ХХК 400,140,072 ширхэг (51.29%)  
Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)  
Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)



Баатарсайханы  
**АМАРСАЙХАН**

Цалин, урамшууллын  
хорооны гишүүн

Стратеги, өсөлт  
хөгжил хариуцсан  
захирал

#### МЭРГЭЖИЛ

Бизнесийн удирдлага ба энтрепренершип

#### БОЛОВСРОЛ

2016 - 2019 Их Британи улс, Вестминистр Их Сургууль, Бизнесийн удирдлага ба энтрепренершип, бакалавр

#### ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2019 - 2023 Говь Кашмер Европ ХХК-ийн Гүйцэтгэх захирал  
2022 оноос Говь Кашмер Их Британи ХХК-ийн Гүйцэтгэх захирал  
2022 оноос Таван Богд Трейд ХХК-ийн Стратеги, бизнес хөгжил хариуцсан захирал  
2022 оноос Говь ХК-ийн Стратеги, өсөлт хөгжил хариуцсан захирал  
**2023 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

#### ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ

Хувь хүн: 1,000 ширхэг (0.0001%)  
Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:  
Таван Богд Трейд ХХК 400,140,072 ширхэг (51.29%)  
Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)  
Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)



Цогтгэрэлийн  
**ОРГИЛБОЛД**

Нэр дэвшүүлэх  
хорооны гишүүн

Тэргүүн дэд захирал  
/Гадаад борлуулалт/

#### МЭРГЭЖИЛ

Олон улсын харилцаа

#### БОЛОВСРОЛ

2011-2014 Япон улс, Temple Их Сургууль, Олон улсын харилцаа, бакалавр

#### ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2014 Эдийн засгийн хөгжлийн яам-д Чөлөөт бүс хариуцсан мэргэжилтэн  
2016 Таван Богд Трейд ХХК-д Бизнес хөгжлийн менежер  
2016-2017 Жуулчин Дюти Фрий ХК-д Гүйцэтгэх захирал  
2017-2019 Гоёо ХХК-д Гүйцэтгэх захирал  
2019-2021 Говь ХК-д Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал  
2021-2022 Саппорт Сервисес Монголиа ХХК-д Дэд захирал  
2022 оноос Говь ХК-д Тэргүүн дэд захирал  
2023 оноос Говь Кашмер Европ ХХК-ийн Гүйцэтгэх захирал  
**2023 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

#### ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ

Хувь хүн: Хувьцаа эзэмшдэггүй.  
Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд:  
Таван Богд Трейд ХХК 400,140,072 ширхэг (51.29%)  
Таван Богд ХХК 3,140,239 ширхэг (0.40%)  
Таван Богд Капитал ҮЦК ХХК 278,030 ширхэг (0.04%)



Хидэо  
**САВАДА**

#### МЭРГЭЖИЛ

Эдийн засагч

#### БОЛОВСРОЛ

1973-1976 Герман улс, Майнзын Их Сургууль, Эдийн засагч, бакалавр

#### ХӨДӨЛМӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1980-1996 Интернейшнл түүрс компанийн үүсгэн байгуулагч, захирал  
1996-1999 Австралийн Вотээмак зочид буудлын эзэн, Skymark Airlines компанийн үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга  
1999-2001 Н.И.С ХК-ийн Ерөнхийлөгч  
2000 Skymark ХК-ийн Ерөнхийлөгч  
2002 Н.И.С аялал жуулчлалын компанийн Ерөнхийлөгч  
2003-2021 Хаан банкны ТУЗ-ийн дарга  
2004 оноос Н.С ХК-ийн Ерөнхийлөгч  
**2009 оноос Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүн**

#### ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИЛ

Хувьцаа эзэмшдэггүй.  
Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд: Хиде Интер ХХК 265,238,300 ширхэг (34.00%)

## ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ

Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дуусгавар болсон тул тус хурлаар ТУЗ-ийн гишүүнийг томилох тухай асуудлыг хэлэлцсэн. Хурлын үр дүнд ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Баяр болон ТУЗ-ийн ердийн гишүүн Ж.Оюунчимэг нар ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөн ТУЗ-ийн ердийн гишүүнээр Б.Амарсайхан болон Ц.Оргилболд нар шинээр сонгогдсон.

## ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ, ТОМИЛОХ

Говь ХК нь компанийн дүрэмдээ заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал хураах кумулятив аргаар сонгон 3 жилийн хугацаатай томилдог.

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зүгээс ТУЗ-ийн гишүүдийн идэвх оролцоо, ажлын тайлан, гүйцэтгэлтэй танилцан, компанийн урт хугацааны стратеги төлөвлөлт, бизнесийн чиг хандлагатай уялдуулан ТУЗ-ийн гишүүдийг улираан нэр дэвшүүлэх, эсхүл бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах эсэх шийдвэрийг хэлэлцэн гаргадаг.

Говь ХК-ийн "ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам"-ын дагуу Нэр дэвшүүлэх хорооны зүгээс ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж шийдвэрлэсэн тохиолдолд ердийн болон хараат бус гишүүдийн тоо, шинээр нэр дэвшүүлэх хараат бус гишүүдийн хэрэгцээ, мэргэжил, ур чадварын нэмэлт шалгуурыг тодорхойлон, сонгон шалгаруулалтыг зохион байгуулдаг. Хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг нээлттэй байдлаар, эсвэл өмнөх сонгон шалгаруулалтад оролцсон нэр дэвшигчдээс сонгон шалгаруулах гэсэн арга хэлбэрээс сонгон явуулдаг. Улмаар нэр дэвшигчдэд үнэлгээ хийн, хэлэлцэн, дүгнэлт гаргасны үндсэн дээр нэр дэвшигчдийн жагсаалтыг батлан гаргадаг.

Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгох хүртэл ТУЗ-ийн шийдвэрээр түр томилж, хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хурлаар оруулж батлуулдаг. Түр томилогдсон гишүүн нь хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан байх ба ТУЗ-ийн гишүүний бүх эрх, үүргийг эдэлнэ.

## ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооноос тодорхойлон санал боловсруулж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг. Говь ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин сар бүр олгох тогтмол цалин болон хурлын оролцоонд үндэслэсэн цалин гэсэн бүтэцтэй байдаг.

2023 оны 4-р сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг дараах байдлаар тогтоосон.



## 2023 ОНЫ ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

ТУЗ-ийн цалин урамшуулал	2022 он гүйцэтгэл	2023 он		Өөрчлөлт %	
		Төсөв	Гүйцэтгэл	2022Г/2023Г	2022Т/2023Г
Тогтмол цалин	128,400	161,200	161,200	25.5%	0.0%
Оролцооны цалин	34,500	41,800	37,200	7.8%	-11%
Урамшуулалт цалин	10,000	-	-	-	-
НДШ	22,513	30,450	25,485	13.2%	-16.3%
<b>Дүн</b>	195,413	<b>233,450</b>	<b>223,885</b>	14.6%	-4.1%

## ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ЗАРЧИМ

Цалин, урамшууллын хорооны 2023 оны эцсийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалин, хангамж, урамшууллын зарчмыг хэлэлцэж дараах байдлаар тодорхойлсон.

- ТУЗ-ийн гишүүд нь компанийн санхүү, үр дүнгээс хамаарсан аливаа урамшуулал авахгүй.
- ТУЗ-ийн хараат бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагыг үнэлэх зорилгоор хараат бус гишүүдийн үндсэн цалинг ердийн гишүүдийнхээс өндөр байлгана.
- Компанийн Менежмент багт ажилладаг ТУЗ-ийн ердийн гишүүд нь ТУЗ-ийн гишүүний хувьд аливаа хангамжийг давхар авахгүй.

Энэхүү зарчмын дагуу 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн хараат бус гишүүдийн үндсэн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр төлөвлөж байна.

## ТУЗ-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Хурал	Ээлжит хурал	Ээлжит бус хурал	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр	Санал зөвлөмж	Үүрэг даалгавар	Баталсан тогтоол
ТУЗ-ийн хурал	6	10	59	51	19	25	41
Эрсдэл, аудитын хорооны хурал	4	1	24	17	17	5	5
Нэр дэвшүүлэх хорооны хурал	2	1	18	14	7	6	3
Цалин урамшууллын хорооны хурал	2	-	13	8	4	1	-
<b>Нийт</b>	<b>14</b>	<b>11</b>	<b>114</b>	<b>90</b>	<b>47</b>	<b>37</b>	<b>49</b>

Говь ХК-ийн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2023 онд нийт 14 ээлжит хурал болон 11 ээлжит бус хурал зохион байгуулж гишүүд идэвх санаачилгатай ажиллан нийт 114 асуудлыг хэлэлцэн, 90 шийдвэр гаргаж, 49 тогтоол баталсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 47 санал зөвлөмж, 37 үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилт дээр нь хяналт тавьж анхаарч ажиллав. ТУЗ-ийн шийдвэр болон удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын биелэлт 100% хэрэгжилттэй байв.

### ХУРЛЫН ИРЦ

№	ТУЗ-ийн гишүүний нэр	ТУЗ-ийн хорооны харьяалал	ТУЗ-ийн хурлын ирц	ТУЗ-ийн хорооны хурлын ирц
1.	Д.Гэрэлмаа	Эрсдэл, аудитын хорооны гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	100%	100%
2.	Д.Хүрэлбаатар	Нэр дэвшүүлэх хорооны дарга, Цалин, урамшууллын хорооны дарга	100%	100%
3.	А.Жаргалмаа	Эрсдэл аудитын хорооны дарга, Цалин, урамшууллын хорооны гишүүн	100%	100%
4.	Такэши Камбэ	Цалин урамшууллын хорооны гишүүн	100%	100%
5.	Ц.Баатарсайхан	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн /2023 оны 5-р сар хүртэл/	100%	100%
6.	Д.Хулан	Эрсдэл, аудитын хорооны гишүүн	100%	100%
7.	Б.Амарсайхан	Цалин урамшууллын хорооны гишүүн	100%	100%
8.	Ц.Оргилболд	Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	100%	100%
9.	Хидэо Савада	-	100%	-

Тайлбар: Япон улсад байдаг хоёр гишүүд ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурлын мэдээллийг цаг тухай бүрд нь и-мэйлээр хүлээн авч, саналаа цахим шуудангаар илгээдэг. Тиймээс хурлын ирцийг оролцооноор тооцдог.

### ХУРЛЫН ДАВТАМЖ

**Ээлжит хурал:** ТУЗ-ийн хурал 2 сард нэг удаа буюу жилд 6 удаа, Эрсдэл, аудитын хорооны хурал улиралд нэг удаа буюу жилд 4 удаа, Нэр дэвшүүлэх хорооны хурал хагас жилд нэг удаа буюу жилд 2 удаа, Цалин урамшууллын хорооны хурал хагас жилд нэг удаа буюу жилд 2 удаа хуралддаг.

**Ээлжит бус хурал:** ТУЗ болон хороодын ээлжит бус хурлыг ТУЗ-ийн дарга, гишүүд, компанийн Гүйцэтгэх захирал болон Менежмент багийн гишүүдийн санаачилга, шаардлагаар хэдийд ч хуралдуулж болно.

## ТУЗ-ИЙН 2023 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Говь ХК-ийн ТУЗ нь 2023 онд 6 ээлжит хурал, 10 ээлжит бус хурал зохион байгуулж 59 асуудлыг хэлэлцэн, 51 шийдвэр гаргаж, 41 тогтоол баталсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 19 санал зөвлөмж, 25 үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилт дээр нь хяналт тавьж чиглүүлэн ажиллав.

2023 онд ТУЗ-ийн зүгээс компанийн санхүү, үйл ажиллагаанд хяналт тавих, чиглүүлэх чиг үүргийн хүрээнд оны эхний хурал дээр компанийн бизнес төлөвлөгөөг баталж сар бүр санхүү, үр дүнгийн тайлангаар дамжуулан төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллахаас гадна 4-р сард Компанийн дунд хугацааны стратегийн төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. Мөн БОНЗ-ын үйл ажиллагааны хүрээнд хяналт удирдлагаа сайжруулан БОНЗ-ын хүрээнд хийгдсэн ажлын тайлантай 3 удаа танилцаж, ТУЗ-өөс баталсан тогтвортой хөгжлийн үүрэг амлалтынхаа хэрэгжилтэд хяналт тавин, удирдлагын багийг чиглүүлэн ажиллалаа.

Бид Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг сайжруулах, хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшигч нарынхаа эрх ашгийг хангах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 4-р сард "Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр"-ийг, 11-р сард "Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө"-г тус тус батлав. Мөн шинэчилсэн кодексийн дагуу ТУЗ-ийн дэргэдэх 3 хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж, хороодын үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталсан.

ТУЗ-ийн нэг чухал үүрэг бол хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах, тэдний эрх ашиг зөрчигдөхөөс сэргийлэх явдал бөгөөд ТУЗ-ийн зүгээс "Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам"-ыг 11-р сард баталж, компанийн хэмжээнд хийгдэж буй аливаа хэлцлийг хуулийн дагуу хийгдэж байгаа дээр хяналт тавьж, сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг тухай бүр Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэн олон нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлсэн.

Говь ХК нь 2023 онд компанийн соёлыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг шат дараатай авч хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ТУЗ-ийн зүгээс эдгээр арга хэмжээг дэмжин, шаардлагатай төсөв хөрөнгийг баталж, ажлын байрны тав тухтай орчныг бүрдүүлэх, цалинг үе шаттай нэмэгдүүлэх дээр анхаарч ажиллалаа.



## ТУЗ-ИЙН БОЛОН ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ


Говь ХК нь ТУЗ-ийн үйл ажиллагаагаа тогтмол сайжруулах зорилгоор 2015 оноос хойш жил бүр ТУЗ-ийн өөрийн үнэлгээг хийж байна. Мөн ТУЗ-ийн үнэлгээнээс гадна ТУЗ-ийн гишүүний өөрийн үнэлгээг 2018 оноос эхлэн хийж заншсан. Тус үнэлгээний асуулгуудыг Нэр дэвшүүлэх хорооноос компанийн засаглалын олон улсын сайн туршлага, зарчим дээр үндэслэн боловсруулсан.

Бид жил бүр ТУЗ-ийн болон ТУЗ-ийн гишүүний өөрийн үнэлгээг хийснээр ТУЗ-ийн үйл ажиллагаагаа дүгнэн, давуу тал болон эрсдэлтэй, сайжруулах шаардлагатай зүйлсээ тодорхойлон цаашдын төлөвлөгөөг боловсруулж, улмаар тасралтгүй сайжруулалтыг хийн ажиллаж байна.

### ТУЗ-ИЙН ҮНЭЛГЭЭ

ТУЗ-ийн үнэлгээ нь ТУЗ-ийн бүрэлдэхүүнтэй холбоотой 4 асуулт, ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой 16 асуулт, ТУЗ ба засаглалтай холбоотой 10 асуулт буюу 3 бүлэг бүхий 30 асуулт, нөхөж бичих 1 чөлөөт асуултаас бүрддэг.

№	Шалгуур	2022 он		2023 он	
		Оноо	Хувь	Оноо	Хувь
I	<b>ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН (4 асуулт)</b>	4.4	88%	<b>4.2</b>	<b>84%</b>
II	<b>ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА (16 асуулт)</b>	4.5	90%	<b>4.8</b>	<b>97%</b>
	1. Хурал	4.6	92%	<b>4.7</b>	<b>94%</b>
	2. ТУЗ-ийн дэргэдэх хороод	4.3	85%	<b>4.7</b>	<b>94%</b>
	3. ТУЗ-ийн дарга	4.6	92%	<b>4.9</b>	<b>98%</b>
	4. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	4.7	93%	<b>5.0</b>	<b>100%</b>
III	<b>ТУЗ БА ЗАСАГЛАЛ (10 асуулт)</b>	4.5	84%	<b>4.6</b>	<b>93%</b>
	<b>Нийт дундаж</b>	4.3	87%	<b>4.6</b>	<b>94%</b>




2023 оны хувьд ТУЗ-ийн бүрэлдэхүүний үнэлгээ 84% буюу өмнөх оноос 4% буурсан бол ТУЗ-ийн үйл ажиллагаа 97% болж өмнөх оноос 7%, ТУЗ ба засаглал гэсэн бүлгийн үр дүн 93% болж 9% өссөн бөгөөд ТУЗ-ийн нийт дундаж үнэлгээ 94% болж өмнөх оноос 7% өссөн үзүүлэлттэй байна.

### ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ ҮНЭЛГЭЭ

ТУЗ-ийн гишүүний үнэлгээ нь ТУЗ-ийн гишүүний үүрэг, оролцоотой холбоотой 15 асуулт, ТУЗ-ийн үйл ажиллагаа болон компанийн үйл ажиллагаатай холбоотой өөрийн санаачилж хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнтэй холбоотой нөхөж бичих 1 чөлөөт асуултаас бүрддэг.

ТУЗ-ийн гишүүд өөрсдийгөө жил бүр үнэлснээр өөрийн давуу болон сул талыг олж харах, цаашид анхаарч ажиллах үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлж дүгнэхээс гадна Нэр дэвшүүлэх хорооны зүгээс ТУЗ-ийн гишүүдийнхээ үйл ажиллагааг дүгнэх нэгэн үзүүлэлт болдог. 2023 оны хувьд ТУЗ-ийн гишүүдийн өөрийн үнэлгээний дундаж 89% болж өмнөх оноос 4% өссөн үр дүнтэй байна.



### ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ОРОЛЦОО

Говь ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүд нь оны эхэнд тухайн жилд анхаарч ажиллах чиглэлээ тодорхойлж, төлөвлөгөө гаргадаг бөгөөд оны эцэст компанийн болон ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой өөрийн санаачилж хэрэгжүүлсэн ажлын үр дүнгээ дүгнэн хэлэлцдэг. Бид ТУЗ-ийн хараат бус гишүүдийнхээ оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2022 оноос эхлэн хараат бус гишүүдийн хурлыг жилд 1 удаа тогтмол зохион байгуулж байгаа бөгөөд 2023 оны 12-р сард ТУЗ-ийн хараат бус гишүүд хуралдан үйлдвэрлэлийн процесстой нарийн танилцаж, компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хараат бусаар хэлэлцэн, үйл ажиллагаанд саналаа тусган ажилласан.

## ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ТАЙЛАН

### НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

#### ЗОРИЛГО

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь ТУЗ-ийг Эрх бүхий албан тушаалтнууд буюу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад Менежмент багийн удирдлагуудын залгамж халааны тогтвортой байдлыг хангах, тэдгээрийн ажил үүргийн тодорхойлолт, гэрээний нөхцөлийг тодорхойлох, ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч хяналт тавин, чиг удирдлагаар хангах гэсэн үндсэн чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

Нэр дэвшүүлэх хороо нь Компанийн засаглалын кодексийн дагуу 2023 оны 8-р сард хорооны үйл ажиллагааны журмаа шинэчлэн баталж, тус хорооны чиг үүрэгт ЭБАТ-уудтай холбоотой шүгэл үлээх системээр ирүүлсэн мэдээллийг шийдвэрлэх чиг үүргийг нэмж оруулав.

#### БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга:

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
Д.Хүрэлбаатар

Гишүүд:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа  
ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Оргилболд

#### Хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт:

2023 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотой ТУЗ-ийн 2023.05.18-ны №17 тоот тогтоолоор Нэр дэвшүүлэх хорооны гишүүн Ц.Баатарсайханы оронд ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Оргилболдыг томилов.

### 2023 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Нэр дэвшүүлэх хороо нь 2023 онд 2 удаа ээлжит хурал зохион байгуулж, 18 асуудлыг хэлэлцэн, 14 шийдвэр гаргав. Хорооны чиг үүргийнхээ хүрээнд 7 төрлийн санал зөвлөмж, 6 үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтнуудад өгч, хяналт тавьж ажилласан бөгөөд 3 тогтоол батлав.

2023 оны эхний хурлаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нэр дэвшүүлэх ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрсийг тодорхойлон баталж, 4-р сарын хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг 3 жилийн хугацаатай сонгон томилов.

Энэ онд тус хороо нь Гүйцэтгэх захиралтай байгуулах Менежментийн гэрээний нөхцөлийг шинэчлэн ТУЗ-ийн хурлаар гэрээний загварыг батлуулж, Гүйцэтгэх захиралтай гэрээг шинэчлэн байгуулсан. Мөн 2023 оны ТУЗ-ийн өөрийн үнэлгээ болон ТУЗ-ийн гишүүний өөрийн үнэлгээг хийж, үр дүнд нь үндэслэн ТУЗ болон хороодын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд цаашид гүйцэтгэх ажлуудыг оны эцсийн хурлаар хэлэлцэв.

ЭБАТ-уудын ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч хяналт тавих чиг үүргийн хүрээнд Менежмент багийн удирдлагуудын хагас жилийн болон жилийн тайлантай танилцаж, тус тайланд Гүйцэтгэх захирлаас өгсөн дүгнэлттэй танилцан үйл ажиллагаа сайжруулах зөвлөмжийг өгөв. Менежмент багийнхны жилийн тайлан болон гүйцэтгэлд үндэслэн хамт олноо манлайлан удирдаж, амжилттай ажилласан хоёр удирдлагыг ТУЗ-ийн нэрэмжит шагналд нэр дэвшүүлэн, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шагнав.


Мөн компанийн шүгэл үлээх системээр ЭБАТ-уудтай холбоотой ирсэн мэдээллийг тухай бүр шийдвэрлэн холбогдох удирдлагуудад санал зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавруудыг өгч хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

## ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос Компанийн засаглалын кодексийн дагуу Эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааны бодлогыг боловсруулан 2023 оны 2-р сарын ТУЗ-ийн хурлаар батлуулсан.

Энэхүү бодлогын зорилго нь Говь ХК-ийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах томоохон хүчин зүйл болсон Эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааны тогтвортой байдлыг хадгалахад баримтлах бодлогыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх арга зам болсон зорилтууд, баримтлах зарчим болон гэнэтийн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход оршино.

**Эрх бүхий албан тушаалтан (ЭБАТ):** Компанийн дүрмээр тодорхойлсны дагуу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, дэд захирлууд, газрын захирлууд, хуулийн зөвлөх, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог удирдах албан тушаалтнуудыг хэлнэ.



#### Залгамж халааны бодлого

- Нэр дэвшүүлэх хороо болон Хүний нөөцийн газар нь компанийн дотоод болон гадаад зах зээлийн өөрчлөлт, бизнесийн урт хугацааны стратеги төлөвлөгөө, өсөлт хөгжилтэй уялдуулан ЭБАТ-уудад тавигдах шаардлага, мэдлэг мэргэжил, ур чадварын шалгуурыг оновчтой тодорхойлно.
- Нэр дэвшүүлэх хороо болон Хүний нөөцийн газар нь ЭБАТ-уудыг сонгон шалгаруулахад баримтлах зарчим, шалгуур үзүүлэлт, залгамж халааг бэлтгэх төлөвлөгөө болон ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулалт хийнэ.
- Компанийн зүгээс ЭБАТ-уудыг тогтвор суурьшилтай сэтгэл ханамжтай ажиллах нөхцөл, ажлын байран дээр өсөж дэвших боломжоор хангана.
- ТУЗ нь энэхүү бодлогын хэрэгжилтийг хангах замаар удирдах албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүй байдлаар өөрчлөгдсөнөөс үүдэн хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудын эрх ашиг хохирох эрсдэлтэй нөхцөл үүсгэхгүйн тулд ЭБАТ-уудын залгамжлагч хүний нөөцийн бэлэн байдлыг тогтмол бүрдүүлж, компанийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хадгалах зохистой тогтолцоог бүрдүүлнэ.

Мөн тус бодлогод залгамж халааны бодлогыг хэрэгжүүлэх зорилт, баримтлах зарчим, гэнэтийн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үүрэг хариуцлага зэргийг тодорхойлон оруулсан бөгөөд ТУЗ болон компанийн удирдлагуудын зүгээс хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

## ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

### ЗОРИЛГО

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь ТУЗ-ийг Эрх бүхий албан тушаалтнууд буюу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад Менежмент багийн удирдлагуудыг цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг тодорхойлох, Компанийн хэмжээнд баримтлах Цалин, урамшууллын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

Цалин, урамшууллын хороо нь Компанийн засаглалын кодексийн дагуу 2023 оны 8-р сард хорооны үйл ажиллагааны журмаа шинэчлэн баталсан.

### БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга:

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
Д.Хүрэлбаатар

Гишүүд:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Такэши Камбэ  
ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Жаргалмаа  
ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Амарсайхан

#### Хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт:

Компанийн засаглалын кодексийн “ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга нь ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн байна” гэсэн зарчмын дагуу ТУЗ-ийн 2023.05.18-ны №17 тоот тогтоолоор Цалин, урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Хүрэлбаатарыг томилов. 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотой тус хорооны гишүүнээр ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Амарсайханыг томилов. Мөн хорооны үйл ажиллагаанд хараат бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ТУЗ-ийн 2023.12.22-ны №39 тоот тогтоолоор тус хорооны гишүүнээр ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Жаргалмааг нэмж томилов.

## 2023 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Цалин урамшууллын хороо нь 2023 онд 2 удаа ээлжит хурал зохион байгуулж, 13 асуудлыг хэлэлцэн 8 шийдвэр гаргав. Хорооны чиг үүргийнхээ хүрээнд 4 төрлийн санал зөвлөмж, 1 үүрэг даалгаврыг холбогдох албан тушаалтнуудад өгч, хяналт тавьж ажиллав.

Энэ онд тус хороо нь ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэх санал боловсруулж 2023 оны 4-р сарын хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлуулахаас гадна 2023 оны ТУЗ-ийн цалингийн төсвийг нээлттэй хэлэлцэн батлуулсан.

Мөн хорооны хагас жилийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн цалин, хангамж, урамшууллын зарчмыг хэлэлцэн, ТУЗ-ийн гишүүд нь компанийн санхүү, үр дүнгээс хамаарсан аливаа урамшуулал авахгүй бөгөөд ТУЗ-ийн хараат бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагыг үнэлэх зорилгоор хараат бус гишүүдийн үндсэн цалинг ердийн гишүүдийнхээс өндөр байлгах, компанийн Менежмент багт ажилладаг ТУЗ-ийн ердийн гишүүд нь ТУЗ-ийн гишүүний хувьд аливаа хангамжийг давхар авахгүй байхаар тодорхойлсон.

Компанийн хэмжээнд баримтлах цалин, урамшууллын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг тодорхойлон, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийнхээ хүрээнд байгууллагын соёлын судалгаа, ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, түүнийг сайжруулах чиглэлээр хийгдсэн ажлуудтай танилцахаас гадна компанийн цалин урамшууллын гүйцэтгэлд хяналт тавьж, оны сүүлийн хурал дээр 2024 оны цалин урамшууллын төсөв болон компанийн Цалин, урамшууллын бодлогыг шинэчлэх төслийг хэлэлцэн ТУЗ-өөр батлуулсан.

## ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооноос Цалин, урамшууллын бодлогыг 2016 онд анх баталж байсан бол шинэчилсэн Компанийн засаглалын кодексийн дагуу тус бодлогыг шинэчлэн боловсруулж 2024 оны 1-р сарын ТУЗ-ийн хурлаар батлуулсан.

Энэхүү бодлогын зорилго нь Говь ХК-ийн хэмжээнд баримтлах цалин хөлс, урамшууллын зарчмыг тодорхойлж Эрх бүхий албан тушаалтнууд болон нийт ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтолцооны үндсийг тодорхойлоход оршино.

### Говь ХК-ийн цалин, урамшууллын бодлого

Компанийн дотоод, гадаад зах зээлийн өөрчлөлт, бизнесийн урт хугацааны стратеги төлөвлөгөө, өсөлт хөгжил, санхүүгийн үр ашиг болон ажилтнуудын ажлын үр дүн, бүтээмжтэй уялдсан цалин, урамшууллын зохистой бөгөөд үр дүнтэй тогтолцоотой байна.


### Цалин, урамшууллын зорилт

- Ажиллах орчныг тасралтгүй сайжруулан, ажилтнууд ур чадвараа хөгжүүлэх, сурч хөгжих, хөдөлмөрөө шударгаар үнэлүүлэх, тогтвортой, сэтгэл ханамжтай, аз жаргалтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх замаар компанийн соёлын судалгааны дундаж үзүүлэлтийг жил бүр зөв зохистой түвшинд нэмэгдүүлнэ.
- Хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн өсөлтийн зохистой харьцааг инфляцын түвшин болон бодит цалингийн өсөлттэй уялдуулна.
- Компанийн цалин, урамшууллын зардлыг компанийн үр ашигтай жил бүр уялдуулан төлөвлөнө.

### Цалин, урамшууллын зарчим

- Бизнесийн үйл ажиллагаа, стратеги зорилттой уялдуулах,
- Зах зээлд өрсөлдөхүйц байх,
- Ижил тэгш байх,
- Инфляцын түвшин болон бодит цалингийн өсөлтийг уялдуулах,
- Шударга, ил тод байх,
- Шинийг эрэлхийлэн, тасралтгүй сайжруулах.

### Цалин, урамшууллын тогтолцоо





## ЭРСДЭЛ, АУДИТЫН ХОРОО

### ЗОРИЛГО

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны хяналтын тогтолцооны үр дүнтэй байдалд хяналт тавих, чиглүүлэх, дотоод хяналт, комплаенс болон эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр дүнтэй байдалд хяналт тавих, чиглүүлэх, хараат бус аудитын байгууллагатай харилцан, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжоор хангах гэсэн үндсэн 3 чиг үүргийг хэрэгжүүлж ТУЗ-ийг эрсдэлийн удирдлага болон компанийн үйл ажиллагаа дахь хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Эрсдэл, аудитын хороо нь шинэчилсэн Компанийн засаглалын кодексийн дагуу 2023 оны 8-р сард хорооны үйл ажиллагааны журмаа шинэчлэн, тус хорооны чиг үүрэгт комплаенсын удирдлагын тогтолцооны хяналтын чиг үүргийг нэмж оруулав.

### БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга:

ТУЗ-ийн хараат бус гишүүн  
А.Жаргалмаа

Гишүүд:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмаа  
ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Хулан

#### Хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт:

2023 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотой ТУЗ-ийн 2023.05.18-ны №17 тоот тогтоолоор Эрсдэл, аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Жаргалмааг, хорооны гишүүнээр ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлмааг томилов.

## 2023 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН


Эрсдэл аудитын хороо нь 2023 онд 4 удаа ээлжит хурал, 1 ээлжит бус хурал зохион байгуулж, 24 асуудлыг хэлэлцэн, 17 шийдвэр гарган 5 тогтоол баталсан. Хорооны чиг үүргийнхээ хүрээнд 17 төрлийн санал зөвлөмж, 5 үүрэг даалгавруудыг холбогдох албан тушаалтнуудад өгч, хэрэгжилтийг хангуулан, хяналт тавьж ажиллав.

Энэ онд тус хороо нь компанийн дотоод хяналт, комплаенс, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд Дотоод аудитын хэлтсийн ажлын тайлантай улирал бүр, Эрсдэлийн удирдлагын багийн ажлын тайлантай хагас жил тутам, Комплаенсын удирдлага, үйл ажиллагааны тайлантай 1 удаа танилцаж компанийн хэмжээнд хэрэгжүүлсэн дотоод аудитын ажлын үр дүн, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө, түүний мониторингийн үр дүнтэй танилцаж удирдамжаар ханган ажилласан. Мөн "Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам", "Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны журам"-ыг шинэчлэх төслийг хэлэлцэн, санал зөвлөмжийг өгч Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулсан.

Мөн 2022 оны санхүүгийн тайлан, НББ-ийн талаар хараат бус аудиторын дүгнэлт зөвлөмжтэй танилцаж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан бөгөөд 2023 оны хөндлөнгийн аудиторын сонгон шалгаруулалтад хорооны гишүүдийн зүгээс хараат бус байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг хийж, үнийн саналтай танилцан санал өгч оролцон ТУЗ-ийн хурлаар Кэй Пи Эм Жи Аудитыг дахин сонгов.

## ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Манай компани дотоод хяналтын тогтолцоондоо "Хамгаалалтын гурван шугам" загварын дагуу зохион байгуулалтыг хийж, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна. Энэ загвар нь шат шатны удирдлагууд өдөр тутмын төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, хянах, зохицуулах үндсэн чиг үүргүүдээ хэрэгжүүлэн ажиллахад ач холбогдолтой байдаг.



## ДОТООД ХЯНАЛТЫН БОДЛОГО

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооноос Дотоод хяналтын бодлогын баримт бичгийг боловсруулан 2022 оны 10-р сарын ТУЗ-ийн хурлаар батлуулсан.

Энэхүү бодлогын зорилго нь компанийн үйл ажиллагааг үр дүнтэй эрхлэн явуулахтай холбоотой дараах харилцааг зохицуулах, нягтлан шалгах, хяналт тавихад оршино. Үүнд:

- Компанийн үйл ажиллагааг хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журмын дагуу үр ашигтайгаар удирдан явуулах,
- Компанийн эд хөрөнгийг хамгаалах, найдвартай байдлыг хангах,
- Ашиглан, залилангийн үйлдэл болон алдаанаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, засах,
- Нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах,
- Үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, бодитоор бэлтгэн гаргах,
- Эрсдэлийг тогтмол хянах, удирдах.

Говь ХК нь дотоод хяналтыг Бүх ажилтан, Нэгжийн удирдлага, Гүйцэтгэх удирдлагын баг, Дотоод аудитын хэлтэс, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороо, ТУЗ, Хөндлөнгийн аудит гэсэн шатлалтайгаар хэрэгжүүлнэ.

Дотоод хяналтын бодлогын баримт бичигт эдгээр оролцогч талуудын эрх, үүргийг тусган оруулсан бөгөөд ТУЗ нь ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хороогоор дамжуулан компанийн дотоод хяналтын үйл ажиллагаанд хяналт тавина.

## ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

### ЗОРИЛГО

Дотоод аудитын зорилго нь компанийн засаглалын үйл явц, эрсдэлийн удирдлагын үр нөлөөтэй байдал, дотоод хяналтын үр ашигт байдалд үнэлгээ хийх тэдгээрийн байнгын сайжруулалтад дэмжлэг үзүүлэх замаар байгууллагын үнэ цэнийг хамгаалах, нэмэгдүүлэхэд оршино. Үйл ажиллагаандаа Олон улсын дотоод аудиторудын институтийн батлан гаргасан ёс зүйн дүрэм, үндсэн зарчмууд болон дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

### БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дотоод аудитын үйл ажиллагаа нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны харьяанд Дотоод аудитын хэлтэс гэсэн бүтэцтэйгээр үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна. Эрсдэл, аудитын хороо нь Дотоод аудитын дүрэм, стратеги зорилт, эрсдэлд суурилсан аудитын төлөвлөгөө, нөөцийн төсвийг батлах, хэлтсийн даргыг томилж цалин урамшууллыг тогтоохоос гадна аудитын төлөвлөгөөний гүйцэтгэл, үйл ажиллагаанд хяналт тавьж, Дотоод аудитын бие даасан, хараат бус байдлыг баталгаажуулдаг.

### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Компанийн зорилго, зорилтууддаа хүрэхийн тулд шийдвэр гаргалт, бодлого тодорхойлолт, бизнесийн болон дэмжих ажиллагааны процессууд, комплаенс болон тайлагналын үйл ажиллагааг хамруулан хуваарилагдсан үүрэг хариуцлагыг биелүүлж, чанартай гүйцэтгэл гаргаж байгаа эсэхийг баталгаажуулдаг.

### 2023 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

- Баталгаажуулах ажлаар нийт 98 анхаарах асуудлыг дэвшүүлэн үүсэж болох эрсдэл, шалтгааныг тодорхойлон, шийдвэрлэх санал, зөвлөмжөөр хангаж ажилласан.
- Мониторингийн ажлаар 9 багц бүхий 76 зөвлөмжийн хэрэгжилтийг эргэн дүгнэсэн. Илэрсэн асуудлуудыг шийдвэрлэх, эрсдэлийг бууруулах, үр дүнг сайжруулах талаар хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлэхийг чухалчилсан.
- Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх удирдлагаас санал авч хэлэлцэн гүйцэтгэдэг бөгөөд шаардлагатай санал зөвлөмжийг хүргүүлж, хамтран ажилласан.
- Компанийн засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхэд үнэлж, компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, тасралтгүй сайжруулах талаар зөвлөмж, дэмжлэгийг өгсөн.
- Дотоод аудитын чанарын баталгаажуулалтын дотоод үнэлгээг өөрсдөө хийж, дотоод аудитын үйл ажиллагаанд анхаарах асуудлуудыг тодорхойлон сайжруулалтыг хийсээр ажиллаж байна.

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

### ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооноос Эрсдэлийн удирдлагын бодлогыг анх 2018 онд баталж байсан бол компанийн үйл ажиллагааны процесс, цар хүрээтэй уялдуулан бодлогыг шинэчлэн боловсруулж, 2023 оны 2-р сарын ТУЗ-ийн хурлаар батлуулсан.

Энэхүү бодлогын зорилго нь Говь ХК-ийн ерөнхий үзэл баримтлал, чиглэлд нийцтэй эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, оролцогчдын эрх үүргийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлэх, хэрэгжилтэд мониторинг хийж, тасралтгүй сайжруулж, Удирдлагын баг болон нэгжүүдийн ажиллах үндсэн зарчим, эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

### ЗОРИЛГО

Эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь эрсдэл өгөөжийн харьцаатай уялдуулан бизнест учирч болох аливаа эрсдэлийг тодорхойлох, хэмжих, хянах үйл явцаар компанийн ашигт ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх явдал юм. Энэхүү үйл явц нь байгууллагын тасралтгүй ашигт ажиллагаанд чухал ач холбогдолтой бөгөөд компанийн ерөнхий үзэл баримтлал, үнэ цэнд нийцтэй удирдлагын тогтолцоог амжилттай хэрэгжүүлэн, тасралтгүй сайжруулна.

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлснээр бизнесийн эрсдэлийн орчныг тасралтгүй хянах, сайжруулах боломжийг бий болгож, ажилтнуудын эрсдэлийн талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулан, удирдлагын түвшинд стратегийн оновчтой шийдвэр гаргах, бизнесийн зорилго, зорилтыг дэмжихэд болон бизнест тулгарах алдагдал, хохирол, хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэхэд тусалдаг.

#### Эрсдэлийн удирдлагын зарчим

- Үнэт зүйлийг бий болгох ба хамгаалах,
- Засаглалын зохистой бүтцийг хэрэгжүүлэх,
- Байгууллагын үйл явцын салшгүй хэсэг байх,
- Шийдвэр гаргалтын нэг хэсэг байх,
- Ил тод ба оролцоог хангасан байх,
- Эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх,
- Тасралтгүй сайжруулах.

#### Эрсдэлийн удирдлагын засаглал

Говь ХК-ийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь засаглал, хэрэгжүүлэлт гэсэн үндсэн хоёр түвшин бүхий "Гурван давхар хамгаалалтын шугам"-аар зохицуулагддаг.

Эрсдэлийн засаглалын үүрэг хариуцлага болон нэгдсэн хяналтыг хэрэгжүүлэх нь ТУЗ-ийн үндсэн зорилгуудын нэг юм. Иймд компанид эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэгч нь ТУЗ, түүний дэргэдэх Эрсдэл, аудитын хороо байна.

Компанид эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэгч нь эрсдэлийн удирдлагын баг байх бөгөөд Гүйцэтгэх захирал багийн бүрэлдэхүүнийг томилно. Эрсдэлийн менежер нь эрсдэлийн удирдлагын багийн гишүүн байх бөгөөд нэгжийн удирдлагууд нь эрсдэлийг хариуцагч байна гэж тус бодлогод заасан байдаг. Манай компанийн эрсдэлийн удирдлагын багийг компанийн удирдах албан тушаалтнууд бүрдүүлж байгаа бөгөөд Тогтвортой хөгжлийн хэлтсийн дарга ахлан ажиллаж, эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд эрсдэл хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний дагуу улирал бүр хянах байдлаар эрсдэлийг удирддаг бөгөөд үр дүнгээ Эрсдэл, аудитын хороонд тайдагнадаг.

**Эрсдэлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт**



**Эрсдэлийн хүлээн зөвшөөгдөх хэм хэмжээ**

Компанийн үйл ажиллагааг явуулахад хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинг илэрхийлэх бөгөөд жил бүр Эрсдэл, аудитын хорооос эргэн хянаж, шинэчилдэг. Эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх хэмжээг эрсдэлийн төрлөөр, хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшнийг дулааны матрицын аргаар (чанар) болон эрсдэлийг хэмжих индикатор үзүүлэлтээр (тоон) тодорхойлно.

Стратегийн эрсдэл	Компанийн хэрэгжүүлэх санаачилгууд үр ашиггүй, бүтээмжгүй болох эрсдэлийг <b>дунд хэмжээнд</b> хүлээн зөвшөөрнө.
Нийцлийн эрсдэл	Компанийн зайлшгүй дагаж мөрдөх, хууль эрхзүйн болон компанийн дүрэм, журам, заавар, шаардлагуудыг санаатайгаар, зориудаар зөрчихийг хатуу хориглоно. Үүнээс үүдэх эрсдэлийг <b>үл хүлээн зөвшөөрнө</b> .
Санхүүгийн эрсдэл	Компанийн санхүүгийн тогтворгүй байдалтай холбоотой эрсдэлийг <b>дунд хэмжээнд</b> хүлээн зөвшөөрнө.
Үйл ажиллагааны эрсдэл	Компанийн үйл ажиллагааны эрсдэлийг нь <b>бага хэмжээнд</b> хүлээн зөвшөөрнө. Мэдээллийн технологийн эрсдэлийг <b>маш бага хэмжээнд</b> хүлээн зөвшөөрнө. Ёс зүйгээс үүдэн гарах эрсдэлийг <b>маш бага хэмжээнд</b> хүлээн зөвшөөрнө. Санаатайгаар болон зориудаар ёс зүйн дүрмийг зөрчсөн бол компани ямар ч тохиолдолд <b>үл хүлээн зөвшөөрнө</b> .
Давагдашгүй эрсдэл	Давагдашгүй хүчин зүйлээс үүсэх эрсдэлийг <b>дунд хэмжээнд</b> хүлээн зөвшөөрнө.

**Бизнесийн тасралтгүй үйл ажиллагаа**

Говь ХК нь 2022 онд “Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны бодлого”, “Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны журам”-ыг боловсруулан батлуулав.

Энэхүү журмын зорилго нь компанийн бизнесийн үйл ажиллагаанд учирч болох аливаа нөлөөлөх хүчин зүйл, давагдашгүй хүчин зүйл, цар тахлын үед авах шаардлагатай арга хэмжээг боловсронгуй болгон, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааг түргэн шуурхай зохион байгуулах, нөөцийн бэлэн байдлыг хангаж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хадгалах, нөхөн сэргээхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэхэд оршино.

Говь ХК нь дээрх баримт бичгүүдийг боловсруулан батлуулж, цаашид голлох эрсдэлүүдэд бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахаар зорьж ажиллаж байна.

Байгууллага тасралтгүй үйл ажиллагааны төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхийн тулд эрсдэлийн удирдлагыг хүлцэх чадвартай уялдуулан удирдаж хэвших нь чухал юм. Учир нь бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө нь эрсдэлийн удирдлага, хүлцэх чадвар нь тус тусдаа хэрэгжих ойлголт бус бөгөөд харилцан бие биедээ уялдаатай байдаг байна. ISO22301 бизнесийн тасралтгүй ажиллагааны менежментийн явцад бизнес хэрхэн ажилладаг, алдаа дутагдал хаана гарч болох талаар тодорхой ойлголтыг бий болгож, сайжруулах цэгүүдийг тодорхойлж чадна.



## ЭРСДЛИЙН УДИРДЛАГЫН 2023 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

### Баримт бичиг

Говь ХК нь эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо улам бататган сайжруулж, "ISO/IEC31000:2018" стандарт, "Хамгаалалтын гурван шугам" загвар, олон улсын мэргэжлийн байгууллагын зөвлөмж зэрэг олон улсын тэргүүн туршлагын дагуу байгууллагын баримт бичгүүддээ өөрчлөлт оруулах үндэслэлийг тодорхойлж, "Эрсдэлийн удирдлагын бодлого", "Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам"-даа холбогдох сайжруулалтуудыг хийн, шинэчлэн батлуулав.

### Эрсдэлийн удирдлагын баг

Эрсдэлийн удирдлагын шинэчилсэн журмын дагуу эрсдэлийн мониторингийг жилд 2 удаа хийж байхаар өөрчлөн, байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг 2023 оны 1-р улирлын Эрсдэл аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн хагас жилээр тайлагнахаар болж, шийдвэрийн дагуу тайлагнан ажиллалаа. Эрсдэлийн удирдлагын багийн бүрэлдэхүүний хувьд байгууллагын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн дагуу тухай бүр томилгоог шинэчлэн батлуулсан.

### Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилт

Байгууллагын эрсдэлийн удирдлагын календарийн дагуу нийт газар, үйлдвэр, нэгжүүд учирч болзошгүй эрсдэлүүдээ тодорхойлох, үнэлэх, удирдах, хяналт мониторинг хийх, тайлагнах буюу тогтолцооны үе шатуудыг бүрэн хэрэгжүүлж, эрсдэлээс үүсэх үр нөлөөг хамгийн бага түвшинд байлгахад удирдан ажилласаар байна.

### Эрсдэлийн аппетит болон хүлцэх чадвар

Энэ оны хувьд байгууллагын хэмжээнд нийт нэгжүүд эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй байлгаж, сайжруулах зорилгоор "Эрсдэлийн аппетит" болон "Хүлцэх чадвар"-ыг олон улсын ахисан түвшний арга, аргачлалд тулгуурлан, бүртгэлтэй эрсдэл бүрийн хэмжих үзүүлэлтийг тогтоож, холбогдох хүлцэх чадварын босго утгуудыг зааж өгсөн.

### Эрсдэлийн соёлыг түгээн дэлгэрүүлэх

Эрсдэлийн удирдлагын соёлын төлөвшүүлэх зорилгын хүрээнд 2023 онд байгууллагын "Эрсдэлийн удирдлагын баг" болон нийт "Эрсдэл хариуцагч" нарт эрсдэлийн удирдлагын ерөнхий ойлголт, аргазүйн сургалтыг тус тус зохион байгуулав.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын шинэчилсэн календарийн дагуу эрсдэлийн удирдлагын тогтолцооны үе шат бүрийг үр дүнтэй гүйцэтгэхэд дэмжлэг болох үүднээс эрсдэл хариуцагч нарт Эрсдэлийн удирдлагын багаас тухай бүр тухайн газар, үйлдвэр, нэгжийн эрсдэл бүр дээр газар дээр болон зайнаас ойлголт болон аргазүйн зөвлөгөөг өгч, хэрхэн удирдах амжилттайгаар хамтран ажиллалаа.


Нийт ажилтны эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг ойлголтыг бататгаж, түгээх зорилгоор байгууллагын дотоод сүлжээнд "Эрсдэлийн удирдлага" гэсэн цэсийг нэмж, мэдээлэл зөвлөмжөөр ханган, ажил үүргээ гүйцэтгэх явцад эрсдэл бүхий нөхцөл байдал эсвэл ирээдүйд эрсдэл учруулж болох нөхцөл анзаарагдсан үед эрсдэлийн тухай мэдээлэх сувгийг зааж өгсөн.

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ҮР ДҮН

2023 оны 1-р сарын байдлаар удирдах арга хэмжээ авах шаардлагатай **432** эрсдэл (2022 оны мониторингоор үлдсэн нийт 239 эрсдэл, 2023 оны эхэнд эрсдэлийн үнэлгээгээр шинээр бүртгэгдсэн 193 эрсдэл) байсан бөгөөд дундаж оноо нь 7 буюу **ДУНД** түвшинд байв. Тайлант хугацааны туршид бид эрсдэлийн дундаж оноог оны эцэс гэхэд **БАГА** түвшинд хүргэнэ гэсэн зорилттой ажилласан.

		Үр нөлөө					Эрсдэлийн түвшин	Тоо	Эзлэх %
		Маш бага	Бага	Дунд	Их	Маш их			
		1	2	3	4	5			
Магадлал	Маш их	5	8	15	17	0	1	0.23%	
	Их	4	12	20	16	9	0	12.27%	
	Дунд	3	33	24	41	8	3	43.52%	
	Бага	2	41	22	17	12	6	28.70%	
	Маш бага	1	66	23	27	7	4	15.28%	
<b>Нийт</b>							<b>432</b>	<b>100%</b>	

2023 оны эрсдэлийн мониторингийн арга хэмжээ:



Эрсдэл удирдах хариу арга хэмжээний төлөвлөлт боловсруулан хэрэгжүүлж, үүн дээр эхний хагас жилийн эрсдэлийн үнэлгээгээр шинэ эрсдэлүүд нэмэгдэн 2023 оны 4-р улирлын эцэс гэхэд нийт 554 эрсдэл бүртгэлтэй байснаас 246 эрсдэлийг бусад эрсдэлд нэгтгэж, 69 эрсдэл бүрэн хаагдаж, 239 эрсдэл болж буурсан бөгөөд дундаж оноо нь 3 буюу БАГА түвшинд байна.

## ГЭНЭТИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Байгууллагын хэмжээнд 2023 онд нийт 4 удаагийн гэнэтийн эрсдэлийн үнэлгээ хийгдэн Эрсдэлийн удирдлагын багаар хуралдаж хэлэлцсэн. Үүнд:

1. Зуны улиралд үер усны эрсдэл улсын хэмжээнд нүүрлэн, Говь ХК-ийн объектууд эрсдэл бүхий бүст байсан тул холбогдох эрсдэлийн үнэлгээг хийн, сэргийлэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, эрсдэлийг ямар нэгэн хохиролгүйгээр даван гарсан.
2. Амьтны эрхийг хамгаалах байгууллагаас (PETA) Монголын ноос ноолуурын үйлдвэрүүдийн нэрийг цохон ямаа самнах үйл ажиллагааг шүүмжилсэн нийтлэлийг 7-р сард нийтэлсэн. Үүнтэй холбогдуулан Говь ХК-нд учирч болох нөлөөллийг үнэлэн, хэлэлцсэн.
3. Хүйтний улирал эхэлсэн үеэр Хятад улсад томуу, вирусын халдварт өвчлөлийн тоо нэмэгдэж эхэлсэн бөгөөд үүнтэй холбогдуулан эрсдэлийн үнэлгээ хийн, мэдээлэл бэлтгэж Эрсдэлийн удирдлагын баг болон Эрсдэл хариуцагч нарт мэдээлэл хүргэсэн.
4. Өвлийн улирлын эрчим хүчний оргил ачааллын үеэр буюу 2023 оны 12-р сард ОХУ-с Монгол улс руу нийлүүлэх эрчим хүчний тасалдал үүсэх магадлал бий болсонтой холбогдуулан эрсдэлийн үнэлгээ хийж, холбогдох газар, үйлдвэр, нэгжүүд Эрчим хүчний хэмнэлтийг төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан.

## НИЙЦЛИЙН УДИРДЛАГА

Говь ХК нь бизнесийн үйл ажиллагаагаа хууль дээдлэх, шударга байх, хариуцлагатай байх, ил тод нээлттэй байх, ёс зүйтэй байх зарчмыг баримтлан явуулдаг бөгөөд тогтвортой хөгжлийн бодлого, зорилтод ёс зүйн нийцлийг тодотгон тусгаж, энэ хүрээнд авч буй арга хэмжээг нийцлийн удирдлагаар зохицуулдаг. Нийцлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх нь ажилтан, харилцагч болон дотоод гадаад хөрөнгө оруулагчдын итгэл үнэмшлийг бэхжүүлж, учирч болохуйц эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Манай компани 2022 оны 4 сард Комплаенсын бодлого, зорилтуудыг батлан, 2022 оны 8 сард Ёс зүйн кодоо шинэчлэн баталсан билээ. Говь ХК-ийн ёс зүйн код дараах зарчмуудыг агуулдаг:



## 2022 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД

- “Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам”, “Ёс зүйн кодын хэрэгжилтийг зохицуулах журам”-ыг шинэчлэн батлуулав.
- “Ёс зүйн код” болон холбогдох журмуудын мэдлэг, ойлголт өгөх 849 хүн/цагийн сургалт оров.
- Нийцлийн менежер болон Ёс зүйн хорооны гишүүд мэдлэг, ур чадвар сайжруулах сургалтуудад хамрагдав.  
Компанийн “Шүгэл үлээх систем”-ийг шинэчлэв.
- Ёс зүйн хорооны сонгууль зохион байгуулж, хороог 13 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэв.
- Ёс зүйн код, Шүгэл үлээх тогтолцооны танилцуулга, гарын авлагыг ажилтнуудад хүргэв.  
Нийт 43 баримт бичигт нийцлийн хяналт хийв.

## ШҮГЭЛ ҮЛЭЭХ УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Говь ХК 2022 онд байгууллагын үйл ажиллагааны ёс зүйн доголдлыг эрт үед нь илрүүлэх гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, засаж сайжруулах, ажилтны байгууллагадаа итгэх итгэлийг бэхжүүлэх зорилгоор “Шүгэл үлээх удирдлагын тогтолцоо”-г нэвтрүүлж, шүгэл үлээх системийг <http://info.gobi.mn/whistleblowing> ашиглалтад оруулсан.


Дээрх системд ирсэн мэдээллийг хамрах хүрээнээс нь шалтгаалан Төлөөлөн удирдах зөвлөл, Нэр дэвшүүлэх хороо, Ёс зүйн хороо шууд хүлээн авч, аливаа ёс зүйн зөрчлийг илрүүлэх, шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх, сайжруулах, шударга тогтолцоог ханган ажиллахаар зохицуулагдсан.

Ёс зүйн хорооны баг нь нийт ажилтны төлөөллөөс нээлттэй сонгуулийн зарчмаар сонгогдсон, тал бүрийн мэдлэг, ур чадвар, туршлага бүхий ажилтнуудаас бүрдсэн. Ингэснээр олон талт ялгаатай байдлыг эрхэмлэж ёс зүйн хэм хэмжээг түгээн нийт ажилтнуудад илүү нээлттэй ойр байх нөхцөл бүрдсэн.

Цаашид Ёс зүйн хороо болон Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааг сайжруулах, хянах ба нийт ажилтнуудад ёс зүйн хэм хэмжээг таниулах ажлуудыг тогтмол хийхээр төлөвлөж байна.

### 2022.11-2023.12 сарын хооронд шүгэл үлээх системд нийт 74 шүгэл ирсэн бөгөөд 100% шийдвэрлэн ажиллав.

Шүгэл үлээх системд ирсэн зөрчлүүдийг хүлээн авсан суваг, төрөл болон шийдвэрлэсэн байдлаар авч үзвэл:



1. Ёс зүйн хороо, Нэр дэвшүүлэх хорооноос зөвлөмж, шийдвэр хүргэгдсэн	48	65%
2. Байгууллагын холбогдох газар нэгж болон шууд удирдлагад шилжүүлсэн	10	14%
3. Хуулийн байгууллагад шилжүүлсэн	1	1%
4. Өөрийн хүсэлтээр буцаасан	4	5%
5. Нотлох баримт хангалтгүй гэж буцаасан	7	9%
6. Хүлээгдэж байгаа	4	7%
<b>Нийт</b>	<b>74</b>	<b>100%</b>

## ЧАНАРЫН УДИРДЛАГА

Говь ХК нь түүхий эдийг малчдын гараас хүлээн авахаас эцсийн бэлэн бүтээгдэхүүн хүртэлх бүхий л шат дамжлагад 230 үзүүлэлтээр чанарын шалгалтыг хийж, технологийн горимыг чанд мөрдөн, бүтээгдэхүүнээ үндэсний болон олон улсын стандартын шаардлагын дагуу үйлдвэрлэж, баталгаажуулан дотоод, гадаад, онлайн сувгаар хэрэглэгчдэд хүргэдэг.


Бид хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхээр үйлдвэрлэлийн шат дамжлага бүрдээ чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэн, үндэсний 85 MNS стандарт, компанийн 18 бодлого, 6 дүрэм, 152 журам, технологийн горим, 47 ажлын заавар, зааварчилгаа, 14 гарын авлагыг мөрдөж, чанарын хяналт шалгалтыг 100% хийж, чанарын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулан ажиллаж байна.



2023 оны 5-р сард ISO 9001:2015 стандартын баталгаажуулалтын аудитад орж гэрчилгээгээ гардан авсан. Говь ХК нь хэрэглэгчдэд стандартын шаардлагыг хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж байгааг нотлон харуулж буй хэрэг юм.



Говь ХК-ийн Анхан шатны үйлдвэр нь 2023 онд Англи улсад төвтэй "Тогтвортой ноос ноолуурын эвсэл" буюу SFA байгууллагын "Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал"-ын тохирлын үнэлгээнд 3 дахь удаагаа амжилттай хамрагдсан. Энэ нь анхан шатны үйлдвэртээ түүхий эд ангилах, угаах, самнах явцдаа хүний нөөцийн менежмент, хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчиндоо ээлтэйгээр тогтвортой арга зарчмыг баримтлан үйлдвэрлэж буйгаа хэрэглэгчид, харилцагчдадаа нотлон харуулж буй хэрэг юм.



Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийг эрхлэхэд баримтлах үндсэн зарчим, шаардлагуудыг тогтоох, тэдгээрийг үнэлэх, баталгаажуулах MNS 6926:2021 "Текстилийн тогтвортой үйлдвэрлэл" Монгол улсын стандартын магадлан үнэлгээнд амжилттай оролцсон. Говь ХК-ийн үйл ажиллагааг байгальд ээлтэй, зөв засаглалтай, хүнд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, менежментийн зөв тогтолцоог үйлдвэрлэлийнхээ шат дамжлага бүрд бий болгон ажиллаж буйг ахин баталгаажуулав.



"Монголын хаан ширхэгт" тохирлын гэрчилгээ Говь ХК-ийн үйлдвэрлэж буй Самнасан ноолуур, Сүлжмэл бүтээгдэхүүнээр 2019 онд анхны гэрчилгээг гардан авч байсан бөгөөд 2023 онд нэхмэл бүтээгдэхүүний төрлийг нэмж 3 жилийн хугацаатай сунгуулсан.



Говь ХК-ийн үйлдвэрлэсэн ээрмэл утас нь Швейцарь улсын Цюрих хотод төвтэй OEKO-ТЕКС 100 байгууллагын "STANDARD 100 by OEKO-TEX" стандартын шаардлагыг хангаж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанарын гэрчилгээг 2023 онд 4 дэх удаагаа сунгасан. Энэхүү гэрчилгээ нь хэрэглэгчдэд Говь ХК-ийн үйлдвэрлэсэн ээрмэл утас ямар нэг химийн хортой бодис агуулаагүй бөгөөд хүний эрүүл мэндэд аюулгүй, найдвартай гэдгийг дахин нотлон харуулж байна.




"Органик бүтээгдэхүүн" – Хөдөө аж ахуйн тэнхимээс олгогддог бөгөөд Н-1,02,03,57 зэрэг өнгүүдээр хийсэн сүлжмэл, оёмол нэхмэл бүтээгдэхүүнүүд нь үйлдвэрлэлийн менежмент, чанарын үзүүлэлтүүд нь органик хөдөө аж ахуйн гарагтай бүтээгдэхүүнд тавигдах шалгуурыг хангаж авч байсан бол 2023 онд 1000 өнгийг шинээр нэмж 2 жилээр сунгасан.



Говь ХК-ийн түүхий эдийн агуулах нь Хөдөө аж ахуйн биржийн шалгуур үзүүлэлтүүдийг хангаж АГУУЛАХЫН ИТГЭМЖЛЭЛ-ийг 07/21/2023- 07/21/2026 хүртэл 3 жилийн хугацаатай амжилттай сунгасан.



# ГОВЬ ХК-ИЙН БҮТЭЦ



- Газар - 10
- Хэлтэс - 42
- Үйлдвэр - 5



## КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ГАРСАН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД

Дээд шатны удирдлага:

- Борлуулалт хариуцсан Тэргүүн дэд захирлын ажлын байрыг Гадаад борлуулалт болон Дотоод, экспорт борлуулалт хариуцсан 2 чиг үүргээр тусад нь салгасан.
- Стратеги, өсөлт хөгжил хариуцсан захирлын шууд удирдлагад Гадаад маркетингийн хэлтэс, Контент хөгжүүлэлтийн хэлтэс, Тогтвортой хөгжлийн хэлтсийг шилжүүлсэн.
- Санхүү хариуцсан дэд захирлын шууд удирдлагад Худалдан авалтын хэлтсийг шилжүүлсэн.

Дотоод борлуулалтын газар:

- Дотоод харилцагчийн үйл ажиллагааны хэлтэстэй болсон.

Экспортын борлуулалтын газар:

- Экспортын борлуулалтын хэлтсийг Экспортын борлуулалтын газар болгосон.


Гадаад борлуулалтын газар:

- Гадаад борлуулалтын Хүний нөөцийн хэлтсийг нийт борлуулалт хариуцсан Хүний нөөцийн хэлтэс болгож чиг үүргийг өөрчилсөн.

Хүний нөөцийн газар:

- Шинээр хоол үйлдвэрлэлийн хэлтэстэй болсон.
- Захиргаа аж ахуйн хэлтсийг Хүний нөөцийн газрын харьяанд шилжүүлсэн.

### ГОВЬ ГРУППИЙН БҮТЭЦ



### ГОВЬ ГРУППИЙН БҮТЦЭД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ

2023 оны 8-р сарын 11-ний ТУЗ-ийн хурлын шийдвэрээр Бүгд Найрамдах Казахстан Улсад охин компани байгуулсан.

### ОХИН КОМПАНИ, САЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

№	Охин компанийн нэр	Байршил	Үйл ажиллагааны чиглэл
1	Говь Кашмер Европ ХХК	Герман улс, Шонефелд хот	Худалдаа үйлчилгээ
2	Говь Кашмер Өвөр Монгол ХХК	Хятад улс, Эрээн хот	Худалдаа үйлчилгээ
3	Говь Кашмер Америк ХХК	АНУ, Лос Анжелес	Худалдаа үйлчилгээ
4	Говь Кашмер Их Британи ХХК	Их Британи улс, Лондон хот	Худалдаа үйлчилгээ
5	Говь Кашмер Казахстан ХХК	Казахстан улс, Алматы хот	Худалдаа үйлчилгээ
6	Гоёо Кашмер ХХК	Монгол улс, Улаанбаатар хот	Үйлдвэрлэл, Худалдаа үйлчилгээ
№	Салбарын нэр	Байршил	Үйл ажиллагааны чиглэл
1	Говь Австрали	Австрали улс, Сидней хот	Худалдаа үйлчилгээ



## МЕНЕЖМЕНТ БАГИЙН УДИРДЛАГУУД



**Цагаачийн БААТАРСАЙХАН**  
Гүйцэтгэх захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 17 жил

Говь ХК-ийн хувьцааны эзэмшил: 50,000 ширхэг (0.006%)

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд: 51.73%



**Цогтгэрэлийн ОРГИЛБОЛД**  
Тэргүүн дэд захирал /Гадаад борлуулалт/

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 4 жил

Говь ХК-ийн хувьцааны эзэмшил: Хувьцаа эзэмшдэггүй.

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд: 51.73%



**Гантөмөрийн АНУДАРЬ**  
Экспортын борлуулалт хариуцсан захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 9 жил

Говь ХК-ийн хувьцааны эзэмшил: 800 ширхэг (0.0001%)



**Оюунчимэгийн ЦЭНГЭЛ**  
Дизайн хөгжүүлэлт хариуцсан захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 8 жил

Говь ХК-ийн хувьцааны эзэмшил: 800 ширхэг (0.0001%)



**Батчулууны АРИУНАА**  
Тэргүүн дэд захирал /Дотоод, экспорт борлуулалт/

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 11 жил

Говь ХК-ийн хувьцааны эзэмшил: 1,000 ширхэг (0.0001%)



**Батсүхийн ЭНХМАНДАХ**  
Тэргүүн дэд захирал /Дизайн, үйлдвэрлэл, дэмжих/

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 2 жил

Говь ХК-ийн хувьцааны эзэмшил: Хувьцаа эзэмшдэггүй.



**Дүйхэржавын СОДГЭРЭЛ**  
Санхүү бүртгэл хариуцсан захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 13 жил

Говь ХК-ийн хувьцааны эзэмшил: 800 ширхэг (0.0001%)



**Ариунтулгын УДВАЛ**  
Санхүү удирдлага хариуцсан захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 8 сар

Говь ХК-ийн хувьцааны эзэмшил: Хувьцаа эзэмшдэггүй.



**Баатарсайханы АМАРСАЙХАН**  
Стратеги, өсөлт хөгжил хариуцсан захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 4 жил

Говь ХК-ийн хувьцааны эзэмшил: 1,000 ширхэг (0.0001%)

Нэгдмэл сонирхолтой хуулийн этгээд: 51.73%



**Отгонтөгсийн МИШЭЭЛ**  
Гадаад борлуулалт хариуцсан дэд захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 7 жил

Говь ХК-ийн хувьцааны эзэмшил: 1,000 ширхэг (0.0001%)



**Баяраагийн ЭРДЭНЭ**  
Мэдээлэл технологи хариуцсан захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 4 сар

Говь ХК-ийн хувьцааны эзэмшил: Хувьцаа эзэмшдэггүй.



**Цогтбаярын ЦАСЧИХЭР**  
Хуулийн хэлтсийн дарга

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 10 жил

Говь ХК-ийн хувьцааны эзэмшил: 1,000 ширхэг (0.0001%)



**Батсуурийн БОЛОРМАА**  
Дизайн, үйлдвэрлэл хариуцсан дэд захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 17 жил

Говь ХК-ийн хувьцааны эзэмшил: 1,000 ширхэг (0.0001%)



**Дэмбэрэлнямын СОЁЛМАА**  
Хүний нөөц хариуцсан захирал

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 2 жил

Говь ХК-ийн хувьцааны эзэмшил: Хувьцаа эзэмшдэггүй.



**Мөнхбатын СЭЛЭНГЭ**  
Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 7 жил

Говь ХК-ийн хувьцааны эзэмшил: 500 ширхэг (0.0000%)



**Цэвэлдоржийн УРАНЧИМЭГ**  
Дотоод аудитын хэлтсийн дарга

Говь ХК-д ажиллаж буй хугацаа: 12 жил

Говь ХК-ийн хувьцааны эзэмшил: Хувьцаа эзэмшдэггүй.

## МЕНЕЖМЕНТ БАГИЙН УДИРДЛАГУУДЫН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

### Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал

Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлдэг. Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал нь компанийн санхүү, үйл ажиллагааны үр дүн болон ажлын гүйцэтгэл, ур чадварын үнэлгээтэй уялдсан байх бөгөөд цалин, урамшууллын хэмжээ, түүнийг олгох зарчмыг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо тогтоодог.

Гүйцэтгэх захирлын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон Менежментийн гэрээний нөхцөлийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо боловсруулан, гэрээний агуулгыг ТУЗ-ийн хурлаар баталдаг бөгөөд 2023 оны 8-р сард ТУЗ-өөс Гүйцэтгэх захиралтай Менежментийн гэрээг шинэчлэн байгуулсан.

### Менежмент багийн удирдлагуудын цалин, урамшуулал

Гүйцэтгэх захирлаас бусад Менежмент багийн удирдлагуудын цалин, урамшуулал, түүнийг олгох шалгуур үзүүлэлтийг Цалин, урамшууллын бодлогын хүрээнд нь Гүйцэтгэх захирал тогтоодог. Харин ТУЗ-ийн дэргэдэх нэгжүүд болох ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон Дотоод аудитын хэлтсийн даргын цалинг ТУЗ-ийн дэргэдэх хороодын саналыг үндэслэн ТУЗ тогтоодог.

Менежмент багийн удирдлагууд нь ТУЗ-ийн гишүүний үүргийг давхар гүйцэтгэж байгаа тохиолдолд ТУЗ-ийн гишүүний цалинг авах ба хангамж, урамшууллыг давхар авахгүй байх зарчмыг Цалин урамшууллын хороо тогтоосон.


### Цалингийн бүтэц

Үзүүлэлт	Эзлэх жин
<b>Үндсэн цалин</b>  <b>Гүйцэтгэлээс хамаарсан нэмэгдэл цалин /KPI/</b> <ul style="list-style-type: none"> <li>Компанийн борлуулалт, ашгаас хамаарсан үзүүлэлт</li> <li>Тухайн ажилтны төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлийн үзүүлэлт</li> <li>Хариуцсан газар нэгжийн хүний нөөцийн эргэцийн үзүүлэлт</li> </ul>	Албан тушаалын чиг үүргээс хамаарна.

### Урамшууллын зарчим

Говь ХК-д мөрдөгдөж буй Цалин урамшууллын бодлого, Үр дүнгийн урамшуулал олгох журмын дагуу компанийн санхүү үр дүнгийн гүйцэтгэлээс хамааран тухайн жилийн бизнес төлөвлөгөөний борлуулалтын гүйцэтгэл, цэвэр ашгийн гүйцэтгэлийн тодорхой шалгуурыг хангасан үед урамшууллыг олгодог.

### Гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг дүгнэх үзүүлэлт




Менежмент багийн удирдлагуудын хувьд ажлын байрны чиг үүрэгтэй уялдан ажлын үр дүнг дүгнэх үзүүлэлтийн зорилтыг хэмжих хэмжигдэхүүн болон эзлэх жин өөр өөр байдаг.

### 2023 ОНЫ ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

	2022 он	2023 он	Өөрчлөлт %
Менежмент багийн цалин, урамшуулал			
Цалин	1,282,495	1,755,628	36.9%
Урамшуулал	98,056	56,000	-42.9%
НДШ	186,153	244,329	31.3%
Дүн	1,566,703	2,055,957	31.2%

## КОМПАНИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

Говь ХК-ийн зах зээлийн үнэлгээ 2023.12.31-ний өдрийн хаалтын ханшаар 213,430,978,875 төгрөг байна. Жилийн арилжааны мэдээллийг графикаар үзүүлэв.



### 52 ДОЛОО ХОНОГИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ХАНШ

ҮЗҮҮЛЭЛТ	2022 он	2023 он	Өөрчлөлт %
ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОО /ширхэг/	780,112,500	<b>780,112,500</b>	-
ХУВЬЦААНЫ ҮНЭ /төгрөг/			
Хаалтын үнэ	248.32	<b>273.59</b>	10.2%
Хамгийн их үнэ	311.50	<b>350.00</b>	12.4%
Хамгийн бага үнэ	242.73	<b>240.69</b>	-0.8%
Дундаж үнэ	272.19	<b>263.90</b>	-3.0%
АРИЛЖААЛАГДСАН ТОО /ширхэг/			
Хамгийн их /өдөрт/	1,234,986	<b>7,500,000</b>	507.3%
Хамгийн бага /өдөрт/	392	<b>179</b>	-54.3%
Дундаж /өдөрт/	30,702	<b>62,704</b>	104.2%
Нийт	7,552,604	<b>15,676,081</b>	107.6%
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН /төгрөг/			
Хамгийн их /өдөрт/	336,411,123	<b>2,625,000,000</b>	680.3%
Хамгийн бага /өдөрт/	107,018	<b>52,805</b>	-50.7%
Дундаж /өдөрт/	8,519,435	<b>18,985,172</b>	122.8%
Нийт	2,095,780,903	<b>4,746,292,927</b>	126.5%
ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ /төгрөг/	193,717,536,000	<b>213,430,978,875</b>	10.2%

## НОГДОЛ АШИГ

Манай компани нь дотоодын зах зээлд байр сууриа хадгалах, улмаар зах зээлд эзлэх хувиа өсгөх, гадаад болон онлайн худалдааны зах зээлээ тэлэхийн тулд техник, технологио шинэчлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр чармайн ажиллахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгө оруулалтын өгөөжийг тасралтгүй өсгөж, ногдол ашиг тогтмол тараах бодлогыг баримталдаг.

ТУЗ-өөс 2018 онд баталсан “Ногдол ашгийн журам”-ын 2-р бүлэгт ногдол ашгийн бодлогыг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

### Хоёр. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

- Компанийн ногдол ашгийн бодлого нь Компанийн үйл ажиллагаа болон стратегийн бодлоготой уялдсан байна.
- Компани хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд байлгах бодлоготой ажиллана.
- Компани нь Компанийн тухай хуулийн 47-р зүйл, Компанийн дүрмийн 8.12-д заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангагдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилна.
- Нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тухайн санхүүгийн жилийн татварын дараах цэвэр ашгийн хэмжээ, Компанийн богино болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн ТУЗ тогтооно.
- Тухайн санхүүгийн жилд олсон цэвэр ашиг нь өмнөх жилийнхээс буураагүй тохиолдолд ногдол ашгийн хэмжээг бууруулахгүй байх бодлого баримтална.
- Ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгоно.
- Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.

## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

Ногдол ашиг зарласан он	Хувьцааны тоо /ширхэг/	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг /төгрөг/	Нийт зарласан ногдол ашгийн дүн /төгрөг/	НОГДОЛ АШИГ ТАРААЛТ	
1996	7,801,125	61.00	475,868,625		
1997	7,801,125	153.80	1,199,813,025		
1998	7,801,125	150.00	1,170,168,750		
1999	7,801,125	166.00	1,294,986,750	Говь ХК нь 2007 онд хувьчлагдсан бөгөөд түүнээс өмнөх жилүүдэд зарласан ногдол ашгийг компани дээрээ тарааж байна.	
2000	7,801,125	100.00	780,112,500		
2001	7,801,125	20.16	157,270,680		
2005	7,801,125	60.00	468,067,500		
2006	7,801,125	60.00	468,067,500		
2010	7,801,125	100.00	780,112,500		
2011	7,801,125	100.00	780,112,500	Компани дээрээ тараах болон ҮЦТХТ-өөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх аргыг хослуулан 100% тараасан.	
2012	7,801,125	125.00	975,140,625		
2013	7,801,125	130.00	1,014,146,250		
2014	7,801,125	140.00	1,092,157,500		
2015	7,801,125	140.00	1,092,157,500		
2016	7,801,125	200.00	1,560,225,000		
2017	7,801,125	220.00	1,716,247,500		
2018	780,112,500	6.80	5,304,765,000		
2019	780,112,500	-	-		Санхүүгийн үр дүнгээс шалтгаалан ногдол ашиг хуваарилаагүй.
2020	780,112,500	-	-		
2021	780,112,500	-	-		
2022	780,112,500	-	-		
<b>2023</b>	<b>780,112,500</b>	<b>-</b>	<b>-</b>		

### 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ҮР ДҮНГЭЭС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХГҮЙ ТУХАЙ

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 1-р сарын 26-ны өдрийн №1 тоот тогтоолын дагуу 2023 оны санхүүгийн үр дүн нь компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийг хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.





ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ  
ОХИН КОМПАНИУД

# НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2023 ОНЫ 12-Р САРЫН 31

ГОВЬ ХК БОЛОН ТҮҮНИЙ  
ОХИН КОМПАНИУД

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БОЛОН  
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

## ХАРААТ БУС АУДИТОР

Говь ХК-ийн Эрсдэл аудитын хороо нь хараат бус аудиторт тавигдах хараат бус байдлын болон мэргэшил, ажлын туршлага, бусад шалгуур үзүүлэлтийг тогтоож, уг шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдалд дүгнэлт хийн хараат бус аудиторын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээ, бусад гэрээний нөхцөлийн талаар санал боловсруулан ТУЗ-өөр шийдвэрлүүлэн батлуулдаг. Мөн хараат бус аудитын үйл ажиллагаанд нь хяналт тавихаас гадна удирдлагад өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтэд хяналт тавьж чиглүүлэн ажилладаг.

Говь ХК-ийн 2023 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн тайланд Кэй Пи Эм Жи Аудит ХХК хөндлөнгийн аудит хийсэн. Гэрээний дүн 81,000 ам.доллар буюу 280,328,040 төгрөг.

Кэй Пи Эм Жи Аудит ХХК нь олон улсын 4 том аудитын компанийн нэг бөгөөд 2013 онд Санхүүгийн зохицуулах хороонд Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх Аудитын компаниар бүртгэгдсэн.

## АГУУЛГА

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	1
Нэгтгэсэн иж бүрэн орлогын тайлан	2
Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	3
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	4
Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд	5

2023 ОНЫ 12-Р САРЫН 31

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга	Д.Гэрэлмаа
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд	Ц.Баатарсайхан Д.Хулан Б.Амарсайхан Ц.Оргилболд Хидэо Савада
Хараат бус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд	Такэши Камбэ Д.Хүрэлбаатар А.Жаргалмаа
Нарийн бичгийн дарга	М.Сэлэнгэ
Харилцагч банкууд	Хаан Банк Голомт Банк Хас Банк Худалдаа Хөгжлийн банк Ариг Банк Америкийн Банк Корпораци Дойче Банк Эй Жи Хятадын Бүтээн Байгуулалтын Банк Корпораци
Албан хаягууд	Говь үйлдвэрийн байр, үйлдвэрийн гудамж Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо Улаанбаатар-17062, Монгол улс
Хараат бус аудитор	КЭЙ ПИ ЭМ ЖИ АУДИТ ХХК Монгол улс, Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Энхтайваны өргөн чөлөө 17, Блю Скай Тауэр, 602 тоот

### Гүйцэтгэх Удирдлагын Мэдэгдэл

Говь ХК-ийн удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх, тайлагнах үүрэгтэй.

Говь ХК болон түүний охин компаниуд (шашид хамтад нь "Групп" гэх)-ын нэгтгэсэн санхүүгийн тайлан нь СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэгдсэн. Группийн удирдлага нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлан нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Группийн удирдлага нь Группийн санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөв илэрхийлж чадах, санхүүгийн тайлангууд нь тодруулга 2-оос 4-т дурдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн удирдлага нь Группийн эд хөрөнгийг хадгалан замгаалах, аливаа залуан ашиглан, зүй бус үйлдэлээ сэргийлэх, нийм үйлдэл гарвал илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Группийн удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгож, тууштайгаар хэрэглэж, үндэслэлтэй, нягт нямбай тосцоолол, үнэлэмж хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг удирдлага шийдвэрийн дагуу зөвшөөрч батлав.



Д.Содгэрэл  
Санхүү Бүртгэл/Хариуцсан Захирал

Улаанбаатар хот,  
Монгол Улс

Онгоо: 2024 оны 3 дугаар сарын 21-ний өдөр





Кэй Пи Эм Жи Аудит ХХК  
 Монгол Улс, Улаанбаатар-14240,  
 Сүхбаатар дүүрэг, 1 дугаар хороо,  
 Энхтайвны өрлөг чөлөө 17,  
 Било Скай Тауэр, 602 тоот

Утас : +976 7011 8101  
 Факс : +976 7011 8102  
 www.kpmg.com/mn

### Хараат Бус Аудиторын Тайлан

Говь Хувьцаат Компанийн Хувьцаа Эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

#### Дүгнэлт

Бид Говь ХК (цаашид "Толгой Компани" гэх) болон түүний охин компаниуд (цаашид хамтад нь "Групп" гэх)-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд ба бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан тодруулгуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд зүдит хийлээ.

Бидний дүгнэлтээр, энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Группийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд (цаашид "СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд" гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага* хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (цаашид "НБЕЗОУС3-ийн Ёс зүйн Дүрэм" гэх) болон нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Группээс хараат бус байж, НБЕЗОУС3-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

#### Аудитын Гол Онцлох Зүйлс

Аудитын гол онцлох зүйлс гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал ач холбогдол бүхий зүйлс юм. Бид нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр аудитын гол онцлох зүйлсийг бүхэлд нь авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад түс бүрчлэн тусдаа дүгнэлт гараагүй болно.

Кэй Пи Эм Жи Аудит ХХК нь Монгол Улсын өмгөөлөгчид хариуцлагатай компани бөгөөд бэлтгэгчээр өмгөөлөгчид Аудит Үйлчилгээний компани болон KPMG International Limited-д харьяалагдах бие даасан гэрээг байгуулсан гэрээтэй KPMG-ийн олон улсын байгууллагад багтаж өгч, Бүт эрх мөхөөр хариуцдаг.



### Аудитын Гол Онцлох Зүйлс, Үргэлжлэл

#### Борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлт

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Тодруулга 25.1, мөн Тодруулга 2.12-т тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгуудыг харна үү.

Гол онцлох зүйлс	Тэдгээрийг шийдвэрлэсэн аудитын арга хэмжээ
Аудитын Олон Улсын Стандартад борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой залилангийн эрсдэл аливаа байгууллагад зайлшгүй байдаг гэж үздэг. Бид борлуулалтын орлого бодитоор үүссэн эсэхэд уг эрсдэлийг авч үзсэн ба уг эрсдэлийг удирдлагад үүсч буй төлөвлөсөн санхүүгийн үр дүнд хүрэх шахалтаас үүдэлтэй байж болно гэж тодорхойлсон.	Борлуулалтын орлогын хувьд гүйцэтгэсэн аудитын горимүүд:  - Бид удирдлагын зүгээс борлуулалт болон борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөх үйл явцад хэрэгжүүлж буй хяналтууд, тэр дундаа борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийн оршин байх, үнэн зөв байх болон цаг хугацаанд нь бүртгэх зэрэг хяналтуудыг шалгасан.  - Бид Группийн хэрэгжүүлсэн борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөх бодлогыг удирдлагатай ярилцлага хийх, борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрч буй цаг хугацааг холбогдох стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг борлуулалтын гэрээнүүдээс түүвэр байдлаар сонгон ажил гүйлгээний хүргэлтийн нөхцөлүүдийг ойлгох үүднээс нягтлан шалгасан.  - Борлуулалтын орлогыг зохих санхүүгийн жилд борлуулалтын гэрээний нөхцөлийн дагуу хүлээн зөвшөөрсөн эсэхийг шалгах үүднээс жилийн дуусгавар болох хугацааны үед хийгдсэн борлуулалтын ажил гүйлгээнүүдээс түүвэрээр сонгон авч бараа материалын зарлагыг илэрхийлэх баримтууд, борлуулсан бараа материалын хүргэлтийг худалдан авагч талаас хүлээн зөвшөөрсөн холбогдох баримт бичгүүдтэй тулган шалгасан.  - Бид Группийн борлуулалтын тоо хэмжээ болон үнийн мэдээлэлд үндэслэн борлуулалтын орлогыг дахин тооцоолж үзсэн.  - Бид Групп болон түүний худалдан авагч нарын хооронд хийгдсэн борлуулалтын ажил гүйлгээнд тулган баталгаажуулалт хийх гэх мэт аудитын горимтуудыг хэрэгжүүлсэн.  - Бид тайлант жилийн дараа үед хийгдсэн борлуулалтын буцаалтууд болон худалдан авагч нь бодитой байсан эсэхийг шалгасан.  - Бид орлого хүлээн зөвшөөрөх ердийн үйл явцаас гадуур борлуулалтын орлогын журналын бичилтүүд хийгдсэн эсэхийг шалгасан.
Дээрх зүйлстэй холбоотойгоор бид борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн гол онцлох зүйл гэж авч үзсэн.	



#### Бусад Мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээх юм. Бусад мэдээлэл гэдэгт жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба нэгтгэсэн санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлан үүнд хамаарахгүй болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Бусад мэдээлэлтэй уншиж танилцан, уг мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад олж авсан бидний ойлголттой материаллаг хэмжээгээр нийцэхгүй эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн зүйлс байгаа эсэхийг шалгах нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг, хариуцлага юм. Хийж гүйцэтгэсэн ажлын хүрээнд бусад мэдээлэлд аливаа материаллаг буруу илэрхийлэл байна гэж үзвэл бид энэ талаар тайлагнах үүрэгтэй. Бусад мэдээлэлтэй холбоотойгоор бидэнд тайлагнах зүйлс байгаагүй.

#### Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Эггээдүүдийн Нэгтгэсэн Санхүүгийн Тайланд Хүлээх Үүрэг Хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайланг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Алдаа, залыт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх үүрэг хариуцлагыг мөн удирдлага хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Группийн тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тодруулж, Группийг татан буулгах юм үү үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг Группийн удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий эггээдүүд нь Группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.



#### Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Бүрүү илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ уг нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх үед мэргэжлийн үнэлэмж гаргах, мэргэжлийн үл итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг.
- Группийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн бид олж авсан нотолгоондос тулгуурлан Группийн тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бүс байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бүс байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Группийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, нэгтгэсэн санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.
- Нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилгоор Групп дэх компаниудын санхүүгийн мэдээлэл болон бизнесийн үйл ажиллагааны талаар аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Бид Группийн аудитыг гүйцэтгэх, хянах, удирдах үүрэгтэй. Бид зөвхөн өөрсдийн аудитын дүгнэлтэнд хариуцлага хүлээнэ.



**Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага, Үргэлжлэл**

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Мөн бид засаглах эрх бүхий этгээдүүдэд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагыг биелүүлсэн талаарх мэдэгдлийг хийдэг бөгөөд шаардлагатай үед бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц бүхий л харилцаа болон бусад асуудлууд, хараат бус байдлын эрсдэлийг бүүруулсан эсвэл түүний эсрэг авсан хамгаалалтын хариу үйлдлүүдийн талаарх мэдэгдлийг хийдэг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас бид тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдолтой гэж үзсэн зүйлсийг аудитын гол онцлох зүйлс хэмээн тодотгосон болно. Бид аудитын гол онцлох зүйлсийг хууль тогтоомжоор нийтэд ил болгохыг хориглоогүй үед эсвэл маш ховор тохиолдолд тайланд тодруулахгүй байх нь тодруулснаас илүүтэйгээр олон нийтийн эрх ашигт нийцнэ гэж үзсэнээс үг онцлох зүйлсийг тайланд оруулахгүй хэмээн шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд эдгээр зүйлсийг тайландаа оруулдаг.

Энэхүү хараат бус аудитын тайлангийн аудитын гэрээт ажлын партнер нь Гун Пён Шиг, аудитын компанийн Ерөнхий Захирал нь Г. Соёлмаа нар болно.



Кэй Пи Эм Жи Аудит ХХК  
Монгол Улс, Улаанбаатар хот  
2024 оны 3 дугаар сарын 21-ний өдөр

Баталгаажуулсан:

Г. Соёлмаа  
Ерөнхий Захирал

Баталсан:

Гун Пён Шиг  
Партнер

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2024 оны 3 дугаар сарын 21-ний өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг нэгтгэсэн санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Тиймээс аудитын тайланг хэрэглэгчид нь уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна үү. Энэхүү тайлан нь зөвхөн Группийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД  
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ  
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Тодруулга	2023	2022
<b>Хөрөнгө</b>			
<i>Эргэлтийн хөрөнгө</i>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5	9,491,111	9,034,919
Урьдчилгаа төлбөр	7	3,173,680	2,318,495
Дансны болон бусад авлага	6	8,030,908	3,318,986
Бараа материал	8	142,521,277	128,791,463
Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө	9	-	17,227
		<b>163,216,976</b>	<b>143,481,090</b>
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>			
Үндсэн хөрөнгө	10	129,249,293	137,432,575
Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	11	2,109,746	731,724
Хойшлогдсон татварын хөрөнгө	24.3	9,276,559	14,879,483
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	13	7,930,958	1,587,295
		<b>148,566,556</b>	<b>154,631,077</b>
<b>Нийт хөрөнгө</b>		<b>311,783,532</b>	<b>298,112,167</b>
<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>			
<i>Богино хугацаат өр төлбөр</i>			
Дансны болон бусад өглөг	14	38,880,126	20,969,192
Гэрээний өр төлбөр	14.1	1,672,424	1,983,898
Буцаах эрхтэй барааны өр төлбөр	15	-	26,503
Богино хугацаат түрээсийн өглөг	16	964,376	777,988
Орлогын албан татварын өглөг	24.2	1,801,506	3,683,126
Богино хугацаат зээл	17	232,559,514	129,853,617
		<b>275,877,946</b>	<b>157,294,324</b>
<i>Урт хугацаат өр төлбөр</i>			
Урт хугацаат түрээсийн өглөг	16	1,321,948	112,069
Урт хугацаат зээл	17	9,830,059	95,686,234
Бусад урт хугацаат өглөг	18	17,036,260	30,984,941
Хойшлогдсон татварын өглөг	24.3	7,883,775	8,206,834
		<b>36,072,042</b>	<b>134,990,078</b>
<b>Нийт өр төлбөр</b>		<b>311,949,988</b>	<b>292,284,402</b>
<b>Эздийн өмч</b>			
Хувьцаат капитал	19	780,113	780,113
Дахин үнэлгээний нөөц	22	44,568,540	44,568,540
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	23	(10,662,273)	(11,436,010)
Хуримтлагдсан алдагдал		(34,852,836)	(28,084,878)
		<b>(166,456)</b>	<b>5,827,765</b>
<b>Нийт эздийн өмч</b>		<b>(166,456)</b>	<b>5,827,765</b>
<b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>		<b>311,783,532</b>	<b>298,112,167</b>

*Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын саллигүй хэсэг болно.*

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД  
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
НЭГТГЭСЭН АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Тодруулга	2023	2022
Борлуулалтын орлого	25.1	255,650,516	193,427,609
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	25.2	(131,011,345)	(97,766,831)
<b>Нийт ашиг</b>		<b>124,639,171</b>	<b>95,660,778</b>
Бусад орлого	27.1	5,002,286	1,162,425
Борлуулалт ба түгээлтийн зардал	25.4	(73,593,361)	(61,767,484)
Ерөнхий ба удирдлагын зардал	25.5	(19,733,240)	(14,138,399)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт	31.1	9,266	49,464
Бусад зардал	27.2	(6,980)	(13,355)
<b>Үйл ажиллагааны ашиг</b>		<b>36,317,142</b>	<b>20,953,429</b>
Санхүүгийн орлого	26	229,734	29,261
Санхүүгийн зардал	28	(36,523,753)	(30,979,282)
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>23,123</b>	<b>(9,996,592)</b>
Орлогын албан татварын (зардал) өгөөж	24	(6,791,081)	2,998,982
<b>Тайлант жилийн цэвэр алдагдал</b>		<b>(6,767,958)</b>	<b>(6,997,610)</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого:</b>			
<b>Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжтой бусад дэлгэрэнгүй орлого:</b>			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөлөө	22	-	(4,301,861)
<b>Ашиг, алдагдал руу дараа үед дахин ангилагдах боломжгүй бусад дэлгэрэнгүй орлого:</b>			
Гадаад дахь охин компаниудын цэвэр хөрөнгийн гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн зөрүү	23	773,737	(11,997,888)
<b>Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого</b>		<b>773,737</b>	<b>(16,299,749)</b>
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал</b>		<b>(5,994,221)</b>	<b>(23,297,359)</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр)</b>	21	<b>(9)</b>	<b>(9)</b>

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын саллигүй хэсэг болно.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД  
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Тодруулга	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нооц	Гадаад валютын хөрвүүлэлтийн нооц		Хуримтлагдсан алдагдал	Нийт
<b>2022 оны 01 сарын 01-ний үлдэгдэл</b>		<b>780,113</b>	<b>48,870,401</b>	<b>561,878</b>	<b>(21,087,268)</b>		<b>29,125,124</b>
<i>Нийт дэлгэрэнгүй орлого:</i>							
Тайлант жилийн цэвэр алдагдал		-	-	-	(6,997,610)		(6,997,610)
Бусад дэлгэрэнгүй алдагдал	22, 23	-	(4,301,861)	(11,997,888)	-		(16,299,749)
<b>2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>		<b>780,113</b>	<b>44,568,540</b>	<b>(11,436,010)</b>	<b>(28,084,878)</b>		<b>5,827,765</b>
<b>2023 оны 01 сарын 01-ний үлдэгдэл</b>		<b>780,113</b>	<b>44,568,540</b>	<b>(11,436,010)</b>	<b>(28,084,878)</b>		<b>5,827,765</b>
<i>Нийт дэлгэрэнгүй орлого:</i>							
Тайлант жилийн цэвэр алдагдал		-	-	-	(6,767,958)		(6,767,958)
Бусад дэлгэрэнгүй орлого	23	-	-	773,737	-		773,737
<b>2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>		<b>780,113</b>	<b>44,568,540</b>	<b>(10,662,273)</b>	<b>(34,852,836)</b>		<b>(166,456)</b>

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын саллигүй хэсэг болно.

**ГОВЬ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД  
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН  
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН  
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Тодруулга	2023	2022
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Тайлант жилийн цэвэр алдагдал</b>			
Тохируулгууд:			
		(6,767,958)	(6,997,610)
Эргэлтийн бус хөрөнгийн элэгдэл ба хорогдлын зардал	25.3	12,643,029	11,872,940
Орлогын албан татварын зардал (өгөөж)	24	6,791,081	(2,998,982)
Хүүгийн зардал	28	30,257,198	25,600,326
Хүүгийн орлого	26	(229,734)	(29,261)
Хөнгөлөлттэй зээлийн дискаунтын нөлөө	28	4,418,776	-
